



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.01.08 № 3Г-1/08  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

□ □

Тогтоолын төсөл  
өргөн мэдүүлэх тухай

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.01.08 № 1187/58  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг  
батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар  
хэлэлцэн шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлд:

“1.ХЭЛЭЛЦСЭН нь: “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

**2025.01.08** № **011110**

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,  
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД  
Ж.БАТСУУРЬ ТАНАА**

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

**Б.ЖАВХЛАН**

**9761000021**



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.01.08 № 1/75  
танай \_\_\_\_\_-ны № 01/92 -т

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,  
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
САЙД Ж.БАТСУУРЬ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийг үндэслэн “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151600072  
А5.файл.2025



**“НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ” ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичиг бөгөөд Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Их Хурал батлахаар заасан.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод төрийн дээд байгууллагууд байнга оршдог, улсын нийт хүн амын тал хувь нь ажиллаж амьдардаг бөгөөд их дээд сургууль, коллеж болон бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ зэрэг үзүүлэлт жил бүр өссөөр байгаа, нөгөө талдаа хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллахад сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлүүд бий болж байгааг харгалзан нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой дараахи хууль тогтоомжууд батлагдан, мөрдөгдөж байна. Үүнд:

- “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”<sup>1</sup>-ын 3.4.3.2-т “Нийслэлийн хүн амын төвлөрлийг тархаан байршуулах зорилгоор дагуул хотуудыг төлөвлөж, бүс нутгийг өндөр хурдны авто зам, эрчим хүч, инженерийн барилга байгууламжаар хангаж холбоно.”;

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн<sup>2</sup> 9.3.1-д “Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.”, 9.3.46-д “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ.”, 9.5.5-д “Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.” гэж тус тус заасан;

<sup>1</sup> Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан;

<sup>2</sup> Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан.

- 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-иар нийслэлийн дагуул хот, тусгай бүсийг байгуулж, хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн;

- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”<sup>3</sup>-ийн зорилго 9-д “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.”, 9.2.1-д “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна”, 9.3.2-т “Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ”, 9.5.3-т “Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлнэ.”;

- 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулиудаар нийслэл дэх хотууд болон нийслэлээс бусад засаг захиргааны нэгж дэх нийслэлийн дагуул хотын эрх зүйн байдал, удирдлага зохион байгуулалт, хотуудыг байгуулах, 20 минутын хотын концепцоор хөгжүүлэх асуудлыг зохицуулсан.

Мөн түүнчлэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”<sup>4</sup>-г “20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-г боловсруулж, батлуулна.” гэж заасныг үндэслэл болгоно.

## 1.2. Практик шаардлага

Улаанбаатар хотын анхны шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 1954 онд баталж, 1961, 1976, 1986 онуудад тодотгол, шинэчлэл хийгдэж байсан ба манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж, 2002 онд “Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”<sup>5</sup>, 2013 онд “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг<sup>6</sup> батлан хэрэгжүүлж ирсэн.

Нийслэл хотын нутаг дэвсгэр манай улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад харгалзан үзэх нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийг 2024 оны 2 сарын байдлаар авч үзвэл<sup>7</sup>:

- Улаанбаатар хотын 4, 5 дахь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж байсан цаг хугацаанд болон одоогийн байдлаар нийслэл хотын нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн амын тоог харьцуулан үзвэл тогтмол өсөж байна.

<sup>3</sup> Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан;

<sup>4</sup> Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан;

<sup>5</sup> Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолоор баталсан;

<sup>6</sup> Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан;

<sup>7</sup> Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл;

Нийслэл	1963	2002	2013	2024.03.25	2040 <sup>8</sup>
Нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүний тоо /хүн/ <sup>9</sup>	47.1	185.4	291.9	369.1	444.6
Өсөлтийн хувь /өмнөх оны үзүүлэлттэй харьцуулсан хувь/	-	293.6	57.4	26.4	20.4

- Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 175,200 буюу манай улсад бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 74.7 хувьтай тэнцэж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага /улсын нэгдсэн тооллого явагдсан оноор<sup>10</sup>/

он	Нийт	Байгууллагын төрөл		
		Аж ахуйн нэгж	Төрийн	Төрийн бус
1998	18950	14040	3835	1075
2006	32410	26841	3398	2171
2011	65204	55366	3959	5879
2016	118686	101463	4372	12851
2021	180006	151577	4597	23852
Өсөлтийн хувь /2021 оны тооллогын дүнг өмнөх тооллогын дүнтэй харьцуулсан хувь/		49.4%	5.1%	85.6%

2021 онд хийгдсэн ААНБ-ын улсын тооллогоор нийт 180.0 мянган ААНБ бүртгэгдсэнээс 130.0 мянга нь Улаанбаатар хотод байрлаж, 2016 оны тооллогын дүнгээс 52.4 хувиар нэмэгдсэн бол 2024 оны хагас жилийн байдлаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 175,200-д хүрч, 2016 оноос хойш 34.7 хувиар өссөн байна.

- 2023 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 46.8 их наяд төгрөг буюу үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний 66.5 хувьтай тэнцэж байна.

Ийнхүү нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр хот байгуулалт, төлөвлөлт нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж, замын хөдөлгөөний түгжрэл, агаар хөрсний бохирдол, дэд бүтцийн дутагдал зэрэг нь нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учруулж, иргэдийн ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах эрх зөрчигдөж байна. Тухайлбал:

- Хотын төвд төр, захиргааны байгууллага, их дээд сургууль, худалдаа үйлчилгээ, оффисын болон орон сууцны барилгажилт төвлөрч нэг төвт хотын тогтолцоо бүрдэж, "Их тойруу"-руу хоногт дунджаар 440 мянга орчим авто машины хөдөлгөөн бүртгэгдсэн;

- Инженерийн дэд бүтцийн хангамж хүртээмжийг дагаж, орон сууц, олон нийтийн барилга байгууламж хотын төв хэсэгт төвлөрч, нягтарсан нь хүн амын зорчих урсгалыг хотын заххаас төв рүү чиглүүлж, авто замын түгжрэл үүсгэх нэгэн шалтгаан болж байна;

<sup>8</sup> Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайланд;

<sup>9</sup> Үндэсний статистикийн хороо, Хүн амын нягтрал, [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#);

<sup>10</sup> Үндэсний статистикийн хороо, [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#)

- "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04"-ийн 2.14-т заасан хүн амын тооцоот нягтрал 1 га газарт 450 байх хязгаарыг давсан нийслэлийн 6 дүүргийн 111 байршлын 1044 га газарт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбай барихаас бусад зориулалтаар, шинээр газар эзэмших, ашиглах эрх, барилга байгууламж барих зөвшөөрөл олгохгүй байх зэрэг шийдвэрийг нутгийн захиргааны байгууллагын түвшинд гаргасан боловч үр дүн муутай байгаа нь хотжилтын чиг хандлагад тулгуурлан хөгжлийн бодлогоо урт хугацаагаар төлөвлөж тулгамдсан асуудлаа шийдвэрлэх практик шаардлага урган гарч байна.

Мөн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, байнгын болон нөлөөллийн мониторинг үнэлгээ хийх тогтолцоо байхгүй байгаа нь батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04 зөрчигдөх бас нэгэн шалтгаан болж байна.

"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичигт Улаанбаатар хот нийт 15 дагуул хот, тосгонтой байхаар төлөвлөсөн боловч тэдгээрийг хэрхэн байгуулах, бүтэц зохион байгуулалт нь ямар байх талаар зохицуулалтгүйгээс тодорхой үр дүнд хүрээгүй тул Улсын Их Хурал 2021 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2023 онд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, 2024 онд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга), Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг тус тус баталсан нь нийслэл хотын төвлөрлийг сааруулах, нэг төвт хотоос олон төвт хот болох төлөвлөлтийн зарчмын дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлах, түүнийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бүрдүүлээд байна.

Тухайлбал нийслэл Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгож, 20 минутын дотор төрийн болон бусад үйлчилгээ авах боломжтой хот, тосгон байгуулах хэрэгцээ шаардлагыг үндэслэн Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор Нийслэлийн нутаг дэвсгэрт улсын зэрэглэлтэй Багануур хот, Налайх хот, орон нутгийн зэрэглэлтэй Хан-Уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-эх, Баянзүрх, Амгалан хот, нийслэлийн дагуул Багахангай хот, Агросити хот, Шарга морьт хотыг, Улсын Их Хурлын 2024 оны 76 дугаар тогтоолоор Төв аймгийн нутаг дэвсгэрт "Шинэ Зуунмод хот"-ыг, Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт Агросити, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийг тус тус байгуулсан.

Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлэх"<sup>11</sup> зорилтын хүрээнд "Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл"<sup>12</sup>-ийн нэг томоохон арга хэмжээ болох "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичиг, түүнд суурилсан "Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040" болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах<sup>13</sup>, оргил ачааллын горимд ажиллах хийн дулааны станцууд болон дэд төвүүдийн дулааны станцуудыг үе шаттайгаар барих<sup>14</sup>, бие даасан эдийн засаг бүхий

<sup>11</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Нэг. Бүс нутгийн хөгжлийн бодлого;

<sup>12</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1;

<sup>13</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.1;

<sup>14</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.1;

улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотуудыг хөгжүүлэх<sup>15</sup> талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгагдсан. Тухайлбал:

- Шинэ Зуунмод хотод нийслэл дэх төрийн байгууллагуудыг шилжүүлэн байршуулж, олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, аялал жуулчлалын цогцолбор, ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, их сургуулийн хотхон бүхий аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлнэ<sup>16</sup>;

- Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгах<sup>17</sup>;

- Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна<sup>18</sup> гэх мэт.

Мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгагдсан нь Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заавал тусгах шаардлагатай асуудлууд болно. Үүнд:

- Хотын төв дэх төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, "Өөдөө тэмүүлэх Монгол" буюу "Go Mongolia" ган татлагат гүүрийн төсөл, Хөшигийн хөндийн туннелийн төслийг хэрэгжүүлэх, олон улсын чанартай Шинэ тойрог зам, Туулын хурдны авто зам, "Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1", "Дүүжин тээвэр шугам-1" зэрэг олон төрөлт нийтийн тээврийн сүлжээ байгуулах, явган болон дугуйтай зорчигчдод ээлтэй дэд бүтцийг бий болгож автомашины хэрэглээг болон бохирдлын хэмжээг 2 дахин бууруулах;

- Монгол улс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд ихээр өртөж байгаа орнуудын нэгд зүй ёсоор орж байгаа бөгөөд энэ нь цөлжилт, хөрсний доройтол, усны хомсдол, дулааны улиралд орох хур тунадасны хэмжээ буурах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрс тэс үзэгдлийн тоо хэмжээ нэмэгдэх зэргээр илэрч байгаа тул "Туул усан цогцолбор төсөл"-ийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, ундны ус, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх, Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн голын эргийн хамгаалалтын далан болон ус зайлуулах сувгийг шинээр барьж, усан сан, хөв, цөөрөм байгуулах, инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

- нийтийн эзэмшлийн газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барьж, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах нөхцөлийг бүрдүүлэх гэх мэт болно.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" зэрэг урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн зохицуулалт, хэрэгжилттэй уялуулах нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний нэг онцлох чиг үүрэг, хэрэгцээ шаардлага болж байна.

<sup>15</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2;

<sup>16</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.1;

<sup>17</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.3;

<sup>18</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.3.1;

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагад нийцүүлэн иргэний эрүүл, аюулгүй, амьдралын таатай орчин бүрдүүлсэн, олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан, сайн засаглал бүхий эдийн засаг, бизнес, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх боломжтой байдлаар “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

### **Хоёр.Тогтоолын төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь дор дурдсан агуулга бүхий 3 заалттай байна:

1. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хавсралтаар батлах;

2. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлэх дор дурдсан арга хэмжээг тодорхойлж тусгах:

- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 2 дугаар улиралд багтаан баталж, арга хэмжээг улсын болон нийслэлийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

- Хэрэгжилтийн явцад таван жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн төслийг боловсруулах, эрх бүхий байгууллагад өргөн барих ажлыг зохион байгуулах.

3.“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох зэрэг болно.

### **Гурав.Тогтоолын төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын болон нийслэл Улаанбаатар хотын нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дагавар гарна. Үүнд:

- Нийслэл болон нийслэлийн нутаг дэвсгэр дэх бусад хотууд, дагуул хотуудыг “20 минутын хот” үзэл баримтлалаар төлөвлөн, хүн амын суурьшил, хот байгуулалтын оновчтой бодлогоор хөгжүүлж, иргэдийг оршин суугаа газартаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, сэргээгдэх эрчим хүч, ухаалаг технологийг хэрэглээнд нэвтрүүлсэн, орчны бохирдолгүй, уур амьсгалын өөрчлөлт, сорилтыг даван туулах, дасан зохицох чадвартай, хэмнэлттэй, ухаалаг хот болгон хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлнэ.

- Нийслэл дэх хот, тосгоны эдэлбэр газрын хэмжээ, зааг, бүсчлэлийг тогтоосноор хотжих боломжтой нутаг дэвсгэрийн газар ашиглалт сайжирч, хяналттай, төлөвлөлттэй суурьшил үүснэ.

- Гэр хорооллын байршил, инженерийн дэд бүтцийн сүлжээ, сууцны төрөл зэргээс шалтгаалан төвийн бүс нь төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбогдсон өндөр болон дунд давхрын орон сууцны хороолол, дундын бүс нь хэсэгчилсэн инженерийн дэд бүтцэд холбогдсон нам болон дунд давхрын орон сууцны хороолол, захын бүс нь бие даасан инженерийн дэд бүтэц бүхий сайжруулсан амины орон сууцны хороолол болон хөгжинө.

- Байгаль орчны тэнцвэрт байдлыг хамгаалж, агаар орчны бохирдлыг бууруулна. Тухайлбал, барилгажсан болон гэр хорооллын хэсэг, дэд төвүүдэд хотын болон дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр байгуулснаар нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 5 м<sup>2</sup>-аас 35 м<sup>2</sup> болгон нэмэгдүүлж иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх тохилог орчин бүрдэнэ.

- Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулна. Тухайлбал, метро, LRT зэрэг их багтаамжтай нийтийн тээврийн сүлжээг бий болгож өдөрт 1.2 сая зорчигч тээвэрлэж нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлнэ. Мөн 1738.8 км замыг шинээр байгуулж, оргил цагийн хөдөлгөөний дундаж хурд 9 км/цаг-аас 22.5 км/цаг болж нэмэгдэнэ.

- Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөөг хянах, мониторингийн тогтолцоо бүрдэнэ.

- Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд төр хувийн хэвшлийн түншлэлийг түлхүү ашиглах, хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ. Тухайлбал Туул, Сэлбэ, Улиастай, Баянгол, Тахилт, Толгойт голуудын хөндийг цэцэрлэгжүүлэн ногоон байгууламжийн коридорыг үүсгэх, тэдгээрийг хот, дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэнтэй холбож хотын ногоон дэд бүтцийг үүсгэх үйл ажиллагааг иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлж, дэмжих, урамшуулах тогтолцоо бий болно.

**Дөрөв.Тогтоолын төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль, тогтоомжийн талаарх санал**

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хууль тогтоомжийн төслийг боловсруулах, эрх бүхий байгууллагад өргөн барих ажлыг зохион байгуулах талаар Засгийн газарт чиглэл өгөхөөр тусгана.

---o0o---

**“НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ  
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Хот байгуулалтын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г Улсын Их Хурал батлахаар хуульчилсны дагуу “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулсан.

Улаанбаатар хотын анхны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 1954 онд батлагдаж, 1961, 1976, 1986 онуудад тодотгол, шинэчлэл хийгдэж байсан ба манай Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсонтой уялдуулан Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлан, Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг батлан хэрэгжүүлсэн.

1990-ээд оноос Нийслэл рүү шилжих хөдөлгөөн эрчимжиж 2024 оны хагас жилийн байдлаар байнга оршин суугчдын тоо 1,730,263 буюу нийт хүн амын 49,0%, үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 175,200 буюу нийт аж ахуйн нэгжийн 74.0%, нийслэлийн ДНБ-ийн хэмжээ 43.3 их наяд төгрөг буюу үндэсний ДНБ-ний 63,0 хувьтай тэнцэж байна.

Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, агаар, хөрс бохирдох, хог хаягдал, дуу чимээ нэмэгдэж, улмаар иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах эрх зөрчигдөхөд хүрч Улаанбаатар хотын ХЕТ-г шинэчилж, хот төлөвлөлтийн шинэ орчин бүрдүүлж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9.3.1-т “Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.” “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Зорилго 9-д “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.” гэсэн зорилго, зорилтуудыг дэвшүүлсэн.

Мөн сүүлийн жилүүдэд батлагдсан Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулиуд нь Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бүрдүүлээд байна.

Эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан<sup>1</sup> “20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040” болон бусад хот, суурин газрын хөгжлийн

<sup>1</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1;

ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах<sup>2</sup>, оргил ачааллын горимд ажиллах хийн дулааны станцууд болон хотын дэд төвүүдийн дулааны станцуудыг үе шаттайгаар барих<sup>3</sup>, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотуудыг хөгжүүлэх<sup>4</sup> талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Тухайлбал, нийслэлийн дагуул хот Шинэ Зуунмод хотод төрийн байгууллагуудыг үе шаттайгаар нүүлгэн шилжүүлж, олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, аялал жуулчлалын цогцолбор, ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, их сургуулийн хотхон бүхий аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлнэ<sup>5</sup>, Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгах<sup>6</sup>, Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна<sup>7</sup> гэх мэт.

Улаанбаатар хотын цаашдын хөгжлийн үзэл баримтлал /концепц/, чиглэлийг тодорхойлох ажлын хүрээнд Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/ боловсруулах нээлттэй уралдаан, олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, ирүүлсэн шинэлэг санаа, шийдлүүдэд үндэслэн үзэл баримтлал /концепц/-ыг боловсруулсан бөгөөд үзэл баримтлалыг Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, тус үзэл баримтлалын дагуу “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичгийг боловсруулахыг даалгасан<sup>8</sup>.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Хүн ам нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн төсөл, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөл зэрэг урт хугацааны бодлогын баримт бичгийн үзэл санаа, зохицуулалттай уялдуулах, олон нийтээр хэлэлцүүлэх, тэдний саналыг авах ажлыг зохион байгуулсан.

Д/д	Оролцогчид
1	Мэргэжлийн байгууллага, холбоод, төрийн бус байгууллага, багш, эрдэмтэн, судлаачид.
2	Төрийн захиргааны төв байгууллагууд, тэдгээрийн харьяа газрын удирдлага, албан хаагчид.
3	9 дүүрэг, 172 хороодын Засаг дарга, албан хаагчид.
4	Нийслэлийн өмчит болон инженерийн дэд бүтцийн хангагч нийт 45 байгууллагын албан хаагчид.
5	Монголын Архитекторуудын Эвлэлийн болон Хот төлөвлөлт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн хурлын гишүүд
6	ЗГХЭГ болон Шадар сайдын ажлын албаны дарга, албан хаагчид.
7	Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүд, ААНБ-ын төлөөлөл.
8	НИТХ-ын төлөөлөгчид

<sup>2</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.1;

<sup>3</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.1;

<sup>4</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2;

<sup>5</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.1;

<sup>6</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.3;

<sup>7</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.3.1;

<sup>8</sup> Засгийн газрын 2020 оны 35 дугаар хурлын тэмдэглэл.

Мөн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 29-ний өдрийн хооронд <https://ulaanbaatar2040.mn/> вэб хуудас, Улаанбаатар 2040 Facebook, twitter, Instagram-д байршуулан, Youtube, телевиз, сайтын мэдээ, ярилцлага, Засгийн газрын яамд, Нийслэл түүний харьяа байгууллагын сайт, пэйж зэрэг олон нийтийн цахим сүлжээний хэрэгслүүд болон харьяа хороогоор дамжуулан цаасан хэлбэрээр санал авах үйл ажиллагааг явуулж нийт 32,230 иргэдээс санал ирүүлсэн. Санал өгсөн иргэдийн 93 хувь нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дэмжсэн бөгөөд амьдарч буй орчноо сайжруулахад нэн тэргүүнд гэр хорооллыг барилгажуулах, сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, авто зам, дугуйн зам, явган хүний зам, авто зогсоолыг нэмэгдүүлэх саналыг нийтлэг гаргасан болно.

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичгийн төсөлд Нийслэл хотын хот байгуулалтын өнөөгийн нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн өсөлт, шинжлэх ухааны хөгжил, цаг үеийн өөрчлөлтүүд, ирээдүйн хотжилтын чиг хандлага, иргэд, олон нийтийн санал оролцоонд тулгуурлан 1.Тогтвортой хөгжилтэй хот, 2.Идэвхтэй хот, 3.Дасан зохицох чадвартай хот, 4.Цогц хот, 5.Хүртээмжтэй хот, 6.Хэмнэлттэй хот гэсэн үзэл баримтлалын хүрээнд Улаанбаатар хотыг 2040 он гэхэд “Амьдрахад таатай орчин бүрдсэн хот” болгон хөгжүүлэх алсын харааг тодорхойлсон бөгөөд дараах томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгаж, хүрэх үр дүнг тодорхойлсон. Үүнд:

- Улаанбаатар бүсийн хэмжээнд дагуул хот, тосгодыг соёл боловсрол, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, эдийн засгийн тусгай бүс, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж, 193 мянган ажлын байрыг шинээр бий болгосноор Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулна;

- Нийслэлийн дагуул хот, тосгоны эдэлбэр газрын хэмжээ, зааг, бүсчлэлийг тогтоосноор хотжих боломжтой нутаг дэвсгэрийн газар ашиглалт сайжирч, хяналттай, төлөвлөлттэй суурьшил үүснэ;

- Нийслэл Улаанбаатар хот нэг төвт төвлөрсөн хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжиж, иргэд, олон нийтэд нийгмийн болон төрийн үйлчилгээг ойртуулах нөхцөл бүрдэнэ. Тухайлбал, “20 минутын хот” үзэл баримтлалаар 14 хотыг төлөвлөн хөгжүүлж, дэд байгуулна;

- Гэр хорооллын байршил, инженерийн дэд бүтцийн сүлжээнд холбогдох боломж, сууцны төрөл зэрэг нөхцөлүүдээс шалтгаалан төвийн бүс нь төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбогдсон өндөр болон дунд давхрын орон сууцны хороолол, дундын бүс нь хэсэгчилсэн инженерийн дэд бүтцэд холбогдсон нам болон дунд давхрын орон сууцны хороолол, захын бүс нь бие даасан инженерийн дэд бүтэц бүхий сайжруулсан амины орон сууцны хороолол болон хөгжинэ;

- Байгаль орчны эко систем, тэнцвэрт байдлыг хамгаалж, агаар орчны бохирдлыг бууруулна. Тухайлбал, барилгажсан болон гэр хорооллын хэсэг, дэд төвүүдэд хотын болон дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр байгуулж нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 4.8 м<sup>2</sup>-аас 35 м<sup>2</sup> болгон нэмэгдүүлж иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх тохилог орчин бүрдэнэ;

- Багтаамж ихтэй нийтийн тээврийн сүлжээг бий болгож өдөрт 1.2 сая зорчигч тээвэрлэж нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлнэ, 1738.8 км замыг шинээр байгуулж оргил ачааллын үеийн дундаж хурд 9 км/цаг-аас 22.5 км/цаг болж нэмэгдэнэ;

- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, мониторингийн тогтолцоо бүрдэнэ;

- Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд төр хувийн хэвшлийн түншлэлийг түлхүү ашиглаж, хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ. Тухайлбал, Туул, Сэлбэ, Улиастай, Баянгол, Тахилт, Толгойт голуудын хөндийг цэцэрлэгжүүлэн ногоон байгууламжийн коридорыг үүсгэж түүнийг хот, дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэнгүүдтэй холбож хотын цогц ногоон бүтцийг үүсгэх үйл ажиллагааг иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлж, дэмжих, урамшуулах тогтолцоо бий болно;

- Нийслэл Улаанбаатар хотын дагуул хот, тосгон, эдийн засгийн тусгай бүсийг байгуулснаар тэдгээрт оршин сууж байгаа иргэн, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага татварын болон татварын бус дэмжлэг эдэлнэ. Тухайлбал, Тусгай бүсэд байнга байрлаж, тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг тухайн бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар чөлөөлнө гэх мэт.

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад, хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд энэ тогтоол гарсантай холбогдуулан “Улаанбаатар хотын 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг баталсан Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолыг хүчингүй болгох заалт тусгагдсан болно.

---o0o---

## **“НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүний аюулгүй байдлыг хангах” төрийн үүргийг тодорхойлсон.

Нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжсэн манай улсын хувьд төр дээр дурдсан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхүйц бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, иж бүрэн тохижуулах цогцолбор үйл ажиллагаа болох “хот байгуулалт”<sup>1</sup>-ын үйл ажиллагаа, тухайн хот, тосгоны ирээдүйн хөгжил, эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгохуйц газар ашиглалт, хотын барилгажилт болон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн үе шат бүхий төлөвлөлтийн мэргэжлийн үйл ажиллагаа болох “хот төлөвлөлт”<sup>2</sup>-ийн үйл ажиллагаа чухал ач холбогдолтой юм.

Энэхүү “хот байгуулалтын” болон “хот төлөвлөлтийн” үйл ажиллагааг “хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” буюу хот, тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичиг<sup>3</sup>-ээр тодорхойлдог бөгөөд манай улсын нийт хүн амын 50 орчим хувь нь ажиллаж, амьдарч байгаа нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь нийслэлийн төдийгүй бүс нутаг, цаашлаад улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьдралын чанар, Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдол бүхий хот байгуулалтын баримт бичиг юм.

Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь манай улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч хүн ам, их дээд сургууль, коллеж, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ зэрэг үзүүлэлтээр тогтмол Улсын хэмжээнд тэргүүлж жил бүр энэ үзүүлэлтийн тоо хэмжээ өссөөр байна. Эдгээр үзүүлэлтийг 2024 оны хагас жилийн байдлаар авч үзвэл<sup>4</sup>:

- Нийслэлд байнга оршин суугчдын тоо 1,596,335 буюу манай улсын нийт хүн амын 47.4% хувьтай тэнцэж байгаа бөгөөд нийслэлийн нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн амын тоог Улаанбаатар хотын 4, 5 дахь хөгжлийн ерөнхий төлөвлөгөө баталж байсан болон түүнд тодотгол оруулж байсан цаг хугацаатай одоогийн нөхцөл байдлыг харьцуулан үзвэл тогтмол өсөж байна.

<sup>1</sup> Хот байгуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт.

<sup>2</sup> Хот байгуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт.

<sup>3</sup> Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.3 дахь заалт.

<sup>4</sup>

Нийслэл	1963	2002	2013	2024.03.25	2040
нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүний тоо /хүн/ <sup>5</sup>	47.1	185.4	291.9	369.1	
Өсөлтийн хувь /өмнөх оны үзүүлэлттэй харьцуулсан хувь/	-	293.6	57.4	26.4	

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 175,200 буюу манай улсад бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 74.7 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт. Аж ахуйн нэгж, байгууллага  
/төрөл, улсын нэгдсэн тооллого явагдсан оноор<sup>6</sup>/

он	бүгд	Байгууллагын төрөл		
		Аж ахуйн нэгж	Төрийн	Төрийн бус
1998	18950	14040	3835	1075
2006	32410	26841	3398	2171
2011	65204	55366	3959	5879
2016	118686	101463	4372	12851
2021	180006	151577	4597	23852
Өсөлтийн хувь /2021 оны тооллогын дүнг өмнөх тооллогын дүнтэй харьцуулсан хувь/		49.4%	5.1%	85.6%

2021 онд хийгдсэн ААНБ-ын улсын тооллогоор манай улсын хэмжээнд бүртгэгдсэн 180.0 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 130.0 мянга нь Улаанбаатар хотод байршиж, 2016 оны тооллогын дүнгээс 52.4 хувиар нэмэгдсэн бол 2024 оны хагас жилийн байдлаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 175,200-д хүрч, 2016 оноос хойш 34.7 хувиар өссөн байна.

- нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 33.8 их наяд төгрөг буюу үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний 69.2 хувьтай тэнцэж байна<sup>7</sup>.

“Хот байгуулалтын тухай” хуулийн 5.1.5-д “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г Улсын Их Хурал батлахаар хуульчилсны дагуу “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулсан.

Энэ нь Улаанбаатар хотыг хөгжүүлэх урт хугацааны 6 дахь удаагийн ерөнхий төлөвлөгөө бөгөөд анхдугаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 1954 онд батлагдаж, 1961, 1976, 1986 онуудад тодотгол, шинэчлэл хийгдэж байсан ба Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсонтой уялдуулан Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн ба нийслэлийн хүн ам, эдийн засаг, газрын

<sup>5</sup> Үндэсний статистикийн хороо, Хүн амын нягтрал, [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#);

<sup>6</sup> Үндэсний статистикийн хороо, [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#)

<sup>7</sup>

харилцаанд томоохон өөрчлөлтүүд гарч Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг батлан хэрэгжүүлсэн.

Сүүлийн жилүүдэд төрөөс Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүний аюулгүй байдлыг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор хот байгуулалт, хот төлөвлөлттэй холбоотой хэд хэдэн бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал:

1.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9-д “Улаанбаатар хотыг Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэх” зорилгыг дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх зорилт, үе шат, хүрэх үр дүнг дараахи байдлаар тодорхойлсон. Үүнд:

**Зорилт 9.2.**Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно:

- Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бохирдол үүсгэгчийг багасгаж, агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулсан байна;

- Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болсон байна;

- Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ;

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор нийтийн тээвэрт эко, цахилгаан тээврийг нэвтрүүлсэн байна;

- Гэр хорооллын болон ногоон бүсийн айл өрхүүдийн эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлж, өрхийн үйлдвэрлэсэн цахилгааныг төвийн сүлжээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

**Зорилт 9.3.**Орон зайн оновчтой төлөвлөлт, суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай, олон улсад өрсөлдөгч метрополитан хот болж хөгжинэ:

- Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь дагуул хотуудад кампус байгуулж шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулна;

- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ.

**Зорилт 9.5.** Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ:

- Дагуул, хаяа хот, тосгоныг тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна;

- “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

- Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ;

- Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана;

- Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон байгуулан шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулна;

- Улаанбаатар хотын бүсийн хэмжээнд өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна.

2.Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Зорилго 9-д “Нийслэл хотыг амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.” гэсэн зорилго, зорилтуудыг дэвшүүлсэн. Тухайлбал:

**Зорилт 9.1.** Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ:

- нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна;

- эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.

**Зорилт 9.2.** Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно:

- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна;

- хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болгоно;
- ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно;
- олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.

**Зорилт 9.3.** Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ:

- соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв баригдаж төвлөрлийг бууруулна;
- хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ;
- инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлнэ;
- олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна;
- Богд уулыг тойрсон “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан байна.

3. Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичигт “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон<sup>8</sup>:

- Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулан багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлж, гол ба үндсэн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчилж, олон түвшний уулзварыг байгуулан хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын түгжрэлийг бууруулна;
- шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна гэх мэт.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт Улаанбаатар хот нийт 15 дагуул хот, тосгонтой байхаар төлөвлөсөн боловч дагуул хотыг хэрхэн байгуулах, бүтэц зохион байгуулалт нь ямар байх талаар ерөнхий зохицуулалттай, тухайн хотын онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалтгүйгээс тодорхой үр дүнд хүрээгүй тул Улсын Их Хурал 2021 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2023 онд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай

<sup>8</sup> “Шинэ сэргэлтийн бодлого”-ын дөрөвт;

хууль, 2024 онд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг тус тус баталсан нь Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бүрдүүлээд байна.

Мөн дээр дурдсан хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, түүний үзүүлэлт, үр дагаврыг харгалзан нийслэл Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгож, 20 минутын дотор төрийн болон бусад үйлчилгээ авах боломжтой хот, тосгон байгуулах хэрэгцээ шаардлагыг үндэслэн Улсын Их Хурлын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолоор нийслэлийн нутаг дэвсгэрт Улсын зэрэглэлтэй 2 хот, орон нутгийн зэрэглэлтэй 14 хот, 3 дагуул хотыг байгуулсан бол Улсын Их Хурлын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн 76 дугаар тогтоолоор Төв аймгийн нутаг дэвсгэрт нийслэлийн дагуул хот "Шинэ Зуунмод хот"-ыг тус тус байгуулаад байна.

Эдгээр бодлогын баримт бичиг, хот байгуулалттай холбоотой хуулийн хэрэгжилтийг хангаж Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлэх<sup>9</sup> зорилтын хүрээнд хэрэгжүүлэх "Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл"<sup>10</sup>-ийн нэг томоохон арга хэмжээ "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан "Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040" болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах<sup>11</sup>, Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн дулааны станцууд болон хотын дэд төвүүдийн дулааны станцуудыг үе шаттайгаар барих<sup>12</sup>, бие даасан эдийн засаг бүхий улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотуудыг хөгжүүлэх<sup>13</sup> талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгагдсан. Тухайлбал,

- нийслэлийн дагуул хот болох Шинэ Зуунмод хотод нийслэл дэх төрийн байгууллагуудыг үе шаттайгаар шилжүүлэн байршуулж, олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, аялал жуулчлалын цогцолбор, ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, их сургуулийн хотхон бүхий аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлнэ<sup>14</sup>;

- Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгах<sup>15</sup>;

<sup>9</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Нэг. Бүс нутгийн хөгжлийн бодлого;

<sup>10</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1;

<sup>11</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.1;

<sup>12</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.1;

<sup>13</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2;

<sup>14</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.1;

<sup>15</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.3;

- Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна<sup>16</sup> гэх мэт.

Улаанбаатар хотын цаашдын хөгжлийн үзэл баримтлал /концепц/, чиглэлийг тодорхойлох ажлын хүрээнд Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/ боловсруулах нээлттэй уралдаан, олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, ирүүлсэн шинэлэг санаа, шийдлүүдэд үндэслэн үзэл баримтлал /концепц/-ыг боловсруулсан бөгөөд үзэл баримтлалыг Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, тус үзэл баримтлалын дагуу “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичгийг боловсруулахыг даалгасан<sup>17</sup>.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Хүн ам нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн төсөл, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөл зэрэг урт хугацааны бодлогын баримт бичгийн үзэл санаа, зохицуулалттай уялдуулах, олон нийтээр хэлэлцүүлэх, тэдний саналыг авах ажлыг зохион байгуулсан.

д/д	Оролцогчид	Тайлбар
1	Мэргэжлийн байгууллага, холбоод, төрийн бус байгууллага, багш, эрдэмтэн, судлаачид.	2 удаа цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан.
2	Төрийн захиргааны төв байгууллагууд, тэдгээрийн харьяа газрын удирдлага, албан хаагчид.	
3	9 дүүрэг, 172 хороодын Засаг дарга, албан хаагчид.	
4	Нийслэлийн өмчит болон инженерийн дэд бүтцийн хангагч нийт 45 байгууллагын албан хаагчид.	
5	Монголын Архитекторуудын Эвлэлийн болон Хот төлөвлөлт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн хурлын гишүүд	
6	ЗГХЭГ болон Шадар сайдын ажлын албаны дарга, албан хаагчид.	
7	Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүд, ААНБ-ын төлөөлөл.	
8	НИТХ-ын төлөөлөгчид	НИТХ-ын 2021 оны ээлжит бус IV хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, 04/30 дугаар тогтоол гаргасан.

<sup>16</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.3.1;

<sup>17</sup> Засгийн газрын 2020 оны 35 дугаар хурлын тэмдэглэл.

Мөн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 29-ний өдрийн хооронд <https://ulaanbaatar2040.mn/> вэб хуудас, Улаанбаатар 2040 Facebook, twitter, Instagram-д байршуулан, Youtube, телевиз, сайтын мэдээ, ярилцлага, Засгийн газрын яамд, Нийслэл түүний харьяа байгууллагын сайт, пэйж зэрэг олон нийтийн цахим сүлжээний хэрэгслүүд болон харьяа хороогоор дамжуулан цаасан хэлбэрээр санал авах үйл ажиллагааг явуулж нийт 32,230 иргэдээс санал ирүүлсэн. Санал өгсөн иргэдийн 93 хувь нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дэмжсэн бөгөөд амьдарч буй орчноо сайжруулахад нэн тэргүүнд гэр хорооллыг барилгажуулах, сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, авто зам, дугуйн зам, явган хүний зам, авто зогсоолыг нэмэгдүүлэх саналыг нийтлэг гаргасан болно.

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичгийн төсөлд Нийслэл Улаанбаатар хотын хот байгуулалтын өнөөгийн нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн өсөлт, шинжлэх ухааны хөгжил, цаг үеийн өөрчлөлтүүд, ирээдүйн хотжилтын чиг хандлага, иргэд, олон нийтийн санал оролцоонд тулгуурлан дор дурдсан үзэл баримтлалын хүрээнд Улаанбаатар хотыг 2040 он гэхэд “Амьдрах таатай орчин бүрдсэн хот” болгон хөгжүүлэх алсын харааг тодорхойлсон:

- 1.Тогтвортой хөгжилтэй хот;
- 2.Идэвхтэй хот;
- 3.Дасан зохицох чадвартай хот;
- 4.Цогц хот;
- 5.Хүртээмжтэй хот;
- 6.Хэмнэлттэй хот.

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичгийн төсөлд олон улсын мэрэгжлийн байгууллага, мэрэгжилтнүүдийн санал зөвлөмжийг авах ажлыг НЗДТГ-аас зохион байгуулж, БНСУ-ын “Дэхан консалтент” ХХК шалгаран санал, зөвлөмж өгсөн.

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичгийн төсөлд Нийслэл хотыг “Амьдрах таатай орчин бүрдсэн хот” болгон хөгжүүлэхийн тулд дараах томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгаж, хүрэх үр дүнг тодорхойллоо. Тухайлбал:

- Улаанбаатар бүсийн хэмжээнд дагуул хот, тосгодыг соёл боловсрол, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, эдийн засгийн тусгай бүс, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж, 193 мянган ажлын байрыг шинээр бий болгосноор Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулна;

- Нийслэлийн дагуул хот, тосгоны эдэлбэр газрын хэмжээ, зааг, бүсчлэлийг тогтоосноор хотжих боломжтой нутаг дэвсгэрийн газар ашиглалт сайжирч, хяналттай, төлөвлөлттэй суурьшил үүснэ;

- Нийслэл Улаанбаатар хотыг нэг төвт төвлөрсөн хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлж, иргэд, олон нийтэд нийгмийн болон төрийн үйлчилгээг ойртуулах нөхцөл бүрдэнэ. Тухайлбал, Улаанбаатар хотын хүн ам, барилгажилтын хэт төвлөрлийг задлах зорилгоор соёл боловсрол, банк, санхүү, худалдаа үйлчилгээ, орон

сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий 14 хотыг төлөвлөн хөгжүүлж, дэд төвүүдийг байгуулна;

- гэр хорооллын байршил, инженерийн дэд бүтцийн сүлжээнд холбогдох боломж, сууцны төрөл зэрэг нөхцөлүүдээс шалтгаалан төвийн бүс нь төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбогдсон өндөр болон дунд давхрын орон сууцны хороолол, дундын бүс нь хэсэгчилсэн инженерийн дэд бүтцэд холбогдсон нам болон дунд давхрын орон сууцны хороолол, захын бүс нь бие даасан инженерийн дэд бүтэц бүхий сайжруулсан амины орон сууцны хороолол болон хөгжинө;

- байгаль орчны эко систем, тэнцвэрт байдлыг хамгаалж, агаар орчны бохирдлыг бууруулна. Тухайлбал, барилгажсан болон гэр хорооллын хэсэг, дэд төвүүдэд хотын болон дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр байгуулж нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 4.8 м<sup>2</sup>-аас 35 м<sup>2</sup> болгон нэмэгдүүлж иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх тохилог орчин бүрдэнэ;

- багтаамж ихтэй нийтийн тээврийн сүлжээг бий болгож өдөрт 1.2 сая зорчигч тээвэрлэж нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлнэ. Мөн 1738.8 км замыг шинээр байгуулснаар оргил цагийн хөдөлгөөний дундаж хурд 9 км/цаг-аас 22.5 км/цаг болж нэмэгдсэнээр Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулна;

- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, мониторингийн тогтолцоо бүрдүүлнэ;

- Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд төр хувийн хэвшлийн түншлэлийг түлхүү ашиглаж, хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ. Тухайлбал, Туул, Сэлбэ, Улиастай, Баянгол, Тахилт, Толгойт голуудын хөндийг цэцэрлэгжүүлэн ногоон байгууламжийн коридорыг үүсгэж түүнийг хот, дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэнгүүдтэй холбож хотын цогц ногоон бүтцийг үүсгэх үйл ажиллагааг иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлж, дэмжих, урамшуулах тогтолцоо бий болно;

- Нийслэл Улаанбаатар хотын дагуул хот, тосгон, эдийн засгийн тусгай бүсийг байгуулснаар тэдгээрт оршин сууж байгаа иргэн, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага татварын болон татварын бус дэмжлэг эдэлнэ. Тухайлбал, Тусгай бүсэд байнга байрлаж, тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг тухайн бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар чөлөөлнө гэх мэт.

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад, хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд энэ тогтоол гарсантай холбогдуулан “Улаанбаатар хотын 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг баталсан Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолыг хүчингүй болгох заалт тусгагдсан болно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН Т О Г Т О О Л**2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот**НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ  
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын ес дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.

2.“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай:

1/“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 2 дугаар улиралд багтаан баталж, түүнд заасан арга хэмжээг улсын болон нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2/“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад 5 жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж Улсын Их Хуралд танилцуулах;

3/“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

4/“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн төслийг боловсруулах, эрх бүхий байгууллагад өргөн барих ажлыг зохион байгуулах.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

**УЛААНБААТАР ХОТЫГ 2040 ОН ХҮРТЛЭХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ,  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ****НЭГ.ЗУРАГЛАЛЫН МАТЕРИАЛ: 40 хуудас****1.1. Нийслэлийн буюу Улаанбаатар бүсийн хөгжлийн чиг хандлага, хэтийн төлөв**

Нүүр хуудас

1.1.1. Зургийн жагсаалт	
1.1.2. Бүсийн таталцал нөлөөлөл	схем
1.1.3. Нийгэм - эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв	схем

**Байгаль орчин**

1.1.4. Ойн сан, ногоон бүсийн хамгаалалт /Ногоон дэд бүтэц/	M1:100000
1.1.5. Усны нөөцийн менежмент /Цэнхэр дэд бүтэц/	M1:100000
1.1.6. Тусгай хамгаалалттай газар нутгийн хадгалалт, хамгаалалт	M1:100000
1.1.7. Экологийн коридорын бүтэц	M1:100000
1.1.8. Хог хаягдлын менежмент	M1:100000

**Хот байгуулалт, суурьшлын бүсийн хөгжил**

1.1.9. Хот байгуулалтыг хориглох, хязгаарлах, дэмжих бүс	M1:100000
1.1.10. Нутаг дэвсгэрийн бүс	M1:100000
1.1.11. Гадна зам тээврийн сүлжээий хөгжлийн чиг хандлага	M1:100000
1.1.12. Түүх соёл, археологийн өвийн хадгалалт, хамгаалалт	M1:100000
1.1.13. Аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага	M1:100000

**Улаанбаатар бүсийн инженерийн дэд бүтцийн хөгжлийн чиг хандлага**

1.1.14. Дулаан хангамж	M1:100000
1.1.15. Цахилгаан хангамж	M1:100000
1.1.16. Ус хангамж	M1:100000
1.1.17. Ариутгах татуурга	M1:100000
1.1.18. Мэдээлэл холбоо	M1:100000
1.1.19. Инженерийн бэлтгэл арга хэмжээ	M1:100000

**1.2. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө****Нутаг дэвсгэр, архитектур орон зайн төлөвөлт**

1.2.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн үндсэн бүс	M1:10000
1.2.2. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн дэд бүс	M1:10000
1.2.3. Орон нутгийн зэрэглэлтэй 14 хот	M1:10000
1.2.4. Төлөвлөлтийн 42 нэгж хорооллууд	M1:10000
1.2.5. Хот байгуулалтын үйл ажиллагаа	M1:10000
1.2.6. Ногоон байгууламжийн сүлжээ	M1:10000
1.2.7. Түүх соёлын үл хөдлөх өв, дурсгалын хадгалалт, хамгаалалт	M1:10000
1.2.8. Хотын аялал жуулчлал	M1:10000
1.2.9. Гамшгийн менежмент	M1:10000

### **Зам тээврийн сүлжээ**

1.2.10. Гудамж замын үндсэн бүтэц	M1:10000
1.2.11. Авто замын сүлжээ	M1:10000
1.2.12. Нийтийн тээврийн сүлжээ	M1:10000

### **Инженерийн бэлтгэл арга хэмжээ**

1.2.13. Үерийн хамгаалалтын барилга байгууламж	M1:10000
1.2.14. Хөрсний ус шүүрүүлэх, зайлуулах шугам, хяналтын цооног	M1:10000
1.2.15. Автозам талбайн борооны ус зайлуулах шугам	M1:10000

### **Инженерийн дэд бүтцийн хангамж**

1.2.16. Дулаан хангамж	M1:10000
1.2.17. Цахилгаан хангамж	M1:10000
1.2.18. Ус хангамж	M1:10000
1.2.19. Ариутгах татуурга	M1:10000
1.2.20. Мэдээлэл холбоо	M1:10000

### **ХОЁР:БИЧИГЛЭЛИЙН МАТЕРИАЛ: 3 боть**

I боть. Суурь судалгааны тайлан	- 232 хуудас
II боть. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	- 376 хуудас
III боть. Хураангуй тайлан	- 284 хуудас

**УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА**

**УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2024 он

Агуулга	
Товчилсон үгийн жагсаалт.....	3
Удиртгал.....	4
<b>НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ .....</b>	<b>6</b>
1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал.....	9
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох.....	16
1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл .....	16
<b>ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ .....</b>	<b>17</b>
<b>ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....</b>	<b>17</b>
<b>ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ .....</b>	<b>19</b>
4.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө .....	19
4.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө .....	23
4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө .....	26
4.5 Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ, бусад хуультай нийцэж буй байдал .....	27
<b>ТАВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ .....</b>	<b>28</b>
<b>ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>37</b>
Ашигласан эх сурвалж: .....	39

## Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АҮ	Аж үйлдвэрийн
БНБД	Барилгын норм ба дүрэм
ДЦС	Дулааны цаилгаан станц
ЗГ	Засгийн газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЕТ	Ерөнхий төлөвлөгөө
МАА	Мал аж ахуй
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ҮТП	Үндэсний технологийн парк
ХАА	Хөдөө аж ахуй
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
ЭЗ	Эдийн засаг

## ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

(Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тухай)

### Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх”, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүний аюулгүй байдлыг хангах” төрийн үүргийг тодорхойлсон.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн хот байгуулалтын үндсэн баримт бичиг бөгөөд Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Их Хурал батлахаар заасан.

Улаанбаатар хотын анхдугаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 1954 онд батлагдаж, 1961, 1976, 1986 онд тодотгол, шинэчлэл хийгдэж байсан ба Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсонтой уялдуулан Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг баталж, улмаар Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг баталсан.

1990-ээд оноос Нийслэл хот руу хүн амын шилжих хөдөлгөөн эрс нэмэгдэж, Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн харилцаа идэвхжихийн хэрээр төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, агаар, хөрс бохирдох, хог хаягдал, дуу чимээ нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх зэргээр нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч, иргэдийн ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах эрх зөрчигдөхөд хүрч байгаа тул сүүлийн жилүүдэд нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой дараахи хууль тогтоомжууд батлагдсан нь нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, батлах хэрэгцээ шаардлага бий болсныг илтгэн харуулж байна. Үүнд:

-“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн<sup>1</sup> 9 дүгээр бүлэг;

-Монгол Улсын Үндэсний бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал<sup>2</sup>;

-Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл<sup>3</sup>-ийн зорилго 9;

-2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга);

-2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль;

<sup>1</sup> Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан.

<sup>2</sup> Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан;

<sup>3</sup> Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан;

-Улсын Их Хурлын 2024 оны “Хот байгуулах тухай” 72, 76 дугаар тогтоолууд;

-Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр.<sup>4</sup>

Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлах хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны арга зүй, үе шатууд:

- Асуудалд дүн шинжилгээ хийх;
- Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
- Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг сөрөг талыг харьцуулан судлах;
- Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
- Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
- Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
- Санал, зөвлөмж боловсруулах.

Эдгээр үе шатуудын дагуу “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-тэй холбоотой ойлголт, харилцааг судалж, эрх зүйн орчинд үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх ерөнхий зорилгоо тогтоож, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж хамгийн оновчтой хувилбарыг сонгон үр нөлөөг судлав.

Эцэст нь тухайн хувилбаруудаас сонгон авсан хувилбарт үндэслэн санал дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

---

<sup>4</sup> Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан;

## НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хот нь хөгжлийн чиг хандлагаа тодорхойлсон 5 удаагийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжиж, 1954 онд боловсруулсан анхны ерөнхий төлөвлөгөөнд 1963, 1974, 1986, 2002 онуудад тодотгол, шинэчлэл хийгджээ.

1992 онд Шинэ Үндсэн хууль батлагдаж, манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж, улмаар Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолоор "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-г баталсан бөгөөд нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжил, өөрчлөлттэй уялдуулан Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг"-ийг батлан хэрэгжүүлж байна.

Нийслэл Улаанбаатар хотод төрийн дээд байгууллагууд байнга оршдог, улсын нийт хүн амын тал хувь нь ажиллаж амьдардаг, их дээд сургууль, коллеж болон бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ зэрэг үзүүлэлт жил бүр өсөж байгаа боловч хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллахад сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлүүд бий болж байгааг харгалзан сүүлийн жилүүдэд нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой хэд хэдэн бодлогын баримт бичиг батлагдсан. Үүнд:

- "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"<sup>5</sup>-ын 3.4.3.2-т "Нийслэлийн хүн амын төвлөрлийг тархаан байршуулах зорилгоор дагуул хотуудыг төлөвлөж, бүс нутгийг өндөр хурдны авто зам, эрчим хүч, инженерийн барилга байгууламжаар хангаж холбоно.";

- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн<sup>6</sup> 9.3.1-д "Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.", 9.3.46-д "Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ.", 9.5.5-д "Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.";

- "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"<sup>7</sup>-ийн зорилго 9-д "Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.", 9.2.1-д "Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна", 9.3.2-т "Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ", 9.5.3-т "Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлнэ.";

- "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"<sup>8</sup>-т "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын

<sup>5</sup> Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан;

<sup>6</sup> Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан.

<sup>7</sup> Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан;

<sup>8</sup> Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан;

баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан "Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040"-г боловсруулж, батлуулна." гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар хуралдаанаар "Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө" боловсруулж, батлуулахаар шийдвэрлэсэн байна.

"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичигт Улаанбаатар хот нийт 15 дагуул хот, тосгонтой байхаар төлөвлөсөн боловч тэдгээрийг хэрхэн байгуулах, бүтэц зохион байгуулалт нь ямар байх талаар зохицуулалтгүйгээс тодорхой үр дүнд хүрээгүй тул УИХ 2021 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2023 онд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, 2024 онд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга), Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг тус тус баталсан нь нийслэл хотын төвлөрлийг сааруулах, нэг төвт хотоос олон төвт хот болох төлөвлөлтийн зарчмын дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлах, түүнийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бүрдүүлжээ.

Тухайлбал, нийслэл Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгож, 20 минутын дотор төрийн болон бусад үйлчилгээ авах боломжтой хот, тосгон байгуулах хэрэгцээ шаардлагыг үндэслэн УИХ-ын 2024 оны 72 дугаар тогтоолоор Нийслэлийн нутаг дэвсгэрт улсын зэрэглэлтэй Багануур хот, Налайх хот, орон нутгийн зэрэглэлтэй Хан-Уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-эх, Баянзүрх, Амгалан хот, нийслэлийн дагуул Багахангай хот, Агросити хот, Шарга морьт хотыг, УИХ-ын 2024 оны 76 дугаар тогтоолоор Төв аймгийн нутаг дэвсгэрт "Шинэ Зуунмод хот"-ыг, Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт Агросити, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийг тус тус байгуулсан.

Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлэх"<sup>9</sup> зорилтын хүрээнд "Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл"<sup>10</sup>-ийн нэг томоохон арга хэмжээ болох "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичиг, түүнд суурилсан "Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040" болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах<sup>11</sup>, оргил ачааллын горимд ажиллах хийн дулааны станцууд болон дэд төвүүдийн дулааны станцуудыг үе шаттайгаар барих<sup>12</sup>, бие даасан эдийн засаг бүхий улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотуудыг хөгжүүлэх<sup>13</sup> талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгагдсан. Тухайлбал,

- Шинэ Зуунмод хотод нийслэл дэх төрийн байгууллагуудыг шилжүүлэн байршуулж, олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, аялал жуулчлалын цогцолбор, ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, их

<sup>9</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Нэг. Бүс нутгийн хөгжлийн бодлого;

<sup>10</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1;

<sup>11</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.1;

<sup>12</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.1;

<sup>13</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2;

сургуулийн хотхон бүхий аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлнэ<sup>14</sup>;

- Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгах<sup>15</sup>;

- Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна<sup>16</sup> гэх мэт.

Мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгагдсан нь Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заавал тусгах шаардлагатай асуудлууд болно. Үүнд:

- Хотын төв дэх төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, "Өөдөө тэмүүлэх Монгол" буюу "Go Mongolia" ган татлагат гүүрийн төсөл, Хөшигийн хөндийн туннелийн төслийг хэрэгжүүлэх, олон улсын чанартай Шинэ тойрог зам, Туулын хурдны авто зам, "Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1", "Дүүжин тээвэр шугам-1" зэрэг олон төрөлт нийтийн тээврийн сүлжээ байгуулах, явган болон дугуйтай зорчигчдод ээлтэй дэд бүтцийг бий болгож автомашины хэрэглээг болон бохирдлын хэмжээг 2 дахин бууруулах;

- "Туул усан цогцолбор төсөл"-ийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, ундны ус, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх, Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн голын эргийн хамгаалалтын далан болон ус зайлуулах сувгийг шинээр барьж, усан сан, хөв, цөөрөм байгуулах, инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

- нийтийн эзэмшлийн газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барьж, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах нөхцөлийг бүрдүүлэх гэх мэт.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" зэрэг урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн зохицуулалт, хэрэгжилттэй уялуулах нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний нэг онцлох чиг үүрэг, хэрэгцээ шаардлага болж байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагад нийцүүлэн иргэний эрүүл, аюулгүй, амьдралын таатай орчин бүрдүүлсэн, олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан, сайн засаглал бүхий эдийн засаг, бизнес, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх боломжтой байдлаар "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Судалгааны хүрээнд хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоо, хүний эрхийг хангахад чиглэсэн үндсэн зарчим, Нийслэл Улаанбаатар хотод амьдрахад аятай таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийгэм, эдийн засгийн өсөлтийг бий болгох үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүний ач холбогдол, эерэг болон сөрөг талыг судлан үзлээ.

<sup>14</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.1;

<sup>15</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.3;

<sup>16</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.3.1;

Үүний тулд аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.


### 1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах хэрэгцээ шаардлагыг манай улсын хотжилт, түүний дотроос нийслэл хотын болон Улаанбаатар бүс нутгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, хүн амын амьдралын чанар, дэд бүтцийн хангамж зэрэг асуудлыг тухайлан шинжлэн судалж тодорхойлов.

#### А.Хотжилт ба хүн амын амьдралын чанарт хийсэн дүн шинжилгээ:

Монгол Улсын хүн ам 1962 онд 1 сая, 1988 онд 2 сая, 2015 онд 3 саяд хүрч байсан бол хүн амын шинэчилсэн хэтийн тооцооны дундаж бууралттай хувилбарын тооцооллын дүнгээр Монгол Улсын харьяат хүн ам 2033 онд 4 саяд, 2048 онд 5 саяд хүрэх тооцоо гарсан<sup>17</sup> байх бөгөөд хүн амын нутагшилт суурьшлын үндсэн хоёр хэлбэр нь хот, хөдөө бөгөөд хүн ам олноор шилжин суурьшсантай холбоотойгоор хотжилт эрчимтэй явагдаж, 2010 оны байдлаар 67.9 хувь байсан (Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2011) бол эдүгээ 70 орчим хувьд хүрсэн байна.

Зураг 1. Монгол Улсын хүн амын өсөлт, хот, хөдөөгөөр



Монгол Улсад хотжих үйл явц өнгөрсөн зууны хоёрдугаар хагаст хурдацтай өрнөж, үүнээс хойш өнөөг хүртэл нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь өссөөр байна. Үндэсний статистикийн хорооны судалгаагаар 2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3.5 сая бөгөөд үүнээс 1.7 сая буюу 48.6% нь Улаанбаатар хотод амьдарч байна<sup>18</sup>.

<sup>17</sup> Хүн амын шинэчилсэн хэтийн тооцоо 2020-2050 он, ҮСХ, 2020

<sup>18</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. <https://www.nso.mn/mn/statistic/fun-statistic/population>;

Түүнчлэн Улаанбаатар хотод манай улсын их дээд сургуулиудын 88.5 хувь нь байршиж, түүнд нийт оюутан сурагчдын 95.3 хувь нь суралцаж байгаа төдийгүй Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй хүн амын 39.7 хувь нь төвлөрчээ.

Өнөөгийн байдлаар манай улсад 1,0 саяас дээш хүн амтай хот 1 (Улаанбаатар) байна. УИХ-ын 2024 оны “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолоос харахад аймгийн төвүүд болон суурьшил үүсэн хэсгүүдийг хот болгосорн байх бөгөөд 50.0-100.0 мянган хүн амтай хот 2 (Дархан, Эрдэнэт), 20.0-50.0 мянган хүн амтай хот 12, 20.0 мянга хүртэл хүн амтай хот 7 байна.

Хотжилтын түвшин	Тоо	Хотын нэр
1,0 саяас дээш хүн амтай хот	1	Улаанбаатар
100,000 - 1,000,00 хүн амтай хот	1	Орхон
50,000 - 100,000 хүн амтай хот	1	Дархан
20,000 - 50,000 хүн амтай хот	12	Өлгий, Улаангом, Ховд, Цэцэрлэг, Баянхонгор, Арвайхээр, Хөвсгөл, Сайншанд, Даланзадгад, Сүхбаатар, Чойбалсан, Өндөрхаан
20,000 хүртэл хүн амтай хот	7	Алтай, Улиастай, Булган, Говьсүмбэр, Мандалговь, Зуунмод, Баруун-Урт

Ийнхүү хот, суурин газруудад хүн амын дийлэнх хэсэг төвлөрөн суурьшсантай холбоотойгоор хүн амын нягтрал хот, хөдөөд хэт ялгаатай болсон байна. Тухайлбал 2018 оны байдлаар Улаанбаатар хотын хүн амын нягтрал 317.3 болж улсын дунджаас 151 дахин өндөр болсон байна<sup>19</sup>.

Нийслэл хотын нутаг дэвсгэр манай улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад харгалзан үзэх шаардлагатай нэг асуудал болох хотжилт буюу хүн амын нягтралыг авч үзвэл<sup>20</sup>:

- Улаанбаатар хотын 4, 5 дахь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж байсан цаг хугацаанд болон одоогийн байдлаар нийслэл хотын нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн амын тоог харьцуулан үзвэл тогтмол өсөж байна.

Нийслэл хот	1963	2002	2013	2024.03.25	2040 <sup>21</sup>
Нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүний тоо /хүн/ <sup>22</sup>	47.1	185.4	291.9	369.1	444.6
Өсөлтийн хувь /өмнөх оны үзүүлэлттэй харьцуулсан хувь/	-	293.6	57.4	26.4	20.4

Улаанбаатар хотын хүн ам төлөвлөснөөс хэтрэлтэй (14% гажилттай) байгаа нь хүн амын төвлөрлийг тархаах бодлого хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Хэдийгээр хотжилт нэмэгдсэнээр хот, суурин газруудын эдийн засаг өргөжин тэлж байгаа боловч нөгөө талаар хөдөө орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжил саарч, зах зээл нь хумигдаж байгаа нь эргээд хот, суурин газар руу шилжих хөдөлгөөнийг эрчимжүүлэх нөлөө үзүүлж байна. Тухайлбал 2008 онд Монгол улсын ДНБ-ий 54,8%-ийг Улаанбаатар хотод үйлдвэрлэж байсан бол энэ үзүүлэлт тогтмол өссөөр 2023 оны жилийн эцсийн

<sup>19</sup> [www.1212.mn](http://www.1212.mn)

<sup>20</sup> Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл;

<sup>21</sup> Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд;

<sup>22</sup> Үндэсний статистикийн хороо, Хүн амын нягтрал, [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](http://www.1212.mn);

байдлаар онд 66,5% болсон<sup>23</sup> зэрэг сайн үр дүн байгаа боловч хотжилтын нөлөө, хүн амын хэт төвлөрлийн улмаас хог хаягдал бүхий гудамж, хороог бий болгож, хавар, намартаа их хэмжээний “шороо, түйрэн” дэгдэх, өвөлдөө агаарын бохирдлыг үүсгэх болсны дээр амьжиргаа тааруу өрхүүд бүхий захын гэр хорооллууд тэлэхэд хүргэжээ.

Ийм учраас нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн хот байгуулалтын үндсэн баримт бичиг болох “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г шинэчлэн батлах хэрэгцээ шаардлага байна.

### **Б.Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт:**

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 175,200 буюу манай улсад бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 74.7 хувьтай тэнцэж байна.

*Хүснэгт. Аж ахуйн нэгж, байгууллага /улсын нэгдсэн тооллого явагдсан оноор<sup>24</sup>/*

он	Нийт	Байгууллагын төрөл		
		Аж ахуйн нэгж	Төрийн	Төрийн бус
1998	18950	14040	3835	1075
2006	32410	26841	3398	2171
2011	65204	55366	3959	5879
2016	118686	101463	4372	12851
2021	180006	151577	4597	23852
<i>Өсөлтийн хувь /2021 оны тооллогын дүнг өмнөх тооллогын дүнтэй харьцуулсан хувь/</i>		49.4%	5.1%	85.6%

2021 онд хийгдсэн ААНБ-ын улсын тооллогоор нийт 180.0 мянган ААНБ бүртгэгдсэнээс 130.0 мянга нь Улаанбаатар хотод байрлаж, 2016 оны тооллогын дүнгээс 52.4 хувиар нэмэгдсэн бол 2024 оны хагас жилийн байдлаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 175,200-д хүрч, 2016 оноос хойш 34.7 хувиар өссөн байна.

Ажиллах хүчний судалгааны 2024 оны 1 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 1.4 (59.4%) сая нь ажиллах хүч, 933.3 (40.6%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Ажиллах хүчний 1.3 (94.8%) сая нь ажиллагчид, 71.0 (5.2%) мянга нь ажилгүй хүн байна. Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 37.8 (3.0%) мянгаар өсөж, өмнөх улирлаас 22.7 (1.7%) мянгаар буурч, ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 5.6 (7.3%) мянгаар буурч, өмнөх улирлаас 20.0 (39.2%) мянгаар өссөн байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 36.5 (3.9%) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүч байна. Боломжит ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 7.8 (27.2%) мянгаар өсөж, өмнөх улирлаас 14.8 (28.8%) мянгаар буурсан байна.<sup>25</sup>

2023 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 46.8 их наяд төгрөг буюу үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний 66.5 хувьтай тэнцэж байгаа нь Улаанбаатар хотын үйлдвэр, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын хөгжил хөдөөнөөс илүү, ажлын байрны олдоц харьцангуй өндөр байгаа нь хүмүүсийг ихээр татаж хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлж улмаар нийслэлийн хэт төвлөрлийг бий болгож гажуудсан хотжилтыг бий болгож байна. Иймд энэ чиглэлд анхаарч

<sup>23</sup> <http://ubstat.mn/StatTable=372>

<sup>24</sup> Үндэсний статистикийн хороо, [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](http://ubstat.mn/StatTable=372)

<sup>25</sup> Үндэсний статистикийн хороо, 2024 оны эхний улирлын тайлан, мэдээ

хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах нь хүн амын ядуурлыг бууруулах бодлогын томоохон хүчин зүйл болно гэж үзлээ.

### **В.Дэд бүтцийн хомсдол:**

Улаанбаатар хот Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж байгаа боловч хүн амын нягтрал ихтэй хотод тооцогдож улмаар хотжилтыг бий болгох суурь хүчин зүйлс болох шилжин суурьшилт, хүн амын төвлөрлийн үр дүнд төлөвлөөгүй, эмх замбараагүй хотхон, хороолол, гэр хороолол бий болж хотын нийгэм, эдийн засаг, дэд бүтэц болон засаг захиргааны ажилд ачаалал үүсгэж, үүний дотроос нийгмийн салбарын хөрөнгө оруулалт гэр хорооллын хүн амд бага хийгдэж байгаа нь хөрсний бохирдол, агаарын бохирдлыг нэмэгдүүлж, тухайн өрхүүдийг орчны хувьд баталгаагүй, эмзэг байдалд оруулж байна. Тухайлбал, сургууль, цэцэрлэгийн ачаалал хэтэрсний улмаас гэр хорооллын хүүхдүүд сургууль завсардах, асарч хамгаалах хүнгүй гэртээ үлдэх, 2 ба түүнээс дээш километрт байрлах сургууль, цэцэрлэгт хамрагдах зэрэг эрсдэлтэй, хүндрэлтэй амьдралын орчин нөхцөл бий болсон.

Энэ мэтчилэн нийслэл Улаанбаатар хотын нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмж, хангамж хангалтгүй байгааг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүн илтгэн харуулж байна. Үүнд:

#### **УЛААНБААТАР ХОТЫГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛЫН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Зорилтын чиглэлүүд	Хэрэгжилт (%)
1	Хүн амын суурьшлыг зохицуулах	30%
2	Эдийн засаг	45.3
3	Архитектур, орон зайн төлөвлөлт	18.0
4	Нийгмийн дэд бүтэц	24.5
5	Зам тээвэр	34.7
6	Инженерийн дэд бүтэц	36.5
7	Байгаль орчин, гамшгийн менежмент	18.0
<b>Нийт дундаж биелэлт</b>		<b>29.6%</b>

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг маш хангалтгүй буюу 29.6%-ийн хэрэгжилттэй гэж дүгнэгэхэд дараахи хүчин зүйлүүд нөлөөлсөн гэжээ:

- Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй;
- Салбарын мастер төлөвлөгөө бүрэн боловсруулагдаагүй;
- Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд мониторинг хийх тогтолцоо бүрдээгүй;
- Ерөнхий төлөвлөгөөний хөрөнгө оруулалт, санхүүжилт дутмаг;
- Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хугацаа хоцорч батлагдсан.


#### **Төвлөрсөн дулаан хангамжийн системийн өнөөгийн байдал:**

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн систем нь Дулааны цахилгаан станц II, III, IV болон Амгалан дулааны станцаас хангагдах ба нийт 13,450 гаруй барилга,

байгууламжийг дулааны эрчим хүчээр хангадаг бөгөөд хэрэглэгчдийн 43 хувь нь үйлдвэр, аж ахуйн газар, 57 хувь нь нийтийн болон амины орон сууцны барилгууд байна.

Дулааны эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал 3303 МВт (2840Гкал/цаг) боловч хотын сүлжээнд холбогдсон дулааны хэрэглээ 3923МВт (3373.6 Гкал/цаг), техникийн нөхцөл олгогдсон хүлээгдэж буй хэрэглээ 609МВт (524.9Гкал/цаг) болж суурилагдсан хүчин чадлаас 1838.1 МВт (1580.5Гкал/цаг)-аар илүү буюу 60 хувиар хэтэрсэн ачаалалтай байна.

2024 оны байдлаар нийт дулааны төв шугамын 18.5% хувь буюу 70.8 км шугам нь 30-аас дээш жил ажиллаж насжилтын хугацаа дууссан, ашиглалтын байдал муудаж гэмтэл гарах эрсдэлтэй болсон байна.



**Улаанбаатар хотын цахилгаан хангамж одоогийн байдал:**

Улаанбаатар хотод цахилгаан дамжуулах 928,8км цахилгаан дамжуулах агаарын шугамаар 220, 110кВ-ын 28 дэд станцыг дамжуулан тэжээж байна.

Түгээх сүлжээний 35кВ-ын 34 дэд станц, ил хуваарилах байгууламж байгаагийн тал хувь нь 30 аас дээш жил ашиглагдсан насжилт өндөртэй станцууд ашиглагдаж байгаа ба 6, 10кВ-ын 11713км шугамаар хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

2023 оны өвлийн их ачааллын үед нийслэлийн хэрэглэгчдийн цахилгаан ачаалал 1058МВт хүрсэн бөгөөд цахилгаан хангамжийн эх үүсвэрийн чадал нэмэх зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн байна.

Ус хангамж, ариутгах татүүргын өнөөгийн байдал:

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын усны нөөц, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор 2030 оны түвшинд Нийслэл хотын хүн амыг нийт хүн амын 50,3% байхаар тооцсон байна. 2020 оны байдлаар төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээгээр нийт хүн амын 46,0 хувийг хангаж, Улаанбаатар хот орчимд нийт 286800 м<sup>3</sup>/хон нөөц бүхий 7 эх үүсвэрээс ф80-ф800 мм-ийн голчтой 586 км урт цэвэр усны шугамаар цэвэр ус түгээж цэвэрлэгдсэн усыг ф100-ф1400 мм голч бүхий 236 км бохир усны шугамаар татан зайлуулж 190-210 мянган м<sup>3</sup>/хон хүчин чадал бүхий 8 цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэршүүлж байна.

Гэр хороолол, амины сууцанд нийт хүн амын 20 хувь төвлөрсөн шугаманд холбогдсон ус түгээх 320 байруудаар үйлчлүүлж, гэр хороололд 4 усан санг 193 км цэвэр усны төвлөрсөн шугамаар холбосон байх бөгөөд шугаманд холбогдоогүй 294 байранд зөөврөөр ус түгээж байна.

Цаашид 2040 оны түвшинд Улаанбаатар хотын хүн амын өсөлтөөс хамаарч усны хэрэглээ 272,5 мянган /м<sup>3</sup> болох ба нийт усны хэрэглээний 59 % буюу 160 мянган м<sup>3</sup>/хоног усыг хотын хүн амын унд ахуйн хэрэглээнд зориулж гүний усаар хангаж, дээд, төв, яармаг, Буянт-Ухаагийн гүний усны эх үүсвэрүүдийг унд ахуйн хэрэглээнд ашиглахаар төлөвлөсөн байна. Шинээр баригдах бохир усны цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн усыг ДЦС- II, III, IV-ийн технологийн хэрэгцээнд ашиглаж, цашид эдгээр ДЦС болон үйлдвэр, комбинатын гүний усны нөөцийг ирээдүйн хэрэглээний нөөц болгожээ. Мөн гадаргын усыг боловсруулж хотын усан хангамжийн хэрэгцээнд ашиглахаар Туул, Сэлбэ, Толгойт, Улиастайн голыг түшиглэн усан цөөрөм барьж байгуулах ба Улаанбаатар хотын 2040 оны нийт унд ахуйн усны хэрэглээний 24 хувь буюу 65,4 мянган м<sup>3</sup>/хоног усыг гадаргын усаар, 17% буюу 46,3 мянган м<sup>3</sup>/хоног усыг цэвэршүүлсэн усаар хангахаар зорилт дэвшүүлсэн байна.

Төв цэвэрлэх байгууламж нь хоногт дундажаар 190000-210000м<sup>3</sup> бохир усыг хүлээн авч механик болон биологийн цэвэрлэгээг хийн, хэт ягаан туяагаар халдваргүйжүүлж Туул голд нийлүүлж байгаа ба хүчин чадлаасаа усны хэмжээний хувьд 20-40 мянгаар их, бохирдлын хэмжээний хувьд 2-5 дахин их усыг хүлээн авч байна. Цэвэрлэх байгууламжид ирж байгаа болон цэвэрлэгдэн гарсан усны бохирдолтын хэмжээг стандарттай харьцуулахад 2-9 дахин их байна. Сүүлийн жилүүдэд хүлээн авч байгаа бохир усны хэмжээ болон бохирдолт эрс нэмэгдсэн бөгөөд "БОХИРДУУЛАГЧ ҮЙЛДВЭРҮҮД" гэсэн ангилалд хамаардаг 225 үйлдвэр аж ахуйн газрууд бохирдсон усаа нийлүүлж байна. Харгиа цэвэрлэх байгууламжид MNS 5582:2006 стандартаас 1.5-2 дахин өндөр бохирдолтой ус хүлээн авч бохирдлын хэмжээг 2-3 дахин бууруулж төвийн шугамд нийлүүлж байгаа боловч төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх MNS 6561:2015 стандартын шаардлагыг хангахгүй байна.

Гачуурт тосгоноос Төв цэвэрлэх байгууламж хүртэл 30,0 км "Туул-1" коллекторын ажил 4 үе шаттайгаар 2007 оноос хойш хийгдэж, одоогийн байдлаар 19,5 км шугам ф600-ф1500мм-ийн шугам хэсэгчлэн хийгдсэн бөгөөд үлдсэн 11,5 км шугамын трассын дагуух газар чөлөөлөлтийн болон барилга угсралтын ажлыг дуусгах шаардлагатай байна.

Нийслэлийн хэмжээнд бохир усны шугам сүлжээний насжилт өндөр, хурын болон хөрсний ус шугам сүлжээ хийгдээгүйн улмаас хөрсний усыг бохир усны шугаманд зайлуулж байгаа нь цэвэрлэх байгууламжийн ачааллыг ихээр нэмэгдүүлж байна. Мөн Төв цэвэрлэх байгууламжийн төслийн технологийн шаардлагатай уялдуулан арьс шир, ноос ноолуурын


үйлдвэрүүдийг хотоос шилжүүлэх, Харгиа цэвэрлэх байгууламжийг татан буулгах шаарлагатай байна.

Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих ажлыг Хятад, Монголын Засгийн газар хоорондын гэрээгээр 2020-2025 оны хооронд хийх ба хүчин чадлыг нь нэмэгдүүлж, технологийн шинэчлэлт хийх, усыг дахин боловсруулж, техникийн ус гаргах ус боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулж, үйлдвэрлэл, техникийн болон ногоон байгууламжийн усалгааны системд ашиглахаар төлөвлөсөн байна.

Мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн өнөөгийн байдал:

“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн Улаанбаатар хотын салбар нь нийслэл хотын хэмжээнд 7 станцын хүрээнд 9181 ширхэг худаг, 646.318 метр сувагчлалын ашиглалт үйлчилгээг хариуцан ажилладаг байна. Улаанбаатар хотын хэмжээнд 258 ширхэг хуваарилах шүүгээ, 50 ширхэг MSAN, 170 чиглэлийн шууд кабель, 3608 агаарын багана, 22308 ширхэг телефон цэг байна. “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК нь 121 аж ахуйн нэгж, байгууллагад давхардсан тоогоор 5903,9 км сувагчлал, 79,727 ширхэг худагт түрээслүүлэх үйлчилгээ үзүүлж байна.

Улаанбаатар хотын мэдээлэл холбооны гол сувагчлал болон Станцуудын байршил



Нийслэл хотын нийгэм, эдийн засаг, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж, хүртээмж, хүчин чадал, найдвартай байдал чухал бөгөөд эдгээрийг шийдвэрлэхэд сайтар боловсруулсан бодлого, төлөвлөгөө, зохион байгуулалтын ажил шаардлагатай байгаа бөгөөд УИХ-ын 2024 оны “Хот байгуулах тухай” 72, 76 дугаар тогтоолуудаар нийслэлийн нутаг дэвсгэрт буюу төвийн 6 дүүрэгт орон нутгийн зэрэглэлтэй 14 хотыг, алслагдсан Багануур, Налайх дүүрэгт улсын зэрэглэлтэй 2 хотыг, Багахангай, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн захын хороодын нутаг дэвсгэрт болон Төв аймгийн нутаг дэвсгэрт 3 дагуул хотыг байгуулахаар шийдвэрлэсэн нь нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дэд бүтцийн хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

### 1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх боломжтой гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
Хүн ам	Хот төлөвлөлт, хот байгуулалтын бүсчлэлээс шалтгаалж, Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий дэд төвүүдийг шинээр байгуулах, гэр хорооллыг орон сууцжуулах төслийн хүрээнд газар чөлөөлөлт хийх, нөхөн олговор олгох.
Өмчийн бүх хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага/ хуулийн этгээд/	Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгээр дагуул хотуудад нүүлгэн шилжүүлэх, шинэ бүтээн байгуулалт, дэд бүтцийг өргөжүүлэх газар чөлөөлөлт, нөхөн олговор олгох.

### 1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Монгол Улсад сүүлийн 20 жил эрчимтэй явагдсан орчин үеийн хотжилт, хүн амын болон үйлдвэр, аж ахуйн газруудын төвлөрлөөс үүдэн Улаанбаатар хотод 2024 оны хагас жилийн байдлаар 1.7 сая буюу манай улсын нийт хүн амын 48.6% нь Улаанбаатар хотод оршин сууж<sup>26</sup>, хүн амын нягтаршил хэтэрсэн нь авто замын түгжрэл үүсгэж, агаар, хөрс, гадаргын болон гүний ус ихээр бохирдож, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, хотжилт нэмэгдэх тусам ерөнхий төлөвлөгөөний үндсэн зарчим, хот төлөвлөлт болон хот байгуулалтын үйл ажиллагаа алдагдах, газар ашиглалтын зориулалт, хэмжээг өөрчлөх, хууль тогтоомж зөрчин барилга байгууламж барих зэргээс шалтгаалан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх сөрөг үр дагавар гарч байна.

Ийм учраас нийслэл Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн амьдралд тулгамдаж буй асуудлууд, түүний дотроос иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах, ХЕТ-г хэрэгжүүлэх болон хяналтын тогтолцоо, хүлээх хариуцлагын механизмыг тодорхой болгох, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай байна.

<sup>26</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. <https://www.nso.mn/mn/statistic/fun-statistic/population>;

## ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

**Ерөнхий зорилго:** Оршин сүүгчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах бүрэн эрхийг хангасан, иргэн төвтэй, байгаль орчинд ээлтэй технологид сүүрилсэн, Монгол Улсын хөгжлийн хөтөч болсон, олон үлсад өрсөлдөх чадвартай хот болох

Учир нь өмнөх бүлэгт тодорхойлсончлон нийслэл Улаанбаатар хотод тулгамдаж байгаа асуудал нь

**Тусгай зорилго:** “20 минутын хот” үзэл баримтлал бүхий хотуудын нэгдэл болж хөгжих.

## ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Оршин сүүгчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах бүрэн эрхийг хангасан, иргэн төвтэй, байгаль орчинд ээлтэй технологид сүүрилсэн, олон үлсад өрсөлдөх чадвартай хот болох” ерөнхий зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа, хувилбаруудыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах эерэг өөрчлөлтийг дараах дүгнэлтээр гаргалаа.

*Хүснэгт 1. Асуудлыг зохицуулж болох эерэг болон сөрөг талууд*

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй асуудал хэвээр үргэлжлэх буюу зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй. Тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй ч иргэдийн идэвхи, хяналт нэмэгдэж асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөөтэй. Асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй.	Багагүй хэмжээний зардал гарах боловч асуудлын гол шалтгааныг бүрэн шийдвэрлэхгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй.
3	Хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Тулгамдсан асуудлыг хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зорилгодоо хүрэх бүрэн боломжтой.	Зохих хэмжээний зардал гарах боловч асуудлыг бүрэн шийдвэрлэх үр нөлөөтэй.	Үр дүн эерэг Зорилгод хүрэх боломжтой.
4	Удирдлага, зохион байгуулалтын оновчтой шийдэл сонгох	ЕТ-ний хэрэгжилтэнд хяналт тавих институтийн чиг үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эерэг нөлөөтэй боловч холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр зорилгодоо хүрэх боломжгүй.	Зохих хэмжээний зардал гарах боловч асуудлыг бүрэн шийдвэрлэх үр нөлөөтэй.	Үр дүн эерэг боловч хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулснаар зорилгод

5	Хувийн хэвшилтэй хамтран ажиллах, олон нийтийн оролцоог хангах	Зорилгод хүрэх боломж бий болгох нэг хүчин зүйл мөн боловч холбогдох хууль тогтоомжид ХЕТ-г хэрэгжүүлэх талаар төр, хувийн хэвшлийн түншлэл болон олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг нарийвчлан тусгах шаардлагатай.	Багагүй хэмжээний зардал гарах бөгөөд холбогдох хууль тогтоомжид ХЕТ-г хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг тусгаснаар үр дүнд хүрнэ.	хүрэх боломжтой
---	--	--	--	-----------------

Асуудлын мөн чанар, нийгмийн хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудлыг харгалзан Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах бүрэн эрхийг хангасан, иргэн төвтэй, байгаль орчинд ээлтэй технологид сүүрилсэн, олон улсад өрсөлдөх чадвартай хот болох ерөнхий зорилго болон “20 минутын хот” үзэл баримтлал бүхий хотуудын нэгдэл болж хөгжих түсгэй зорилгын хүрээнд дараах 2 хувилбарыг сонгон авч дэвшүүллээ.

**Хувилбар 1.** Хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах замаар Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний эрх зүйн орчинг сайжруулах:

- Хот байгуулалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид ХЕТ-г нэг нэршилтэй болгох талаар нэмэлт, өөрчлөлт оруулж нэр томъёог цэгцлэх;
- 20 жилийн төлөвлөлт хийх асуудлыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирлагын тухай хуульд тусгах;
- Хот байгуулалтын тухай хуульд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн хөгжлийн төлөвлөлтийн үе шат болон ногоон бүсийн зохицуулалтыг нэмж тусгах;
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д ХЕТ-ний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийх зохицуулалт тусгах;
- авто зогсоолгүй барилга байгууламжууд замын сүлжээг хязгаарлаж, уулзвар гарцын нэвтрэх чадварыг бууруулдаг, авто замын уулзвар, гарц, гол зам дагуух худалдаа, үйлчилгээний цэг, замын хажуугийн ташуу хэлбэрийн зогсоол, нэгдүгээр эгнээнд тээврийн хэрэгсэл байрлуулж замын хөдөлгөөний эрчмийг сааруулж зохиомол түгжрэл үүсгэдэг, ногоон байгууламжийн хүртээмжийг бууруулдаг зэрэг тулгамдсан асуудлыг зохицуулсан Авто зогсоолын тухай, Ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл боловсруулах;
- Барилга байгууламжийн дизайн, өнгө үзэмж, хэв маягийн нэгдсэн стандарт тогтоох;
- Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хариуцлага хүлээх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах гэх мэт.

**Хувилбар 2.** ХЕТ-г боловсруулах, хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын оновчтой шийдэл сонгох:

- Хотын хөгжлийн орчин үеийн онолын чиг хандлагад үндэслэх;
- хотын онцлог, давуу талыг нээн илрүүлж, “20 минутын хот”-уудаар дамжуулан олон төвт хотын бүтцийг бий болгох;
- байгаль орчны тогтвортой байдлыг хангаж, үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлэх;
- иргэд оршин суугаа газраасаа 300-500 метрийн зайд өдөр тутмын хэрэгцээт нийгмийн дэд бүтцээр хангагдах, худалдаа, үйлчилгээг авах боломжтой хотуудыг

төлөвлөж, ногоон байгууламж бүхий гудамжуудтай амьдралын таатай хэв маягийг бүрдүүлэх;

- хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрийг оновчтой хуваарилах.

## ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгон авсан хувилбаруудын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар шалгуур үзүүлэлтийн дагуу тандан судалж нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

### 4.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дах хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, 16 дугаар зүйлийн 16.1.2 дах хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; 16 дугаар зүйлийн 16.1.3 дах хэсэгт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэсэн нь хүний эрх, өмчлөх эрхийг хамгаалсан эрх зүйн зохицуулалт юм.

Хүснэгт 1

### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	ЕТ-ний дагуу тодорхой шаардлага, хязгаарлалт тавигдах боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш тул сөрөг нөлөөгүй.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.2.Оролцоог хангах			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох төрийн болон ТББ, ААНБ, мэргэжилтэн, судлаачдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээлэл солилцсон. Ямар нэг сөрөг нөлөөгүй.	

	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Зорилтот бүлгийг тодорхойлж, үр нөлөөг тооцсон. Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	ЕТ-ний дагуу тодорхой шаардлага, хязгаарлалт тавигдах боловч энэ нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхэд зөрөг нөлөөтэй.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	ЕТ-ний дагуу тодорхой шаардлага, хязгаарлалт нь хүний эрхийг хамгаалах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Уг асуудлыг холбогдох хуулиар зохицуулах бөгөөд ямар нэг сөрөг нөлөөгүй.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	ЕТ-ний дагуу тодорхой шаардлага, хязгаарлалт тавигдах боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш тул сөрөг нөлөөгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	ЕТ-ний дагуу тодорхой шаардлага, хязгаарлалт тогтоосон нь нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд зайлшгүй шаардлагатай бөгөөд ямар нэг сөрөг нөлөөгүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Иргэн, ААНБ, Төрийн байгууллага
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Улс, нийслэлийн төр захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээд үүрэг хүлээх ба ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

#### 4.2 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Нийслэл Улаанбаатар хотын эдийн засгийн үр нөлөөг тооцох гол үзүүлэлт болох ДНБ одоогийн байдлаар 24.3 их наяд төгрөг байгаа бол энэ үзүүлэлт 2040 онд 4.6 дахин өсөж 112.3 их наяд төгрөгт хүрнэ гэж тооцоолсон байна:

- Улаанбаатар хотын 1 хүнд ногдох ДНБ одоо 5700 ам.доллар байгаа бол 3.3 дахин өсч 2040 онд 18900 ам.долларт хүрнэ.
- Одоогийн байдлаар 509.2 мянган ажлын байр байгаа бол 2040 онд 835.1 мянгад хүрч шинээр 325.9 ажлын байр нэмэгдэнэ. Үүнээс Улаанбаатар хотод 171.9 мянган ажлын байр, дагуул хотуудад 154.0 мянган ажлын байр шинээр нэмэгдэнэ.

Хүснэгт 2

#### ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр ААНБ-д шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	3.3. Зах зээлээс бараа бүтээгдэхүүн худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	ЕТ-ний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, төрөлжүүлэх, зарим ААНБ, төрийн байгууллагыг нүүлгэн шилжүүлэх шаардлага тавигдах боловч үйл ажиллагааг нь зогсооход чиглэхгүй тул сөрөг нөлөөгүй.	
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нөлөөгүй	нэг сөрөг
	7.3. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй		

	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	ХЕТ-ний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, хариуцлага тооцох чиг үүрэгтэй холбоотой зохицуулалт хийх шаардлагатай. Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ажлын байрны тоо нэмэгдэх тул ямар нэг сөрөг нөлөөгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

#### 4.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 3

#### НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2.Ажлын стандарт,	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

хөдөлмөрлөх эрх	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Амьдрах орчин, амьдралын чанар дээшлэнэ. Ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Амьдрах орчин, амьдралын чанар дээшлэх тул амьдралын хэв маягт эерэг нөлөө үзүүлнэ. Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	"20 минутын хот"-ыг төлөвлөж, хөгжүүлнэ. Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	“20 минутын хот”-ыг төлөвлөж, хөгжүүлнэ. Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	“20 минутын хот”-ыг төлөвлөж, хөгжүүлнэ. Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	“20 минутын хот”-ыг төлөвлөж, хөгжүүлнэ. Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

Иргэдийн дундаж наслалт 2020 оны байдлаар 70.7 нас байгаа бол 2040 онд 77.3 нас болж нэмэгдэх ба үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 73.9, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 80.9 насанд хүрэх төсөөлөл гарсан байна<sup>27</sup>.

Он	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
2000	60.4	66.1	63.2
2005	62.1	68.6	65.2
2010	64.9	72.3	68.1
2015	66.0	75.8	69.9
2020	66.7	76.2	70.7
2025	67.3	76.6	71.8
2030	68.9	77.3	73.0
2035	71.7	78.8	75.2
2040	73.9	80.9	77.3
2045	74.8	82.8	78.7
2050	75.0	84.0	79.4

<sup>27</sup> Үндэсний статистикийн газрын мэдээлэл. [https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Population\\_growth\\_age\\_group\\_2020.pdf&ln=Mn](https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Population_growth_age_group_2020.pdf&ln=Mn)

Мөн түүнчлэн Улаанбаатар хотод одоо байгаа орон сууцны хангамжийн түвшин 53%-иас сайжирч 2040 онд 100%-д хүрнэ. Дагуул хотуудад одоо байгаа орон сууцны хангамж 17%-иас 2040 онд 76%-д хүрэх, боловсролын хүртээмж, хамрагдалтын хувьд 57.9%-ийн хангамжтай байгаа цэцэрлэг, 84.4% хүртээмжтэй сургуулийг 2040 онд бүрэн хангамжид хүргэх тооцоо, судалгаа гарсан байна.

#### 4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 4

#### БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
7.Нөхөн сэргээгдэх/сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүй зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

Ерөнхий төлөвлөгөөний архитектур орон зайн төлөвлөлтийн хүрээнд ногоон бүсийг 252,906 га талбайд төлөвлөх ба үүнд улсын ба орон нутгийн ТХГ, ойн сан бүхий газрын бүс, голын хамгаалалтын бүсийг хамааруулна. Одоо байгаа мод үржүүлгийн газруудыг 10 дахин буюу 9 байршилд 1310 га талбайд жилдээ 13 сая орчим 2040 онд 190 сая тарьц суулгац бий болгохоор төлөвлөсөн ба агаарын чанарыг үе шаттайгаар дээшлүүлэх арга хэмжээг авах, гэр хорооллыг шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөх, барилгажуулах, газар хамгаалах, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Ерөнхий төлөвлөгөөний баримт бичигт Ногоон бүсийн захиргаа байгуулахаар удирдлага, зохион байгуулалтын хувьд тусгасан. Улаанбаатар хотын бүсийн хэмжээнд экологийн 3 үндсэн коридор, 1 туслах коридор байгуулах төлөвлөлт, шийдэл хэрэгжсэнээр Экологийн коридорын чухал үүрэг нь нь (гал түймэр, өвчин, генетикийн гажуудал, цус ойртох) г.м сөрөг үр дагавраас сэргийлж цөөрсөн эсвэл устсан популяци өсөхөд чухал үүрэгтэй.

#### **4.5 Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ, бусад хуультай нийцэж буй байдал**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд зааснаар Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох зэргээр үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх ба тус хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээж байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад хүний зохийг хангах төрийн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэх зарчмыг баримтлах шаардлагатай бөгөөд ХЕТ-г баталж, түүний хэрэгжилтийг хангах, зохицуулалтыг боловсронгуй болгох нь иргэд Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй ая тухтай орчинд амьдрах үндсэн эрхээ эдлэх, баталгаагаар хангагдах ач холбогдолтой байна.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын Олон Улсын гэрээтэй нийцүүлэх зарчим баримтална.

Тухайлбал, Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70 дугаар чуулганаар баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм. “Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” уриатай энэхүү баримт бичгийн агуулгад зорилгод нийцүүлэн УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл нь эдгээр баримт бичигтэй нийцүүлэх нь зүй ёсны шаардлага болж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистой хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон

харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд чиглэсэн тул Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл нь энэхүү хуулийн зохицуулалтын дагуу боловсруулагдах бөгөөд ингэснээр хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хуулиудын зохицуулалттай нийцэж, ямар нэг сөрөг нөлөөгүй болно.

### **ТАВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Энэ асуудлын хүрээнд бусад улсуудын хот төлөвлөлттэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Алмек корпораци, СиТи Ай Инженеринг Интернэйшнл ХХК, Ориентал консалтантс глобал ХХК хамтран Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааг 2022 онд хийж гүйцэтгэсэн судалгааг тухайлан авч үзлээ.

Энэхүү судалгаанд бусад улсуудын хот байгуулалт, төлөвлөлтийн талаарх туршлагыг жишээ болгон тусгасан<sup>28</sup> байх бөгөөд тэдгээрээс газар нутаг, хүн ам, тээвэр ложистик гэх мэт нөхцөл байдал нь Улаанбаатар хоттой ойролцоо хотуудыг сонгон авч тэдний хот төлөвлөлтийн туршлага, хууль эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг энэхүү судалгаанд ашиглалаа.

#### **А.Япон улсын Цүкүба сургалт-судалгааны хотын тухай:**

1950-аад онд Токио хотын хүн амын хурдацтай өсөлтөөс болж хэт ачаалалтай болсон Токио хотын төвлөрлийг сааруулах зорилгоор нийслэлийн зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор нийслэл Токио хотоосоо 50 км зайд орших газар тариалангийн бүс нутагт төрөөс санаачлан **Цүкүба сургалт-судалгааны хотыг** байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд шинжлэх ухаан, технологийн төвүүдээс (төрийн өмчит судалгааны хүрээлэн, их дээд сургууль) бүрдэх сургалт-судалгааны дүүрэг, түүний эргэн тойронд байрлах орон сууц, худалдаа үйлчилгээний байгууламж, аж үйлдвэрийн цогцолбор зэргээс бүрддэг байна. 1969 оны эхний төлөвлөгөөнд 4000 га талбайд (улсын байгууллагуудын барилга байгууламж 1,550 га, шинэ суурьшлын бүс 260 га, хувийн орон сууцны талбай 860 га, цэцэрлэгт хүрээлэн 28.5 га) 160,000 хүн ам амьдрахаар тусгагджээ.

Энэхүү хотыг байгуулах ажлыг дэмжих зорилгоор 1970 онд Цүкүба сургалт-судалгааны хотыг байгуулах тухай хуулийг баталсан байна. Уг хуулийг баталснаар төсөл хэрэгжүүлэх бүс нутаг болон төслийн оролцогч талуудын (Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, төслийн хэрэгжүүлэгч хот дахин төлөвлөлтийн агентлаг/UR) үүрэг хариуцлага тодорхой болсон байна. Мөн төрийн байгууллагууд шинээр байгуулагдаж байгаа хотруу нүүж очих, эрдмийн хорооллоос гадна ойр орчмын газар нутгийн хот байгуулалтын үйл ажиллагааг хуулийн хамрах хүрээнд багтааснаар бүс нутгийн хэмжээний бүтээн байгуулалтын ажил хэрэгжих боломжтой болсон. Ингэснээр орон нутгийн засаг захиргаа нүүлгэн шилжүүлэх ажлыг дэмжин ажилласан<sup>29</sup> байна.

<sup>28</sup> Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, Жайка, УБ.,2022 он

<sup>29</sup> Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-24 дэх талд. Жайка, УБ.,2022 он

Түүнчлэн уг хуульд “санхүүжилтийн эх үүсвэр”-ийг тодорхой зааж, Засгийн газраас төслийн санхүүжилтийг хийх, тэгэхдээ Засгийн газрын боломжит санхүүжилтийн эх үүсвэрт багтааж төслийг хэрэгжүүлэх үүрэгтэй байхаар хуульчилсан байна. Мөн орон нутгийн захиргаа, олон нийтийн байгууллагад хандаж санхүү, техник, технологи, мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх амлалт өгөх зэргээр тухайн төсөлд оролцох Засгийн газрын байр суурийг маш тодорхой зааж өгсөн байна.

**Хуулийн бүтэц, агуулгыг доор үзүүлбэл:**

**Нэгдүгээр бүлэг.Зарчим**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго: ...хот байгуулалттай холбоотой нэгдсэн төлөвлөлтийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлснээр .....Сургалт-судалгааны хотыг байгуулахын зэрэгцээ түүнд түшиглэсэн газар тариаланг хөгжүүлэх, нийслэл орчмын хүн амын хэт төвлөрлийг сааруулах...

2 дугаар зүйл.Тодорхойлолт

Хамрах хүрээ: Нийт 6 тосгон сууриныг хамруулах, Сургалт-судалгааны бүс, бусад бүс гэсэн 2 хэсэгт хуваах

**Хоёрдугаар бүлэг.Сургалт-судалгааны хот байгуулах төлөвлөгөө**

3 дугаар зүйл.Сургалт-судалгааны хот төлөвлөлтийн агуулга: Хүн амын болон газар ашиглалтын асуудлууд, нүүлгэн шилжүүлэх болон шинээр байгуулах байгууллагуудад зориулсан барилга байгууламжийг шинээр барих, тэдгээрт шаардагдах нийтийн аж ахуйн байгууламжууд, төрийн байгууллага, орон сууцуудыг барьж байгуулахтай холбоотой асуудлуудыг нийтэд нь хамарсан.

4 дүгээр зүйл.Сургалт-судалгааны хот байгуулах төлөвлөгөөг батлах: Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын сайд

5 дугаар зүйл.Сургалт-Судалгааны хот байгуулах төлөвлөгөөний өөрчлөлт  
6 дугаар зүйл.Нийслэл орчмыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулах

**Гуравдугаар бүлэг.Дагуул хотыг хөгжүүлэх бүсийн төлөвлөлт**

7 дугаар зүйл.Дагуул хотыг хөгжүүлэх бүсийн төлөвлөлтийн агуулга: Нийтийн аж ахуйн болон нийтийн эзэмшлийн байгууламжуудыг барьж байгуулах, газар тариаланд шинэ технологи нэвтрүүлэхэд шаардагдах байгууламжууд, хүн амын хэмжээнд тохируулан газар зохион байгуулалтыг хийх, нийслэл хот орчмыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдсан Сургалт-судалгааны хотын төлөвлөлтийг боловсруулах, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх

8 дугаар зүйл. Дагуул хотыг хөгжүүлэх бүсийн төлөвлөлтийг боловсруулах: Орон нутгийн засаг захиргаа боловсруулан Дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын сайд батлах

**Дөрөвдүгээр бүлэг.Сургалт-судалгааны хот байгуулах төлөвлөгөө болон Ойр орчмын төлөвлөлтийг хэрэгжүүлэх**

9 дүгээр зүйл.Хэрэгжүүлэгчид: Төр, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагууд, Хот дахин төлөвлөлтийн хүрээлэн, бусад холбогдох оролцогчид

10 дугаар зүйл.Хамтын ажиллагаа

11 дүгээр зүйл.Олон нийтийг мэдээллээр хангах

12 дугаар зүйл.Хэрэгжилтийн нөхцөл байдал: Засгийн газраас парламентад төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах

13 дугаар зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр: Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Засгийн газар бүрдүүлэх ба төрөөс тогтоосон санхүүжилтийн хүрээнд багтаан гүйцэтгэх. Мөн хэрэгжилтийг хангахад зайлшгүй шаардлагатай эдийн засгийн, санхүүгийн болон техник технологийн туслалцааг холбогдох байгууллагуудад үзүүлэх.

Энэ хуулийн дагуу Цүкүба сургалт судалгааны хотыг хөгжүүлэхдээ эхний ээлжинд улсын чанартай эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудыг нүүлгэн шилжүүлэх тухай хуулийг баталж хэрэгжүүлсэн байх бөгөөд зарим арга хэмжээний үр дүнгийн талаар авч үзвэл:

- анх Цүкүба сургалт, судалгааны хотод Токио дахь бүх их, дээд сургуулийг нүүлгэн шилжүүлж, 700 мянган хүн амтай хот байгуулах урьдчилсан төлөвлөгөөг хэлэлцэж байсан бол үүний дараа "Токио хотын нутаг дэвсгэр дээр заавал байх шаардлагагүй төрийн байгууллагын зарим нэгжийг (улсын сургууль г.м) нүүлгэн шилжүүлэх асуудлыг яаралтай хэлэлцэх" тухай Засгийн газрын шийдвэр гарсан байна. 1967 оны 9-р сард Засгийн газрын хуралдаанаар 6 яам, 36 байгууллагыг (түүний дараа 43 болж нэмсэн) нүүлгэн шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч ихэнх байгууллагын барилгын ажил эхлээгүй тул 1970 оны 5-р сард Цүкүба сургалт, судалгааны хотын Барилгын тухай хуулийг хэрэгжүүлж улсын төсвийн хөрөнгөөр барилга байгууламжийг төлөвлөгөөтэйгөөр барьж байгуулан нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх тогтолцоог бий болгожээ. Үүний үр дүнд Цүкүба их сургуулийн хамтаар 300 орчим эрдэм шинжилгээний байгууллага, 13,000 орчим судлаачийг нүүлгэн шилжүүлэх ажлыг 1980 онд дуусгасан;

- төрийн байгууллагуудыг нүүлгэн шилжүүлж дууссаны дараа 1982 онд хувийн хэвшлийн судалгаа, шинжилгээний цогцолбор (Токодай цогцолбор) байгуулагдаж, 1985 онд шинжлэх ухааны олон улсын үзэсгэлэн (экспо) зохион байгуулагдсанаар олон улсад танигдаж хувийн компаниуд ихээр суурьших болсон;

- хотын бүтээн байгуулалтын эхэн үед Засгийн газрын санаачилгаар орон сууц, худалдаа үйлчилгээний байгууламжийн бүтээн байгуулалт өрнөж байсан бол 1990 оноос хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалт эрчимжсэн;

- төр, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагаа идэвхжиж, олон улсын байгууллагууд үйл ажиллагаагаа өргөжүүлж эхэлсэн;

- 1970 онд 78,110 хүн амтай байхаар төлөвлөсөн хотын хүн ам эхний 10 жилд 127,401 болж анхны төлөвлөгөөнөөс 1.6 дахин, 50 жилийн дараа 2020 онд 240,383 болж 3 дахин нэмэгдсэн;

- 2005 онд Токиотой холбосон төмөр замын хурдан галт тэрэгний шугам Цүкүба экспресс нээгдсэний дараа шугам дагуух үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалтын ажлыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хийж гүйцэтгэх болсон байна.

Дагуул хот байгуулах жишээ 1: Цүкүба шинжлэх ухааны хот (Tsukuba Science City)



Цүкүба сургалт, судалгааны хотыг Судалгааны хот байгуулалтыг дэмжих төв зөвлөлөөс боловсруулсан бодлого, төлөвлөлтийн дагуу Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам голлох үүрэг гүйцэтгэн барилгын ажлыг хийж, хотын барилгын төслийг тус бүрийн холбогдох хуулийн дагуу Хот сэргээн босгох байгууллага, холбогдох яам, агентлаг, Ибараки мужийн захиргаа, Цүкүба хотын захиргаа болон бусад холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлжээ.

1963 оны сургалт-судалгааны хот байгуулах тухай Засгийн газрын тогтоол гарахаас өмнө нийслэлийн хүн амын төвлөрлийг сааруулах зорилгоор Нийслэлийн хөгжлийн хороо (Одоогийн Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам) нь эрдмийн хот, төрийн байгууллагууд байрлах хот, нийслэлийн дагуул хотуудын хот байгуулалт, хотын хөгжлийн үзэл баримтлалыг хэлэлцэж байжээ. 1963 оны сургалт-судалгааны хот байгуулах тухай Засгийн газрын тогтоол гарсны дараа холбогдох яам, агентлагийн уялдаа холбоог зохицуулах, төслийн явцыг эрчимжүүлэх зорилгоор Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын сайдаар ахлуулсан холбогдох яамдын төрийн нарийн бичгийн дарга нараас бүрдсэн Сургалт-судалгааны хотын барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх төв зөвлөл байгуулах Засгийн газрын шийдвэр 1964 онд гарчээ. Энэхүү төв зөвлөл нь “Цүкүба сургалт-судалгааны хотын хот байгуулалтын төлөвлөгөөний тойм зураглал”, “Цүкүба сургалт-судалгааны хотын олон нийтийн барилга байгууламж барих төлөвлөгөөний тойм”, “Цүкүба сургалт-судалгааны хот руу байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний тойм”

<sup>30</sup> Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-17 дахь талд. Жайка, УБ.,2022.

болон Цүкүба сургалт-судалгааны хот байгуулах тухай хуульд үндэслэн “Эрдмийн (сургалт-судалгааны) хороолол барих төлөвлөгөө”-г боловсруулсан байна. Барилгын ажлын нэгдсэн зохицуулалтыг Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яамнаас хийж, мастер төлөвлөгөө боловсруулах, газар чөлөөлөх, инженерийн бэлтгэл ажлыг хийх зэрэг суурь дэд бүтцийн ажлыг Японы орон сууцны корпорац (Одоогийн Хот дахин төлөвлөлтийн агентлаг (UR) гүйцэтгэсэн байна<sup>31</sup>.

Энэхүү арга механизм нь Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, задлах зорилгоор нийслэлийн дагуул хот Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг батлан хэрэгжүүлж байгаа үйл явцтай нийцэж байгаа бөгөөд энэ туршлагаар Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд шинээр байгуулах дагуул хотын төлөвлөлтийн талаар тусгах нь зүй ёсны шаардлага болж байна.

### **Б.Япон улсын Макүхари шинэ төвийн бүтээн байгуулалтын тухайд:**

Макүхари шинэ төв нь Токио хот, Нарита нисэх онгоцны буудлын дунд, Токио хотоос 30 орчим км зайд байрлах далайг булж барьсан 552 га талбайд төлөвлөгдсөн, мужаас хэрэгжүүлсэн хот байгуулалтын төсөл юм. Төлөвлөгөөнд 36,000 (2008 онд 26,000 байсан) хүн амтай, 150,000 ажлын байртай байхаар тусгагдсан байна. Нарита нисэх онгоцны буудалд ойрхон тул олон улсын бизнесийн чиг үүрэг хэрэгжүүлэх хүрээнд жуулчид хүлээн авах зочид буудал, аутлет зэрэг худалдаа үйлчилгээний байгууламж, Нарита нисэх онгоцны буудлын ачаа тээвэрлэлт түгээлтийн агуулах зэргийг барьж байгуулсан нь Шинэ Зуунмод төслийн функцтэй төстэй гэж Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны баг үзсэн ба энэхүү судалгааны тайланд дараах арга хэмжээ, тоо баримтыг чухалчлан үзсэн:

- Макүхари Мессе үзэсгэлэнгийн танхимыг түшиглэн олон улсын бизнес, орчин үеийн дэвшилтэт, хөгжиж буй аж үйлдвэрийн салбар голчилсон судалгаа хөгжүүлэлт, дэвшилтэт технологийн салбарт тохирсон өндөр ур чадвар бүхий хүний нөөцийг хөгжүүлэх эрдэм шинжилгээ, боловсролын байгууллагуудыг багтаасан шинэ эрин үеийн нийгмийн хэрэгцээ, амьдралын хэв маягт тохирсон ажил, орон сууц, боловсрол, энтертейнмент гэсэн 4 үндсэн цогц функцийг нэгтгэсэн үзэл баримтлал бүхий олон улсын бизнесийн хот болох зорилготойгоор байгуулагдсан. Гэхдээ энэ бүтээн байгуулалт нь төмөр замтай, дэргэдээ суурьшлын бүстэй байршилд хийгдсэн учир, гаднаас ирж ажиллах хүн амын тоог нэмэгдүүлэх тал дээр гол анхаарлаа хандуулан, соёл боловсролын байгууллага, амралт зугаалгын газар, аж ахуйн нэгжийн барилга байгууламж барих зэрэг ажлаас бүтээн байгуулалтыг эхлүүлсэн байна.
- 1975 онд боловсруулсан үндсэн төлөвлөгөөний дагуу соёл-боловсролын бүс 1981 онд байгуулагдаж эхэлсэн ба 1985 онд батлагдсан хот байгуулалтын суурь төлөвлөгөөний дагуу хотын дэд бүтэц, 72 га хиймэл эрэг бүхий далайн эргийн цэцэрлэгт хүрээлэн, 54,000 га үзэсгэлэнгийн байгууламж (дараа нь 72,000 га болж өргөтгөсөн), мэргэжлийн бейсболын цэнгэлдэх хүрээлэн, бизнесийн хороолол барих бүтээн байгуулалтыг хийсэн. 1995 онд орон сууцны барилга ашиглалтад орж, иргэд шилжин суурьшиж эхэлж, оршин суугчдын тоо 2001 онд 10 мянга байсан бол суурь төлөвлөлт боловсруулснаас хойш 30 жилийн дараа буюу 2006 онд 20 мянга давсан байна.

<sup>31</sup> Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-23 дахь талд. Жайка, УБ.,2022.

- 2016 оноос нийт 17,5 га талбайд 10,000 оршин суугчтай, 4,500 орчим айлын өндөр давхрын 6 орон сууцны барилгыг тойрсон офис, худалдаа үйлчилгээний төв бүхий шинэ хотхоныг цогцоор байгуулах ажлыг эхлүүлэн одоо ч төсөл хэрэгжих шатандаа явж байна.
- төмөр замын шугамтай, ойр орчимдоо суурьшлын бүстэй тул боловсрол, судалгааны байгууллага, бизнесийн бүс болгон хөгжүүлэхээр зорьж хөдөлмөр эрхэлж буй хүн амыг суурин хүн амын тооноос олон байна гэж үзсэн байна. Гэтэл хөдөлмөр эрхэлж буй хүн амын тоо дөнгөж 40 мянга байгаа нь төлөвлөсөн хөдөлмөрийн хүн амын дөнгөж 27 хувьтай тэнцэж байна.

### Макухари шинэ төвийн бүтээн байгуулалтын агуулга<sup>32</sup>



### В.Япон улсын Тама шинэ суурины тухайд:

Тама шинэ суурины бүтээн байгуулалтыг 1963 онд батлагдсан Шинэ суурьшлын бүс хөгжүүлэх тухай хуульд үндэслэн хэрэгжүүлжээ. Энэ хууль нь хүн амын нягтрал хэт их хот, суурин газрын эргэн тойрны бүсэд дан орон сууцны хороолол барих, орон сууцаар хангагдаагүй иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлсэн орон сууцыг олноор нийлүүлэх зорилготой байсан ба бүс нутгийг бүхэлд нь суурь дэд бүтцээр хангах үүднээс дан ганц орон сууцаар зогсохгүй зам, цэцэрлэгт хүрээлэн, сургууль, эмнэлэг, худалдааны төв, оффис зэрэг хотын цогц үүрэг гүйцэтгэх шинэ хороолол барих бүтээн байгуулалт болсон байна.<sup>33</sup>

Энэ бүтээн байгуулалт нь Хачи-Ожи, Мачида, Тама болон Инаги гэсэн 4 хотыг хамарсан нийт 2,853 га, 14 км өргөн, 2-3 км урт газарт төлөвлөгдсөн, Токио хотоос

<sup>32</sup> Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-18 дахь талд. Жайка, УБ.,2022.

<sup>33</sup> Мөн тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-26 дахь талд. Жайка, УБ.,2022 он,

хэрэгжүүлсэн шинэ суурин байгуулах төсөл юм. 1963 онд төлөвлөлт эхэлсэн бөгөөд анх 300,000 оршин суугчтай, ажиллах хүн ам 50,000 байхаар тооцсон байв. 1971 онд анхны оршин суугчдаа хүлээн авсан ба 2019 оны байдлаар 220,000 хүн амтай болсон. Төсөл хэрэгжүүлэгч нь Токио хотын захиргаа, Токио хотын орон сууцны корпораци/UR. 1963 онд Өмнөд Тама хотын хот байгуулалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах хороо байгуулагдаж, ерөнхий төлөвлөгөөг боловсруулснаар төсөл эхэлсэн. 1966 онд холбогдох байгууллагын уялдааг хангах зорилгоор "Өмнөд Тама хот байгуулалтын захиргаа"-г Токио хотын захиргааны харьяанд байгуулж газар зохион байгуулалт зэрэг ажлыг хэрэгжүүлж, 1970 онд холбогдох хотуудтай тохиролцож 5 түвшний зохицуулалтын бүтцийг бий болгосон байна<sup>34</sup>. Үүнд:

Тама шинэ суурины бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх бүтэц

Бүтэц	Гишүүд
1.Төлөвлөлтийн хороо (Хотын захирагч ахалдаг дээд шатны хурал)	Хотын захирагч, дэд захирагч, холбогдох хотуудын дарга, Хот дахин төлөвлөлтийн агентлагийн дарга, Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн дарга, Шинэ хотын төв ХК-н захирал
2.Хэрэгжилтийг хангах зөвлөл (Бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах)	Өмнөд Тама шинэ хот байгуулалтын захиргааны дарга, тухайн захиргааны барилгын хяналтын дарга, холбогдох хотуудын даргын туслах, Хот дахин төлөвлөлтийн агентлагийн Өмнөд Тама хариуцсан газрын дарга, төрийн байгууллагуудын газрын асуудал хариуцсан байгууллагын дарга
3.Ажлын хэсэг (2-д дурдсан хорооны дэд хэсэг бөгөөд тулгарсан асуудлыг шийдэх)	Шинэ Тама хот байгуулалтын захиргааны төлөвлөлт хариуцсан нарийн бичиг, тухайн захиргааны болон холбогдох хотуудын төлөвлөлтийн албаны дарга, Хот дахин төлөвлөлтийн агентлагийн Өмнөд Тама бүтээн байгуулалтын нэгжийн, төрийн байгууллагын газрын асуудал хариуцсан албаны дарга
4.Шинэ хотхоны хуралдаан (хотын түвшний төлөвлөлтийн асуудалд чиглэсэн арга хэмжээ, судалгаа, шинжилгээ, иргэдийн хүсэлтийг сонсох)	Холбогдох хотуудын захирагч нар болон хурлын дарга нар
5.Шинэ хотын ажлын хэсэг (4.-т дурдсан хурлын дэд хэсэг бөгөөд хотын түвшинд ажлыг уялдуулах)	Холбогдох хотуудын дарга нар

Япон улсад Цүкүба, Макүхари 2 шинэ хот байгуулсан туршлагаас Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл нь боловсруулах үйл ажиллагаанд жишиг болгон ашиглах боломжтой санааг анхаарч үзэх нь зүйтэй юм.

- Цүкүба сургалт судалгааны хотод томоохон хотод байрлах шаардлагагүй эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургуулиудыг нийтэд нь нүүлгэх бодлого баримталсан байна.
- Цүкүба хот нь олон улсын экспо нээх замаар олны анхаарлыг татаж, олон улсын хурал зөвлөгөөнийг зохион байгуулж сургалт судалгааны хотын статусаа гадаад дотоодод таниулж ирсэн.

<sup>34</sup> Мөн тэнд.

- Мақұхари хотын хувьд цэнгэлдэх хүрээлэн, асар том үзэсгэлэнгийн танхимдаа төрөл бүрийн үзэсгэлэн худалдаа, концерт зэргийг зохион байгуулж хэрэглэгчдийг татан авчирч байна.
- Иргэд цуглах, зочид айлчлан ирэх боломжийг бий болгосноор олонд танигдаж, танил дотно мэдрэмж төрүүлэхийн зэрэгцээ орон нутгийн дүр төрхийг тодорхойлж, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэн бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг гэх мэт.

### Г.Казакстан улсын Астана хотын эрх зүйн зохицуулалтын тухайд:

Астана хот 2001 онд тус улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2027 оны 12-р сар хүртэл эдийн засгийн тусгай бүсийн статустайгаар албан ёсны үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан байна.

## 1) Бүсийн тойм/ онцлог

### Астана шинэ хот ЭЗТБ



1996 онтой харьцуулахад Астана шинэ хотын ЭЗТБ нь дараах байдлаар хөгжиж байна (2017 оны байдлаар);

- ДНБ: 187 дахин
- Хүн ам: 3 дахин
- \* Астана хот 2020 оны байдлаар 1.2 сая хүн амтай.
- Жилийн хөрөнгө оруулалтын хэмжээ: 40 дахин
- \* Астана хотын ЭЗТБ нь 15 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтын 2,5 тэрбум ам.долларыг хүлээн авсан.
- ЖДҮ-ийн тоо: 21 дахин



ЭЗТБ нь дараах чиглэлээр SMART-City технологийг нэвтрүүлэхээр чармайж байна;

- эрчим хүч хэмнэх
- Олон нийтийн үйлчилгээний тарифын төлбөр
- Ослын эрсдэлийг хянах

Астана хотын бүтээн байгуулалт, хөгжүүлэлтийг Эдийн засаг, аж үйлдвэрийн тусгай бүсийн тухай хууль (2011/19), "Астана-Шинэ хот"-ын тухай журам (2017)-аар зохицуулдаг байна.

Эдийн засаг, аж үйлдвэрийн тусгай бүсийн тухай хуулиар доор дурдсан харилцааг зохицуулж байна. Үүнд:

- Засгийн газрын чиг үүрэг, оролцоо /Төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий байгууллага, улсын төлөвлөлтийн газар, татвар, гааль, бүс, хот, нийслэлийн гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг, хэрэгжүүлэх ажлууд/;
- ЭЗТБ-ийг байгуулах, ажиллуулах, татан буулгах /ЭЗТБ байгуулах журам, ЭЗТБ-ийн үйл ажиллагааны нөхцөл, ЭЗТБ-ийн оролцогчоор үйл ажиллагаа эрхлэх болон үндсэн бус

үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг шалгах журам, ЭЗТБ-ийн тэргүүлэх ач холбогдолтой үйл ажиллагааны жагсаалтад оруулах журам, ЭЗТБ-д төрийн үйлчилгээ үзүүлэх, ЭЗТБ-ийг татан буулгах, ЭЗТБ-ийг удирдах компани байгуулах, чиг үүрэг, удирдлагын үйл ажиллагаа эрхлэх иргэдийг сонгох, ЭЗТБ-ийн оролцогчид болон үндсэн бус үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн эрх үүрэг, хэрэгжилтэд хяналт тавих, удирдах компанийн санхүүжилт/;

- ЭЗТБ-ийн удирдлага /ЭЗТБ-ийг удирдах компани байгуулах, чиг үүрэг, удирдлагын үйл ажиллагаа эрхлэх иргэдийг сонгох, ЭЗТБ-ийн оролцогчид болон үндсэн бус үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн эрх, үүрэг, хэрэгжилтэд хяналт тавих, удирдах компанийн санхүүжилт/;
- ЭЗТБ-ийн үйл ажиллагааны эрх зүйн тусгай дэглэм ба нөхцөл /ЭЗТБ-ийн тусгай эрх зүйн дэглэм, оролцогч/удирдах компаниудын татвар, гаалийн зохицуулалт, гаалийн чөлөөт бүсийн гаалийн журамд оруулсан бараа, ЭЗТБ-д гадаадын ажиллах хүч татах, ЭЗТБ-ийн оролцогчдын эрх зүйн хамгааллын баталгаа, ЭЗТБ-ийн төр, хувийн хэвшлийн түншлэл/.

Казахстан улс дээрх хуулийн дагуу нийт 13 ЭЗТБ байгуулсан байх бөгөөд эдгээрийн дотор "Астана Шинэ Хот" ЭЗТБ нь тусгай журмаар зохицуулагддаг. Энэ журмаар зорилго, дэмжих эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, менежмент, татвар, гаалийн дэглэм, гадаадын иргэдийг ажиллуулах, нэвтрүүлэх журам зэргийг тодорхойлсон байдаг.

Бусад улсуудын хувьд авч үзвэл эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн дагуу хотыг байгуулж, хөгжүүлж байгаа улсууд цөөнгүй байна.

Манай улсын хувьд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нийслэл эдийн засгийн тусгай бүстэй байх, эдийн засгийн тусгай бүсийг нийслэлийн нутаг дэвсгэр, дагуул хот болон бусад орон нутагт тухайн засаг захиргааны нэгжтэй тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын шийдвэрээр байгуулах зохицуулалт тусгагдсан<sup>35</sup> бөгөөд одоогийн байдлаар Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор СХД-ийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хүнсний ноноо, хүлэмж, агуулахын чиглэлээр "Агро сити", Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр "Налуу-Ухаа" эдийн засгийн тусгай бүсийг тус тус байгуулаад байна.

Ийм учраас Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд эдийн засгийн бүсийн асуудлыг тусгаж өгөх нь зүйтэй байна.

**Д.Япон улсын Кансай соёл, шинжлэх ухаан, судалгааны хот (Kansai Science City)-ын тухайд:**

Кансай хот 15 мянган га орчим талбайтай ба тооцоолсон хүн амын тоо 410,000 ба 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 254,000 хүн амтай болсон байна.

Соёл, эрдэм шинжилгээ, судалгааны дүүрэгтэй ба хотын бүтээн байгуулалтын ач холбогдол ба философи нь соёл, шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний шинэ хөгжлийн үндсийг бий болгох, Японд төдийгүй дэлхийн хэмжээнд соёл, шинжлэх ухаан, судалгааг хөгжүүлэхээс гадна улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, ирээдүйд анхдагч

<sup>35</sup> Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 38.1 дэх хэсэг.

мэдлэг бүтээгч хотын үндэс суурь болох явдал бөгөөд хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг 1987 онд батлагдсан Кансай соёл, шинжлэх ухаан, судалгааны хотын бүтээн байгуулалтыг дэмжих тухай хуулиар зохицуулж байна.

**Энэхүү хуулийн төслийн бүтцийг авч үзвэл:**

**1 дүгээр зүйл.Зорилго:** (Кансай соёл, шинжлэх ухаан, судалгааны хотын бүтээн байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, түүний хэрэгжилтийг дэмжсэнээр соёл, шинжлэх ухаан, судалгааны төв болох хотыг байгуулан манай улс болон дэлхийн соёлын хөгжил, үндэсний эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.)

**2 дугаар зүйл.Нэр томьёо**

**3 дугаар зүйл.Үндсэн зарчмыг тодорхойлох, өөрчлөх** (Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын сайд холбогдох мужийн захирагчийн саналыг хүлээн авч, холбогдох төрийн захиргааны байгууллагын удирдлагатай зөвшилцөн .....хотын хот байгуулалтын үндсэн зарчмыг тодорхойлно.)

**4 дүгээр зүйл.Үндсэн зарчмын агуулга**

**5 дугаар зүйл.Барилгын ажлын төлөвлөгөө боловсруулах** (Холбогдох байгууллагатай хамтран ажиллах, процедур зэрэг)

**6 дугаар зүйл.Барилгын ажлын төлөвлөгөөний агуулга**

**7 дугаар зүйл.Барилга байгууламж барих** (ЗГ-ын хариуцлага, дэмжлэг)

**8 дугаар зүйл. Санхүүжилт** (ЗГ-ын хариуцлага, дэмжлэг)

**9 дүгээр зүйл.Орон нутгийн бондын тухай заалт**

**10 дугаар зүйл.Татварын арга хэмжээ** (Аж ахуй нэгжийн татварын элэгдэл тооцох тусгай зохицуулалт)

**11 дүгээр зүйл.Орон нутгийн татварыг ялгавартай ногдуулах тухай**

**12 дугаар зүйл.Тариалангийн газрын тухай хуульд заасан зөвшөөрөл.**

Энэ хотын туршлагыг Улсын Их хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт байгуулагдсан 14 хотын төлөвлөлтийг Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд тусгахдаа харгалзаж үзэх боломжтой юм.

Энэ мэтчилэн гадаад орны туршлагаас харахад хот байгуулалтын суурь нь төлөвлөлт бөгөөд эдийн засгийн үр өгөөж, иргэдийн эрх, ашиг сонирхлыг нэгдүгээрт тавьсан байгаа нь Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд тавигдах үндсэн шаардлагатай нийцэж байна.

## **ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэсэн энэхүү судалгааны үндсэн дээр Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл боловсруулах, батлах асуудлыг нийслэлд тулгамдаж байгаа асуудал болон нийслэлээс бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид нийслэлийн дагуул хот байгуулж байгаа онцлогийг харгалзаж үзэх нь Үндсэн хууль болон олон улсын хотуудын төлөвлөлт, хөгжилтэй нийцэхээр байна гэж дүгнэж байна.

Үүний тулд дараах санал, зөвлөмжийг харгалзан үзэж холбогдох зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна. Тухайлбал:

- Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах бодлого баримтлах;
- Хот байгуулалттай холбоотой хууль тогтоомжийн зохицуулалттай уялдуулж, тэдгээрийг хэрэгжүүлэх боломжтой байдлаар төлөвлөх;
- Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгох;
- Нийслэлийн нутаг дэвсгэр дэх хотуудыг “20 минутын хот” үзэл баримтлалаар төлөвлөх;
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслийн төлөвлөлт;
- Төлөвлөлтийг хэрэгжүүлэх “санхүүжилтийн эх үүсвэр”-ийг тодорхой зааж, УИХ, Засгийн газар, нийслэл, орон нутаг уг санхүүжилтийг тодорхой хугацаанд, тодорхой хэмжээгээр заавал бүрдүүлэх үүрэгтэй байх;
- орон сууцны хороолол барих, орон сууцаар хангагдаагүй иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлсэн орон сууцыг нийлүүлэхийн тулд бүс нутгийг бүхэлд нь суурь дэд бүтцээр хангах, орон сууцаар зогсохгүй зам, цэцэрлэгт хүрээлэн, сургууль, эмнэлэг, худалдааны төв, оффис зэрэг хотын цогц үүрэг гүйцэтгэх шинэ хорооллыг барихдаа өмнөх алдаагаа давтахгүй байх, зөв төлөвлөх, төлөвлөлтөө зөрчихгүй байх, зөрчсөн тохиолдолд хатуу хариуцлага хүлээх нөхцөлийг бүрдүүлэх;
- төрийн байгууллага, их, дээд сургууль, МСҮТ, эрдэм шинжилгээний байгууллагуудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх зарчим, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх зарчмыг тогтоож, төрийн байгууллага манлайлах үүрэгтэй болохыг тодорхойлох, хувийн хэвшлийг урамшуулах, дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бий болгох;
- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг богино хугацаанд буюу ХЕТ батлагдсанаас хоойш 6 сарын дотор баталж хэрэгжүүлэх;
- ХЕТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн зохицуулалтын шинэчлэлтийг хийх, бүтэц, зохион байгуулалтыг бий болгох гэх мэт.

### Ашигласан эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
3. Хот байгуулалтын тухай хууль;
4. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
5. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль;
6. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/;
7. Газрын тухай хууль;
8. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль;
9. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
10. Агаарын тухай хууль;
11. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль;
12. Барилгын тухай хууль;
13. Орон сууцны тухай хууль;
14. Legalinfo.mn
15. Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70 дугаар чуулганаар баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”;
16. Нэгдсэн үндэсний байгууллагын “Хабитат-III” байгууллагаас 2016 онд батлагдсан “Хотжилтын шинэ хөтөлбөр”;
17. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”;
18. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
19. Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хот байгуулах тухай” 72, 76 дугаар тогтоол;
20. Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоол;
21. Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Үндэсний бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоол;
22. Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоол;
23. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үзэл баримтлал /концепци/-н дагуу боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар 12-ны өдрийн 35 дугаар хурлын тэмдэглэл;
24. Засгийн газрын 2020-2024, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
25. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
26. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/-г дэмжих тухай НИТХ-ын 2019 оны 28/26 дугаар тогтоол;
27. НИТХ-ын 2020 оны 32/04 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэл хотыг хөгжүүлэх хэтийн төлөв”;
28. Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлан. Жайка, УБ., 2022 он;
29. Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны 2022.05.30-ны олон улсын тээвэр логистикийн өнөөгийн байдал, импортын ачааны саатал, шийдлүүд танилцуулга;

30. Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө” 2020 он, Т-14;
31. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичиг” 2022 он, Т-4;
32. <https://ulaanbaatar.mn/home>, Үндэсний статистикийн хорооны мэдээлэл.

**УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2024 он

Агуулга	
Удиртгал.....	4
<b>НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ</b> .....	4
<b>ХОЁР. ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ</b> .....	6
2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ХЕТ-ний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал: .....	6
2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:.....	8
2.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал: .....	9
2.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:.....	9
2.5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал: .....	9
<b>ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ</b> .....	10
3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:.....	13
3.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:.....	18
3.3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ: .....	19
3.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ: .....	20
3.5.“Төлөвлөгөөний төслийн харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ: .....	21
<b>ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ</b> .....	23
4.1.Баримтжуулалт .....	23
4.2.Үнэлэлт, дүгнэлт .....	23
4.2.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр: .....	23
4.2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр: .....	23
4.2.3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтээр: .....	24
4.2.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр: .....	24
4.2.5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр: .....	25
4.3.Зөвлөмж .....	25
<b>ТАВ.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ</b> .....	26

## Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АҮ	Аж үйлдвэрийн
БНБД	Барилгын норм ба дүрэм
БЗД	Баянзүрх дүүрэг
ДЦС	Дулааны цаилгаан станц
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЕТ	Ерөнхий төлөвлөгөө
МАА	Мал аж ахуй
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ҮТП	Үндэсний технологийн парк
ХАА	Хөдөө аж ахуй
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
ЭЗ	Эдийн засаг

## **ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛСАН ТАЙЛАН** (Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тухай)

### **Удиртгал**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ гэж тусгасан. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалыг баталсан.

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслөөр одоо мөрдөж байгаа Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүтэц, зүйл, заалтын 50-иас дээш хувьд нь өөрчлөлт оруулж байгаа, уг төлөвлөгөөний төсөл нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан хууль тогтоомжид хамаарахгүй байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу судалгаа, шинжилгээг хийлээ.

Энэхүү судалгааны зорилго нь Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа, үүсэх үр дагавар зэргийг тооцох, эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зэргээр төлөвлөгөөний төслийн зохицуулалтыг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар төлөвлөгөөний төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн /цаашид “Төлөвлөгөөний төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх үйл ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 1.4-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлөвлөгөөний төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу төлөвлөгөөний төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

### **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Төлөвлөгөөний төслийн үр нөлөөг тооцохын тулд ерөнхий төлөвлөгөөний төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан үндсэн шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
5. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авахдаа дараахи үндэслэлийг харгалзан үзсэн болно. Үүнд:

*1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хувьд:*

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн дараахи зохицуулалт, холбогдох арга хэмжээ нь уг төлөвлөгөөний төслөөр тавьсан “Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангасан, иргэн төвтэй байгаль орчинд ээлтэй технологид суурилсан, олон улсад өрсөлдөх чадвартай хот болох” зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судлахад ашиглана.

Төлөвлөгөөний төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж Улаанбаатар хотын хөгжлийн бодлогыг шинээр тодорхойлж, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх нь иргэдийн эрүүл, аюулгүй, амьдралын таатай орчин бүрдүүлсэн, олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан, олон улсад өрсөлдөх чадвартай, иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурласан, сайн засаглал бүхий эдийн засаг, бизнес, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ гэж тусгасан байна.

Иймд дээрх зорилтод хүрэх ач холбогдол бүхий зүйл, заалт төлөвлөгөөний төсөлд тусгагдсан эсэхийг шинжлэнэ.

*2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хувьд:*

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн төлөвлөгөөний төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, төлөвлөгөөний төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгана.

*3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хувьд:*

Энэ шалгуур үзүүлэлтийн хувьд төлөвлөгөөний төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектын хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгадаг.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөтэй тул тухайн төлөвлөгөөний төслийн үг хэллэг нь хоёрдмол утга санаагүй, монгол хэл бичгийн дүрэмд нийцсэн, утга найруулгын хувьд зөв хэрэглэсэн эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан энэ шалгуур үзүүлэлтийг сонгосон.

**4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хувьд:**

Төлөвлөгөөний төслийн үйлчлэх хүрээ өргөн бөгөөд нийслэл хотод орших нутгийн захиргааны байгууллагаас гадна нийслэл хотын оршин суугч, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээх тул тэдний эрх, ашиг сонирхол хөндөгдөх, хязгаарлагдах шийдвэр гаргах нөхцөл байдал бий болох зохицуулалт төлөвлөгөөний төсөлд тусгагдсаныг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонголоо.

**5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хувьд:**

Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдох харилцаа нь олон талт бөгөөд бүх салбарын өргөн хүрээг хамардгийн дээр нийслэл хоттой холбоотой асуудал олон салбарын өөр өөр хуулиар зохицуулагддаг тул төлөвлөгөөний төслийн зохицуулалт нь хоорондоо эсвэл бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэх, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэх асуудлыг үнэлэх үүднээс энэ шалгуур үзүүлэлтийг сонгон авч төлөвлөгөөний төслийг бүхэлд нь судлан үзнэ.

**ХОЁР. ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Энэ хэсэгт төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зохицуулалтыг сонгоно. Зохицуулалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий зохицуулалтыг сонгон авлаа. Өөрөөр хэлбэл, төлөвлөгөөний төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс төлөвлөгөөний төсөлд шинээр нэмж орж буй, голлох ач холбогдол бүхий зохицуулалтыг сонгож, тухайн сонгож авсан зүйл, заалтын үр нөлөөг нь судлав.

Түүнчлэн уг төлөвлөгөөний төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсэж болохуйц, тодорхой субъектэд шинээр чиг үүрэг хүлээлгэж байгаа, тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр нэгж /газар, хэлтэс, тасаг гэх мэт/ бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрд авч үзэв. Үүнд:

**2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ХЕТ-ний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:**

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслөөс дараахи зохицуулалт, арга хэмжээг сонгон авч эдгээр нь нь уг төлөвлөгөөний төслөөр тавьсан зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судлахад ашиглана. Үүнд:

**1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨЛТ буюу 3.1 дэх хэсгээс:**

- а) Улаанбаатар хотын ойн санг 9 массив<sup>1</sup>-ын хязгаарт бүлэглэн хувааж, мод бэлтгэсэн талбай, шатсан талбай, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбайд

---

<sup>1</sup> Ойн санг бүлэглэн хуваах утгыг илэрхийлнэ.

нөхөн сэргээлт хийх болон одоо байгаа ойн сангийн хамгаалалтын бүсийг ой тэлэн ургах боломжит талбай 38,813 га буюу 33-иар нэмэгдүүлнэ;

- b) ойн сангийн хамгаалалтын бүсийн заагийг тодорхойлж нийт 155070 га талбайд газар ашиглалтын горим дэглэмийг шинэчлэн тогтооно;
- c) БЗД-ийн Цагаан даваа, СХД-ийн Нарангийн энгэр, Налайх, Багануур дүүрэгт аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж барьж байгуулах ба Эмээлтэд малын гаралтай өтөг бууц, хаягдал хүлээн авч бордоо бэлтгэх, Рашаантад ургамал, ногооны гаралтай түүхий эдийг хүлээн авч бордоо бэлтгэх, Морингийн даваа болон Налайхад барилгын хог хаягдлыг дахин боловсруулах, эрчим гаргах үйлдвэрүүдийг байгуулна.

## 2. ЗАМ ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭ ТӨЛӨВЛӨЛТ буюу 3.2 дах хэсгээс:

- a) Богдхан уулыг тойрон, Улаанбаатар-Шинэ-Зуунмод-Зуунмод-Майдар-Улаанбаатар хотуудыг холбосон цагираг нийтийн тээврийн үйлчилгээг хөнгөн галт тэрэг /хурдан трамвай/, автобусаар гүйцэтгэх ба чиглэлийн урт 135,2 км болно;
- b) Нийслэл хотын автобусны үйлчилгээний нийтийн зорчигч тээврийн үүрэг функцийг хэвээр хадгалах бөгөөд 14 дагуул хот суурингуудыг холбосон авто замын дагуу нийтийн тээврийн сүлжээгээр холбоно. Үйлчилгээг зорчигч урсгалын хэмжээнээс хамааруулан дунд болон том оврын зориулалтын нийтийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ;
- c) Багахангай, Багануур хотуудыг холбох авто замыг түшиглэн нийтийн тээврийг нэвтрүүлж, хотууд өөр хоорондоо холбогдон хөгжих нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
- d) Улаанбаатар хотын баруун зүүн хэсгүүдэд зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн төв буюу авто вокзалуудыг /22-н товчоо, Амгалангийн товчоо, Яармагийн уулзвар орчим/ барьж байгуулна.
- e) Туул, Сэлбэ, Улиастай голуудын дагуу амралт зугаалгын зориулалттай дугуйн зам байгуулж, хотын дугуйн замын сүлжээтэй холбоно;
- f) Их-Тойруу, дэд төвүүдэд оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх, гадаад, дотоодын аялагч жуулчдын сонирхлыг татахуйц худалдаа үзвэр үйлчилгээ төвлөрсөн амралт зугаалгын явган гудамжуудыг шинээр байгуулна.

## 3. ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ буюу 3.3 дахь хэсгээс:

- a) Гэр хорооллын бүсийг оршин суугчдын оролцоотой, хэсэгчилсэн инженерийн хангамж, гудамж замын сүлжээнд холбож, нийгмийн болон бусад үйлчилгээ, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар шинэчлэн зохион байгуулж сайжруулна;
- b) гэр хорооллыг хөгжүүлж, 6291.8 га талбайд сайжруулсан амины сууцны хороолол болох бөгөөд суурьшлын дундаж нягтрал 50 хүн/га болно;

- c) “Хот байгуулалтын бүсчлэлийн тогтолцоо”-г бүрэн нэвтрүүлнэ;
- d) Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлж, 14 орон нутгийн зэрэглэлтэй хот 42 хороололд хуваагдаж, “20 минутын хот” үзэл баримтлалаар хөгжүүлнэ.

Мөн төлөвлөгөөний төслийн үзэл баримтлал болон төлөвлөгөөний төсөлд тусгагдсан “Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг бүрэн хангасан, байгаль орчинд ээлтэй тэргүүний технологид суурилсан, олон улсад байр сууриа эзэлсэн эдийн засагтай, иргэн төвтэй Нийслэл хот болох” зорилго, зорилтууддаа хүрэх ач холбогдол бүхий зүйл, заалт төсөлд тусгагдсан эсэхийг шинжлэнэ.

## **2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:**

Төлөвлөгөөний төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, төлөвлөгөөний төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн зохицуулалт, үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгах зорилгоор төлөвлөгөөний төслийн дараахь зохицуулалтуудыг сонгон авлаа. Үүнд:

1. Хүн амыг шинэ ба дэд төвүүд, олон нийтийн төвүүдийг даган хотын төвөөс хотын зах руу суурьшуулах зохицуулалт:
  - a) Улаанбаатар хотын төв дэх хэт нягтралыг бууруулахын тулд дагуул хотуудыг хөгжүүлж ажлын байрыг бий болгох замаар таталцал үүсгэн 2040 онд 1 сая 649 мянган хүнээс хэтрүүлэхгүй байхаар төлөвлөж, дагуул хотуудад 440.8 мянган хүн амыг суурьшуулна;
  - b) Нийслэл Улаанбаатар хот нь дагуул хот, эдийн засгийн тусгай бүстэй байна.
2. Нийтийн зорчигч тээвэр буюу Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зохицуулалт:
  - a) багтаамж ихтэй нийтийн тээврийн сүлжээг бий болгож өдөрт 1.2 сая зорчигч тээвэрлэж нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлнэ;
  - b) 1738.8 км замыг шинээр барьж, оргил цагийн хөдөлгөөний дундаж хурдыг 9 км/цаг-аас 22.5 км/цаг болгож нэмэгдүүлнэ.
  - c) Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэр, Богдхан уулыг тойрон, Улаанбаатар-Шинэ-Зуунмод-Зуунмод-Майдар-Улаанбаатар хотуудыг холбосон цагираг нийтийн тээврийн үйлчилгээг хөнгөн галт тэрэг /хурдан трамвай/, автобусаар гүйцэтгэнэ;
  - d) 14 дагуул хот, суурингуудыг холбосон авто замын дагуу нийтийн тээврийн сүлжээгээр холбоно. Үйлчилгээг зорчигч урсгалын хэмжээнээс хамааруулан дунд болон том оврын зориулалтын нийтийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.
  - e) Багахангай, Багануур хотуудыг холбосон төлөвлөж буй авто замыг түшиглэн нийтийн тээврийг нэвтрүүлснээр дагуул хотууд өөр хоорондоо холбогдон хөгжинө.

### **2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:**

Төлөвлөгөөний төслийн зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектын хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгадаг. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөтэй тул тухайн төлөвлөгөөний төслийн үг хэллэг нь хоёрдмол утга санаагүй, монгол хэл бичгийн дүрэмд нийцсэн, утга найруулгын хувьд зөв хэрэглэсэн эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан уг төлөвлөгөөний төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийнэ.

### **2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал хүндрэл үүсгэх зохицуулалтыг шалгах хэрэгслийн хүрээнд “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ын судалгааг хийнэ гэж заасан.

Төлөвлөгөөний төслийн үйлчлэх хүрээ өргөн бөгөөд төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас гадна нийслэл хотын оршин суугч, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээх тул тэдний эрх, ашиг сонирхол хөндөгдөх, хязгаарлагдах нөхцөл байдал бий болох дараахь зохицуулалтыг сонгон авч судаллаа.

Улаанбаатар хотын төвлөрлийг задлах, сааруулах төлөвлөлттэй холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгж байгууллага үүрэг хүлээхээр байна. Тухайлбал:

- Үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлнэ;
- өндөр технологи, мэдлэгт суурилсан экспортын баримжаатай үйлдвэрийн бүсийг бий болгоно;
- зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон хэлбэрээр шилжүүлнэ;
- төр захиргааны байгууллагуудыг дагуул хотууд руу нүүлгэн шилжүүлнэ.

### **2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:**

Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр зохицуулах харилцаа нь олон талт бөгөөд өргөн хүрээг хамардагийн дээр нийслэл хоттой холбоотой асуудал олон салбарын өөр өөр хуулиар зохицуулагддаг тул уг төлөвлөгөөний төслийн зохицуулалтууд нь хоорондоо эсвэл бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэх, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэх асуудлыг үнэлэх үүднээс энэ шалгуур үзүүлэлтийг сонгон авсан бөгөөд төлөвлөгөөний төслийг бүхэлд нь судлан үзнэ. Үүнд:

- 1.Төлөвлөгөөний төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн төлөвлөгөөний төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;
- 2.Төлөвлөгөөний төслийн зохицуулалтууд тухайн төлөвлөгөөний төслийн болон бусад хууль тогтоомжийн зохицуулалттай нийцэж байгаа эсэх;
- 3.Төлөвлөгөөний төслийн зохицуулалт тухайн төлөвлөгөөний төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;
- 4.Төлөвлөгөөний төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;
- 5.Төлөвлөгөөний төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;
- 6.Төлөвлөгөөний төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;
- 7.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;
- 8.Төлөвлөгөөний төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;
- 9.Тухайн төлөвлөгөөний төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдсан эсэх;
- 10.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авлига, хүнд суртал, шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;
- 11.Төлөвлөгөөний төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан эсэх.

## ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд төлөвлөгөөний төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тус тус тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойлов.

Хүснэгт 2

Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	1. Төлөвлөгөөний төслийн 3.1 дэх хэсгээс: - Улаанбаатар хотын ойн санг 9 массив <sup>2</sup> -ын хязгаарт бүлэглэн хувааж, мод бэлтгэсэн талбай, шатсан талбай, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбайд нөхөн сэргээлт хийх болон одоо байгаа ойн сангийн хамгаалалтын бүсийг ой тэлэн ургах боломжит талбай 38,813 га буюу 33-иар нэмэгдүүлнэ; - ойн сангийн хамгаалалтын бүсийн заагийг тодорхойлж нийт 155070 га талбайд газар ашиглалтын горим дэглэмийг шинэчлэн тогтооно; - БЗД-ийн Цагаан даваа, СХД-ийн Нарангийн энгэр, Налайх, Багануур дүүрэгт аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж барьж байгуулах ба Эмээлтэд малын гаралтай өтөг бууц, хаягдал хүлээн авч бордоо бэлтгэх,	Зорилгод дүн шинжилгээ хийх

<sup>2</sup> Ойн санг бүлэглэн хуваах утгыг илэрхийлнэ.

		<p>Рашаантад ургамал, ногооны гаралтай түүхий эдийг хүлээн авч бордоо бэлтгэх, Морингийн даваа болон Налайхад барилгын хог хаягдлыг дахин боловсруулах, эрчим гаргах үйлдвэрүүдийг байгуулна.</p> <p>2. Төслийн 3.2 дахь хэсгээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Богдхан уулыг тойрон, Улаанбаатар-Шинэ-Зуунмод-Зуунмод-Майдар-Улаанбаатар хотуудыг холбосон цагираг нийтийн тээврийн үйлчилгээг хөнгөн галт тэрэг /хурдан трамвай/, автобусаар гүйцэтгэх ба чиглэлийн урт 135,2 км болно;</li> <li>- Нийслэл хотын автобусны үйлчилгээний нийтийн зорчигч тээврийн үүрэг функцийг хэвээр хадгалах бөгөөд 14 дагуул хот суурингуудыг холбосон авто замын дагуу нийтийн тээврийн сүлжээгээр холбоно. Үйлчилгээг зорчигч урсгалын хэмжээнээс хамааруулан дунд болон том оврын зориулалтын нийтийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ;</li> <li>- Багахангай, Багануур хотуудыг холбох авто замыг түшиглэн нийтийн тээврийг нэвтрүүлж, хотууд өөр хоорондоо холбогдон хөгжих нөхцөл бололцоог бүрдүүлнэ.</li> <li>- Улаанбаатар хотын баруун зүүн хэсгүүдэд зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн төв буюу авто вокзалуудыг /22-н товчоо, Амгалангийн товчоо, Яармагийн уулзвар орчим/ барьж байгуулна.</li> <li>- Туул, Сэлбэ, Улиастай голуудын дагуу амралт зугаалгын зориулалттай дугуйн зам байгуулж, хотын дугуйн замын сүлжээтэй холбоно;</li> <li>- Их-Тойруу, дэд төвүүдэд оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх, гадаад, дотоодын аялагч жуулчдын сонирхлыг татахуйц худалдаа үзвэр үйлчилгээ төвлөрсөн амралт зугаалгын явган гудамжуудыг шинээр байгуулна.</li> </ul> <p>3. Төслийн 3.3 дахь хэсгээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэр хорооллын бүсийг оршин суугчдын оролцоотой, хэсэгчилсэн инженерийн хангамж, гудамж замын сүлжээнд холбож, нийгмийн болон бусад үйлчилгээ, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар шинэчлэн зохион байгуулж сайжруулна;</li> <li>- гэр хорооллыг хөгжүүлж, 6291.8 га талбайд сайжруулсан амины сууцны хороолол болох бөгөөд суурьшлын дундаж нягтрал 50 хүн/га болно;</li> <li>- “Хот байгуулалтын бүсчлэлийн тогтолцоо”-г бүрэн нэвтрүүлнэ;</li> <li>- Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлж, 14 орон</li> </ul>	
--	--	--	--

		нутгийн зэрэглэлтэй хот 42 хороололд хуваагдаж, "20 минутын хот"-н үзэл баримтлалаар хөгжүүлнэ.	
2	Практикт хэрэгжих боломж	<p>1. Хүн амыг шинэ ба дэд төвүүд, олон нийтийн төвүүдийг даган хотын төвөөс хотын зах руу суурьшуулах зохицуулалт:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын төв дэх хэт нягтралыг бууруулахын тулд дагуул хотуудыг хөгжүүлж ажлын байрыг бий болгох замаар таталцал үүсгэн 2040 онд 1 сая 649 мянган хүнээс хэтрүүлэхгүй байхаар төлөвлөж, дагуул хотуудад 440.8 мянган хүн амыг суурьшуулна;</li> <li>- Нийслэл Улаанбаатар хот нь дагуул хот, эдийн засгийн тусгай бүстэй байна.</li> </ul> <p>2. Нийтийн зорчигч тээвэр буюу Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зохицуулалт:</p> <ul style="list-style-type: none"> <li>- багтаамж ихтэй нийтийн тээврийн сүлжээг бий болгож өдөрт 1.2 сая зорчигч тээвэрлэж нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлнэ;</li> <li>- 1738.8 км замыг шинээр барьж, оргил цагийн хөдөлгөөний дундаж хурдыг 9 км/цагаас 22.5 км/цаг болгож нэмэгдүүлнэ.</li> <li>- Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэр, Богдхан уулыг тойрон, Улаанбаатар-Шинэ-Зуунмод-Зуунмод-Майдар-Улаанбаатар хотуудыг холбосон цагираг нийтийн тээврийн үйлчилгээг хөнгөн галт тэрэг /хурдан трамвай/, автобусаар гүйцэтгэнэ;</li> <li>- 14 дагуул хот, суурингуудыг холбосон авто замын дагуу нийтийн тээврийн сүлжээгээр холбоно. Үйлчилгээг зорчигч урсгалын хэмжээнээс хамааруулан дунд болон том оврын зориулалтын нийтийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.</li> <li>- Багахангай, Багануур хотуудыг холбосон төлөвлөж буй авто замыг түшиглэн нийтийн тээврийг нэвтрүүлснээр дагуул хотууд өөр хоорондоо холбогдон хөгжинэ.</li> </ul>	Практикт тухайн төрлийн харилцаа, чиг үүргийг хэрэгжүүлж буй байдалд дүн шинжилгээ хийх, судалгаа хийх
	Ойлгомжтой байдал	Төлөвлөгөөний төслийг бүхэлд нь авч үзнэ.	Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар төлөвлөгөөний төслийн зохицуулалтуудыг шалгах замаар ойлгомжтой байдлыг шалгах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Дараахи зохицуулалтууд нь иргэн аж ахуйн нэгж байгууллагад үүрэг хүлээлгэсэн шинжийг агуулна гэж үзлээ:	Холбогдох байгууллагуудаас санал авах,

		- Үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлнэ; - өндөр технологи, мэдлэгт суурилсан экспортын баримжаатай үйлдвэрийн бүсийг бий болгоно; - зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон хэлбэрээр шилжүүлнэ; - төр захиргааны байгууллагуудыг дагуул хотууд руу нүүлгэн шилжүүлнэ.	мэргэжилтэнтэй ярилцах.
5	Харилцан уялдаа	Төлөвлөгөөний төслийг бүхэлд нь авч үзнэ.	Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтүүдэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу төлөвлөгөөний төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

### 3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн зорилгыг “Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах бүрэн эрхийг хангасан, иргэн төвтэй байгаль орчинд ээлтэй технологид суурилсан, олон улсад өрсөлдөх чадвартай хот болох” гэж ерөнхий байдлаар тодорхойлсныг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын зорилготой харьцуулвал:

Хүснэгт 1

“Улаанбаатар хотыг 2020 он хэрэт хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага	<b>Зорилго-</b> Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн зорилго нь хот төлөвлөлтийн зураг төслийн баримт бичгүүдийг иш үндэс болгон тогтвортой хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээн байгуулалтыг өргөн далайцтай өрнүүлэх замаар нийслэл хотын оршин суугчдын ажиллаж, аж төрөх таатай орчин нөхцлийг бий болгоход оршино.
Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл	<b>Зорилго-</b> Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн зорилго нь нийслэл хотын оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг бүрэн хангасан, байгаль орчинд ээлтэй тэргүүний технологид суурилсан, олон улсад байр сууриа эзэлсэн эдийн засагтай, иргэн төвтэй нийслэл хот болоход оршино.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслөөр одоогийн хүчин төгөлдөр төлөвлөгөөнөөс ялгаатай дараах шинэ зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. байгаль орчинд ээлтэй технологид суурилсан хот болох;
2. олон улсад өрсөлдөх чадвартай хот болох.

Эдгээр дэвшүүлсэн зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, нийслэлчүүдийн амьдарч, ажиллах аятай таатай зохистой орчинг бүрдүүлэхэд чиглэсэн нь бусад улсуудын хотуудын хөгжлийн хандлага, зорилготой нийцэж байх бөгөөд цаашид хотын бүтээн байгуулалт, төлөвлөлтийн бодлого нь энэхүү зорилгодоо нийцэж

байгаа эсэхэд анхаарлаа хандуулж зорилгод хүрэх зохицуулалтыг төлөвлөгөөний төсөлд тусгасан эсэхэд дүн шинжилгээг хийхийг зорилоо.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслөөс шинжлэх 1 дүгээр зорилго:  
“Байгаль орчинд ээлтэй технологид суурилсан хот болох”

Төлөвлөгөөний төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд “уг төсөлд зорилгодоо хүрэхэд чиглэсэн хэд хэдэн зохицуулалт, арга хэмжээг тусгасан бол арга хэмжээ зохицуулалт бүрийг шинжлэнэ” гэж заасны дагуу төлөвлөгөөний төслөөс тухайн зорилгод хамаарна гэж үзэж сонгон авсан зохицуулалтын үр нөлөөг хүчин төгөлдөр мөгдөгдөж байгаа бодлогын баримт бичгийн зохицуулалттай харьцуулан үнэллээ.

№	Төлөвлөгөөний төслийн үзэл баримтлал	Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл
1	Тогтвортой хөгжилтэй хот Идэвхтэй хот Дасан зохицох чадвартай хот Цогц, цомхон хот	Байгаль орчин төлөвлөлт: /Төлөвлөгөөний төслийн 3.1 дэх хэсэг/: <ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын ойн санг 9 массив<sup>3</sup>-ын хязгаарт бүлэглэн хувааж, мод бэлтгэсэн талбай, шатсан талбай, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбайд нөхөн сэргээлт хийх болон одоо байгаа ойн сангийн хамгаалалтын бүсийг ой тэлэн ургах боломжит талбай 38,813 га буюу 33-иар нэмэгдүүлнэ;</li> <li>- ойн сангийн хамгаалалтын бүсийн заагийг тодорхойлж нийт 155070 га талбайд газар ашиглалтын горим дэглэмийг шинэчлэн тогтооно;</li> <li>- БЗД-ийн Цагаан даваа, СХД-ийн Нарангийн энгэр, Налайх, Багануур дүүрэгт аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж барьж байгуулах ба Эмээлтэд малын гаралтай өтөг бууц, хаягдал хүлээн авч бордоо бэлтгэх, Рашаантад ургамал, ногооны гаралтай түүхий эдийг хүлээн авч бордоо бэлтгэх, Морингийн даваа болон Налайхад барилгын хог хаягдлыг дахин боловсруулах.</li> </ul>
2	Хүртээмжтэй хот Хэмнэлттэй хот	Зам, тээврийн сүлжээний төлөвлөлт /Төслийн 3.2 дахь хэсэг/: <ul style="list-style-type: none"> <li>- Богдхан уулыг тойрон, Улаанбаатар-Шинэ-Зуунмод-Зуунмод-Майдар-Улаанбаатар хотуудыг холбосон цагираг нийтийн тээврийн үйлчилгээг хөнгөн галт тэрэг /хурдан трамвай/, автобусаар гүйцэтгэх ба чиглэлийн урт 135,2 км болно;</li> <li>- Нийслэл хотын автобусны үйлчилгээний нийтийн зорчигч тээврийн үүрэг функцийг хэвээр хадгалах бөгөөд 14 дагуул хот суурингуудыг холбосон авто замын дагуу нийтийн тээврийн сүлжээгээр холбоно. Үйлчилгээг зорчигч урсгалын хэмжээнээс хамааруулан дунд болон том оврын зориулалтын нийтийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ;</li> <li>- Багахангай, Багануур хотуудыг холбох авто замыг түшиглэн нийтийн тээврийг нэвтрүүлж, хотууд өөр хоорондоо холбогдон хөгжих нөхцөл бололцоог бүрдүүлнэ.</li> <li>- Улаанбаатар хотын баруун зүүн хэсгүүдэд зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн төв буюу авто вокзалуудыг /22-н товчоо, Амгалангийн товчоо, Яармагийн уулзвар орчим/ барьж байгуулна.</li> <li>- Туул, Сэлбэ, Улиастай голуудын дагуу амралт зугаалгын зориулалттай дугуйн зам байгуулж, хотын дугуйн замын сүлжээтэй холбоно;</li> </ul>

<sup>3</sup> Ойн санг бүлэглэн хуваах утгыг илэрхийлнэ.

		<ul style="list-style-type: none"> <li>- Их-Тойруу, дэд төвүүдэд оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх, гадаад, дотоодын аялагч жуулчдын сонирхлыг татахуйц худалдаа үзвэр үйлчилгээ төвлөрсөн амралт зугаалгын явган гудамжуудыг шинээр байгуулна.</li> </ul>
3		<p>Орон зайн төлөвлөлт /Төслийн 3.3 дахь хэсэг/:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэр хорооллын бүсийг оршин суугчдын оролцоотой, хэсэгчилсэн инженерийн хангамж, гудамж замын сүлжээнд холбож, нийгмийн болон бусад үйлчилгээ, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар шинэчлэн зохион байгуулж сайжруулна;</li> <li>- гэр хорооллыг хөгжүүлж, 6291.8 га талбайд сайжруулсан амины сууцны хороолол болох бөгөөд суурьшлын дундаж нягтрал 50 хүн/га болно;</li> <li>- “Хот байгуулалтын бүсчлэлийн тогтолцоо”-г бүрэн нэвтрүүлнэ;</li> <li>- Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлж, 14 орон нутгийн зэрэглэлтэй хот 42 хороололд хуваагдаж, “20 минутын хот”-н үзэл баримтлалаар хөгжүүлнэ.</li> </ul>

#### Үүнд:

-”Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”<sup>4</sup>-ын 3.4.3.2-т “Нийслэлийн хүн амын төвлөрлийг тархаан байршуулах зорилгоор дагуул хотуудыг төлөвлөж, бүс нутгийг өндөр хурдны авто зам, эрчим хүч, инженерийн барилга байгууламжаар хангаж холбоно.”;

-”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн<sup>5</sup> 9.3.1-д “Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.”, 9.3.46-д “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ.”, 9.5.5-д “Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.”;

-”Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”<sup>6</sup>-ийн зорилго 9-д “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.”, 9.2.1-д “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна”, 9.3.2-т “Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ”, 9.5.3-т “Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлнэ.”;

<sup>4</sup> Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан;

<sup>5</sup> Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан.

<sup>6</sup> Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан;

-“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”<sup>7</sup>-т “20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-г боловсруулж, батлуулна.” гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар хуралдаанаар “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө” боловсруулж, батлуулахаар шийдвэрлэсэн байна.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт Улаанбаатар хот нийт 15 дагуул хот, тосгонтой байхаар төлөвлөсөн боловч тэдгээрийг хэрхэн байгуулах, бүтэц зохион байгуулалт нь ямар байх талаар зохицуулалтгүйгээс тодорхой үр дүнд хүрээгүй тул УИХ 2021 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2023 онд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, 2024 онд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга), Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг тус тус баталсан нь нийслэл хотын төвлөрлийг сааруулах, нэг төвт хотоос олон төвт хот болох төлөвлөлтийн зарчмын дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлах, түүнийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бүрдүүлжээ.

Нийслэл Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгож, 20 минутын дотор төрийн болон бусад үйлчилгээ авах боломжтой хот, тосгон байгуулах хэрэгцээ шаардлагыг үндэслэн УИХ-ын 2024 оны 72 дугаар тогтоолоор Нийслэлийн нутаг дэвсгэрт улсын зэрэглэлтэй Багануур хот, Налайх хот, орон нутгийн зэрэглэлтэй Хан-Уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-эх, Баянзүрх, Амгалан хот, нийслэлийн дагуул Багахангай хот, Агросити хот, Шарга морьт хотыг, УИХ-ын 2024 оны 76 дугаар тогтоолоор Төв аймгийн нутаг дэвсгэрт “Шинэ Зуунмод хот”-ыг, Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт Агросити, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийг тус тус байгуулсан.

Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлэх”<sup>8</sup> зорилтын хүрээнд “Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл”<sup>9</sup>-ийн нэг томоохон арга хэмжээ болох “20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичиг, түүнд суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040” болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах<sup>10</sup>, оргил ачааллын горимд ажиллах хийн дулааны станцууд болон дэд төвүүдийн дулааны станцуудыг үе шаттайгаар

<sup>7</sup> Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан;

<sup>8</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Нэг. Бүс нутгийн хөгжлийн бодлого;

<sup>9</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1;

<sup>10</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.1;

барих<sup>11</sup>, бие даасан эдийн засаг бүхий улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотуудыг хөгжүүлэх<sup>12</sup> талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгагдсан. Тухайлбал,

- Шинэ Зуунмод хотод нийслэл дэх төрийн байгууллагуудыг шилжүүлэн байршуулж, олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, аялал жуулчлалын цогцолбор, ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, их сургуулийн хотхон бүхий аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлнэ<sup>13</sup>;

- Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгах<sup>14</sup>;

- Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна<sup>15</sup> гэх мэт.

Мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгагдсан нь Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заавал тусгах шаардлагатай асуудлууд болно. Үүнд:

- Хотын төв дэх төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, "Өөдөө тэмүүлэх Монгол" буюу "Go Mongolia" ган татлагат гүүрийн төсөл, Хөшигийн хөндийн туннелийн төслийг хэрэгжүүлэх, олон улсын чанартай Шинэ тойрог зам, Туулын хурдны авто зам, "Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1", "Дүүжин тээвэр шугам-1" зэрэг олон төрөлт нийтийн тээврийн сүлжээ байгуулах, явган болон дугуйтай зорчигчдод ээлтэй дэд бүтцийг бий болгож автомашины хэрэглээг болон бохирдлын хэмжээг 2 дахин бууруулах;

- "Туул усан цогцолбор төсөл"-ийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, ундны ус, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх, Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн голын эргийн хамгаалалтын далан болон ус зайлуулах сувгийг шинээр барьж, усан сан, хөв, цөөрөм байгуулах, инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

- нийтийн эзэмшлийн газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барьж, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах нөхцөлийг бүрдүүлэх гэх мэт.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Хүн амын

<sup>11</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.1;

<sup>12</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2;

<sup>13</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.1;

<sup>14</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.3;

<sup>15</sup> Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.3.1;

нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” зэрэг урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн зохицуулалт, хэрэгжилттэй уялуулах нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний нэг онцлох чиг үүрэг, хэрэгцээ шаардлага болж байна.

Төлөвлөгөөний төслийн дээр дурдсан зохицуулалтууд нь бүхэлдээ Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, өнөөдөр тулгамдаж буй авто замын түгжрэл, агаар, орчны бохирдлыг бууруулах, иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээтэй нийцэж байх бөгөөд нийгэм, эдийн засгийн хөгжил цаашлаад хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх суурь болохоор байна.

### **3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:**

Төлөвлөгөөний төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөгөөний төслийн дараах зохицуулалтыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Хүн амыг шинэ ба дэд төвүүд, олон нийтийн төвүүдийг даган хотын төвөөс хотын зах руу суурьшуулах зохицуулалт:

- Улаанбаатар хотын төв дэх хэт нягтралыг бууруулахын тулд дагуул хотуудыг хөгжүүлж ажлын байрыг бий болгох замаар таталцал үүсгэн 2040 онд 1 сая 649 мянган хүнээс хэтрүүлэхгүй байхаар төлөвлөж, дагуул хотуудад 440.8 мянган хүн амыг суурьшуулна;
- Нийслэл Улаанбаатар хот нь дагуул хот, эдийн засгийн тусгай бүстэй байна.

2. Нийтийн зорчигч тээвэр буюу Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зохицуулалт:

- f) багтаамж ихтэй нийтийн тээврийн сүлжээг бий болгож өдөрт 1.2 сая зорчигч тээвэрлэж нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлнэ;
- g) 1738.8 км замыг шинээр барьж, оргил цагийн хөдөлгөөний дундаж хурдыг 9 км/цаг-аас 22.5 км/цаг болгож нэмэгдүүлнэ.
- h) Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэр, Богдхан уулыг тойрон, Улаанбаатар-Шинэ-Зуунмод-Зуунмод-Майдар-Улаанбаатар хотуудыг холбосон цагираг нийтийн тээврийн үйлчилгээг хөнгөн галт тэрэг /хурдан трамвай/, автобусаар гүйцэтгэнэ;
- i) 14 дагуул хот, суурингуудыг холбосон авто замын дагуу нийтийн тээврийн сүлжээгээр холбоно. Үйлчилгээг зорчигч урсгалын хэмжээнээс хамааруулан дунд болон том оврын зориулалтын нийтийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.
- j) Багахангай, Багануур хотуудыг холбосон төлөвлөж буй авто замыг түшиглэн нийтийн тээврийг нэвтрүүлснээр дагуул хотууд өөр хоорондоо холбогдон хөгжинө.

Эдгээр арга хэмжээнүүд нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн зорилгод нийцэж байх боловч хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардагдах томоохон бүтээн

байгуулалтын ажил байх бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нарийн тооцоолж, зөвхөн улс, нийслэлийн төсөв харах биш өөр олон төрлийн санхүүгийн эх үүсвэр ашигласнаар эдгээр арга хэмжээг практикт хэрэгжүүлэх боломжтой байна.

Мөн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг урьдчилан тогтоож, сонгон шалгаруулалт хийх хугацааг төлөвлөх, олон нийтэд мэдээлэх замаар хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах нь эдгээр зохицуулалт практикт хэрэгжих боломж, нөхцлийг бүрдүүлэх нэг нөхцөл болохоор байна.

### 3.3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийлээ.

#### А.Төлөвлөгөөний төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх талаар:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу төлөвлөгөөний төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хүснэгт 4

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан байна.
29.1.2.ХЕТ-өөр зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.ХЕТ-өөр зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.ХЕТ-өөр зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.ХЕТ-ний зохицуулалт хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.ХЕТ-өөр зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.

29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Энэ асуудлыг холбогдох хуулиар зохицуулах тул шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Энэ асуудлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Засгийн газарт чиглэл болгосон тул шаардлага хангасан.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

Төлөвлөгөөний төслийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага, эрх зүйн болон бусад ажилтнууд, БХБЯ, МАЭ болон хот байгуулалт, төлөвлөлт, барилгын зураг төсөл, архитекторын мэргэжлийн хүмүүст танилцуулж, санал авахад төлөвлөгөөний төсөл ойлгомжгүй байна гэсэн санал гараагүй байна.

Иймд төлөвлөгөөний төслийн зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцэж байна гэж дүгнэлээ.

Б.Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх:

Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг бүхэлд нь авч үзэхэд Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал хүндрэл үүсгэх зохицуулалтыг шалгах хэрэгслийн хүрээнд “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ын судалгааг хийнэ гэж заасны дагуу ХЕТ-ний төслийн дараахи зохицуулалтууд нь иргэн аж ахуйн нэгж байгууллагад үүрэг хүлээлгэсэн шинжийг агуулна гэж үзэж сонгон авч үзлээ:

- Үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлнэ;
- өндөр технологи, мэдлэгт суурилсан экспортын баримжаатай үйлдвэрийн бүсийг бий болгоно;
- зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон хэлбэрээр шилжүүлнэ;
- төр захиргааны байгууллагуудыг дагуул хотууд руу нүүлгэн шилжүүлнэ.

Эдгээр зохицуулалтууд нь иргэн, хуулийн этгээдэд шууд үүрэг хүлээлгээгүй байх боловч Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 31.3-т нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд нь өмчийн хэлбэрээс үл хамааран хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын стандартыг мөрдөх, нийслэл хотын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй, 32.2-т нийслэл хотын оршин суугч нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлын бүсэд оршин суух, нийслэл хотын дүрэм, стандартыг дагаж мөрдөх, хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэлийн дүрмийн дагуу орон байр, орчноо тохижуулах үүрэгтэй байхаар хуульчилсан байна.

Иймд дээр дурдсан төлөвлөгөөний төсөлд тусгагдсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөх үүрэгтэй байна.

Энэ нь хэдийгээр иргэн, хуулийн этгээдэд тодорхойл үр дагавар үүсгэж, эрх, үүрэг хүлээлгэж байх боловч гол зорилго нь нийслэлийн төвлөрлийг задлах, төлөвлөлттэй хөгжүүлэх улмаар өнөөдөр тулгамдаж байгаа олон асуудлыг шийдвэрлэж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилготой байгаа нь хүчин төгөлдөр хууль тогтоомж болон бусад улсуудын жишгээр авч хэрэгжүүлж байгаа хотжилтын үйл ажиллагаанд нийцэж байгаа нь хүлээн зөвшөөрөгдөх нэг хүчин зүйл болж байна. Мөн эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь төрийн байгууллагын оролцоо, ачааллыг багасгаж байгаа зохицуулалт байх тул олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөн хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

### **3.5. "Төлөвлөгөөний төслийн харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар төлөвлөгөөний төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Хүснэгт 5

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Төлөвлөгөөний төслийн зохицуулалт тухайн төлөвлөгөөний зорилготой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байна.
2	Төлөвлөгөөний төсөлд тусгагдсан нэр томьёо тухайн төлөвлөгөөний төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Төлөвлөгөөний төсөлд нэр томьёо тухайлан тайлбарласан зохицуулалт байхгүй бөгөөд хэрэглэгдэж байгаа нэр томьёо нь ойлгомжтой бөгөөд бусад хууль тогтоомжийн нэр томьёотой нийцэж байх тул энэхүү шаардлагыг хангаж байна.

3	Төлөвлөгөөний төслийн зохицуулалт бусад хууль тогтоомжийн зохицуулалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байна.
4	Төлөвлөгөөний төслийн зохицуулалт бусад хууль тогтоомжийн зохицуулалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
5	Төлөвлөгөөний төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
6	Төлөвлөгөөний төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
7	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Томоохон хэмжээний бүтээн байгуулалтын ажлууд хийгдэх бөгөөд холбогдох хуульд тогтоомжид заасны дагуу төрийн байгууллагын чиг үүргийг ТББ, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой.
8	албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
9	Төлөвлөгөөний төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг тусгасан эсэх;	Төлөвлөгөөний төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
10	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
11	Төлөвлөгөөний төслийн зохицуулалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
12	Төлөвлөгөөний төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
13	Төлөвлөгөөний төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	Төлөвлөгөөний төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	- Үгүй

Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн зохицуулалт хоорондоо болон бусад хуулийн зүйл, заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

## **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

### **4.1.Баримтжуулалт**

Төлөвлөгөөний төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

- хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;
- УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлал;
- УИХ-ын тогтоолын төслийн танилцуулга;
- ХЕТ боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан;
- Төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, санал авсан баримтууд.

### **4.2.Үнэлэлт, дүгнэлт**

Төлөвлөгөөний төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

#### **4.2.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:**

Төлөвлөгөөний төслийн зохицуулалт нь ХЕТ-г боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн ХЕТ-ний төслийн зорилгыг бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн.

Төлөвлөгөөний төслийн зохицуулалтуудын хувьд уг төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж зорилгод хүрэх байдлаар томъёологдсон байна.

**Дүгнэлт:** Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр үнэлж ХЕТ-ний төслийн зорилго нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн зорилго, зорилгод бүрэн нийцэж байна гэж үзлээ. Харин ХЕТ-ний төслийн зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгаж, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар анхаарах шаардлагатай гэж дүгнэлээ.

#### **4.2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийж дараах байдлаар дүгнэлээ:

- ХЕТ-ний төслийн зохицуулалт-арга хэмжээнүүд нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн зорилгод нийцэж байх боловч хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардагдах томоохон бүтээн байгуулалтын ажил байх бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нарийн тооцоолж, зөвхөн улс, нийслэлийн төсөв харах биш өөр олон төрлийн санхүүгийн эх үүсвэр ашигласнаар эдгээр арга хэмжээг практикт хэрэгжүүлэх боломжтой байна.

- ХЕТ-ний дагуу хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг урьдчилан тогтоож, сонгон шалгаруулалт хийх хугацааг төлөвлөх, олон

нийтэд мэдээлэх замаар хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах нь эдгээр зохицуулалт практикт хэрэгжих боломж, нөхцлийг бүрдүүлэх нэг нөхцөл болохоор байна.

**Дүгнэлт:** Төлөвлөгөөний төслийн зохицуулалтуудыг практикт дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой байна гэж дүгнэлээ.

#### **4.2.3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтээр:**

ХЕТ-ний төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.

#### **4.2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр:**

Төлөвлөгөөний төсөлд төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх, тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэх, хуулийн этгээдэд ачаалал хүндрэл үүсгэх зохицуулалтыг судалж дүн шинжилгээ хийсэн ба дараах байдлаар үнэлгээ хийж дүгнэв:

- ХЕТ-ний төлөвлөгөөний зохицуулалтууд нь иргэн, хуулийн этгээдэд шууд үүрэг хүлээлгээгүй байх боловч Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 31.3-т нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд нь өмчийн хэлбэрээс үл хамааран хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын стандартыг мөрдөх, нийслэл хотын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй, 32.2-т нийслэл хотын оршин суугч нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлын бүсэд оршин суух, нийслэл хотын дүрэм, стандартыг дагаж мөрдөх, хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэлийн дүрмийн дагуу орон байр, орчноо тохижуулах үүрэгтэй байхаар хуульчилсан байна. Иймд төлөвлөгөөний төсөлд тусгагдсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөх үүрэгтэй байна.
- Төлөвлөгөөний төслийн зарим зохицуулалтууд нь хэдийгээр иргэн, хуулийн этгээдэд тодорхойл үр дагавар үүсгэж, эрх, үүрэг хүлээлгэж байх боловч нийслэлийн төвлөрлийг задлах, төлөвлөлттэй хөгжүүлэх улмаар өнөөдөр тулгамдаж байгаа олон асуудлыг шийдвэрлэж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилготой байгаа нь хүчин төгөлдөр хууль тогтоомж болон бусад улсуудын жишгээр авч хэрэгжүүлж байгаа хотжилтын үйл ажиллагаанд нийцэж байгаа нь хүлээн зөвшөөрөгдөх нэг хүчин зүйл болж байна. Мөн эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь төрийн байгууллагын оролцоо, ачааллыг багасгаж байгаа зохицуулалт байх тул олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөн хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

#### **4.2.5."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтээр:**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд ХЕТ-ний төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгаж, харилцан уялдаатай байдлыг хангасан байна гэж дүгнэлээ.

#### **4.3.Зөвлөмж**

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл, түүнийг батлах Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал"-ын дагуу 5 шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1.Улаанбаатар хотын 2020 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулан өмнөх алдаагаа даватахгүй байх;

2.ХЕТ-ний төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэхүү ХЕТ-г батлагдсанаас хойш 6 сарын дотор боловсруулж батлуулах;

3.ХЕТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг урьдчилан тогтоож, сонгон шалгаруулалт хийх хугацааг төлөвлөх, олон нийтэд мэдээлэх замаар хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах;

4.ХЕТ-ний зорилгыг бүрэн хангахын тулд төлөвлөгөөний төсөлд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн асуудлыг тооцоо, судалгаатайгаар улс, нийслэлийн төсөвт жил бүр тусгаж, батлах, бусад санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах боломжийг бүрдүүлэх;

5.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 17.1, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 41.1-д заасан дэд бүтцийн санг байгуулах гэх мэт.

#### ***Үр нөлөөг үнэлэх судалгааг дүгнэхэд:***

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл, түүнийг батлах Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан гэж дүгнэлээ.

## ТАВ.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. Нийслэлийн цахим мэдээллийн систем [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn)
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn)
4. Нэгдсэн үндэсний хөгжлийн хөтөлбөр [www.undp.org](http://www.undp.org)
5. Монгол хэлний их тайлбар толь, цахим систем <https://mongoltoli.mn>
6. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим систем <http://www.citycouncil.mn/>
7. Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгааны тайлан., УБ, 2024 он;
8. Улаанбаатар хотын 2020 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;
9. Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70 дугаар чуулганаар баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”;
10. Нэгдсэн үндэсний байгууллагын “Хабитат-III” байгууллагаас 2016 онд батлагдсан “Хотжилтын шинэ хөтөлбөр”;
11. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”;
12. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
13. Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хот байгуулах тухай” 72, 76 дугаар тогтоол;
14. Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоол;
15. Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Үндэсний бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоол;
16. Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоол;
17. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үзэл баримтлал /концепци/-н дагуу боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар 12-ны өдрийн 35 дугаар хурлын тэмдэглэл;
18. Засгийн газрын 2020-2024, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
19. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
20. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/-г дэмжих тухай НИТХ-ын 2019 оны 28/26 дугаар тогтоол;
21. НИТХ-ын 2020 оны 32/04 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэл хотыг хөгжүүлэх хэтийн төлөв”;
22. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичиг” 2022 он, Т-4;
23. <https://ulaanbaatar.mn/home>, Үндэсний статистикийн хорооны мэдээлэл.

**“НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН  
2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ  
ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2024 он

## АГУУЛГА

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДАЛ
2. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДАЛ
3. ИРГЭНИЙ ХУВЬД ҮҮСЭХ ЗАРДАЛ
4. ЗУРАГ ТӨСЛИЙН ЗАРДАЛ
5. ДҮГНЭЛТ

## **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл” батлагдсанаар уг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тооцсон болно.

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл батлагдсанаар уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах болон бууруулах талаар санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү тайлангийн зорилго чиглэгдэнэ.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан болно.

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
  - үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
  - бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
  - аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.
- Аргачлалын 1.5-д заасны дагуу тогтоолын төсөл батлагдсан тохиолдолд
1. Төрийн байгууллагын зардал,
  2. Хуулийн этгээдийн зардал,
  3. Иргэний үүсэх зардлыг тус бүрээр тооцов.

### **1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДАЛ БУЮУ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДАЛ**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, хөгжлийн газар нь “Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний захиалагч, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол байгууллагууд бөгөөд цаашид батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын үйл ажиллагааг нийслэлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллана.

Эдгээр төрийн захиргааны байгууллагууд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл батлагдсанаар түүнийг хэрэгжүүлэх дараах үйл ажиллагаатай холбоотой нэмэлт зардал гарахаар байна. Үүнд:

#### **1.1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлээ хийх үйл ажиллагаа**

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад 5 жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж танилцуулах чиг үүргийг тусгайлан заасан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан төсөв, Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ нь Ерөнхий төлөвлөгөөний хяналт мониторингийн үүргийг гүйцэтгэх нэгжтэй бөгөөд 6 хүний орон тоотойгоор ажиллаж байна. Цаашид хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа хяналт, шинжилгээ, мониторинг хийх нэгжийн хүний нөөцийг 10 орон тоотой болгон өргөжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, түүний дагуу хэрэгжих зураг төслийг баримт бичгийг тухай бүр газрын мэдээллийг санд оруулах
- Барилгажилт, газар ашиглалтын мэдээллийг тухай бүр шинэлчэх
- Төлөвлөлт болон хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх,

- 1 жил дутам Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд Хөгжлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн мониторингийн тайланг бэлтгэн хүргүүлэх
- 5 жил дутам, УИХ-д хэрэгжилтийн тайланг нэгтгэн танилцуулах

**Хүснэгт 1. Нэмэгдэх хүний нөөц, цалингийн сангийн төсөөлөл**

№	Албан тушаал	Орон тоо	Сарын цалин /сая.төг/	Жилийн цалингийн сан /төгрөг/
1	Мэргэжилтэн	4	3,060,000	146.88
2	НД, ЭМД-ийн зардал	13%	-	20.27
	Нийт дүн	-	-	167.15

*Тайлбар. \*Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын батлагдсан цалингийн хэмжээг, нэмэгдэл цалин хөлсийг үндэслэв.*

Өөрөөр хэлбэл, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ нь Ерөнхий төлөвлөгөөний хяналт мониторингийн үүргийг гүйцэтгэж байгаа нэгжийн бүрэлдэхүүний тоо 4-аар нэмэгдэж нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй болж өөрчлөгдөх бөгөөд энэхүү өөрчлөлттэй холбоотойгоор тухайн нэгжийн жилийн цалингийн сан 167.15 сая төгрөгөөр цалингийн сан нэмэгдэнэ.

**1.2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчныг сайжруулах үйл ажиллагаа:**

Батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд хууль эрх зүйн орчныг сайжруулах шинээр боловсруулах болон нэмэлт өөрчлөлт оруулах хуулиудын жагсаалт, мөн шинээр боловсруулж хотод хэрэгжүүлэх шаардлагатай стандартуудын жагсаалтыг тус тус гаргаж түүнд шаардагдах зардлыг тооцоолж гаргалаа.

**Хүснэгт 4. Шинээр боловсруулах хууль, тогтоомжийн төсөл, шаардагдах зардал**

№	Хууль, тогтоомжийн төслийн нэр	Хуулийн төслөөр зохицуулах харилцаа	Зардал /сая.төг/
1	Архитектур төлөвлөлтийн тухай хуулийн төсөл	Хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж зам, барилгажилтын улаан шугамыг мөрдүүлэх, барилгын давхаржилт, гадна өнгө дизайнд тавигдах шаардлагыг хангуулах, газар олголт ерөнхий төлөвлөгөөний уялдааг хангах, хотын гудамж, зам сүлжээ, замын байгууламж, хотын ногоон байгууламж, тохижилт, инженерийн шугам, сүлжээний бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах гэх зэрэг хот байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж зөрчлийг арилгах хариуцлагын тогтолцоог бий болгох	20.0
2	Авто зогсоолын тухай хуулийн төсөл	Авто зогсоолгүй барилга байгууламжууд замын сүлжээг хязгаарлаж, уулзвар гарцын нэвтрэх чадварыг бууруулж, авто замын уулзвар, гарц, гол зам дагуух худалдаа, үйлчилгээний цэг, замын хажуугийн ташуу хэлбэрийн зогсоол, нэгдүгээр эгнээнд тээврийн хэрэгсэл байрлуулах нь замын хөдөлгөөний эрчмийг сааруулж зохиомол түгжрэл үүсгэж буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх	20.0
3	Ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Ногоон байгууламж, авто зогсоолын төлөвлөлтийг хэрхэн тогтоохыг тусгасан нь зөвхөн барилгажилтын төсөлд хамаарч байх тул ногоон байгууламжийн талаар бие даасан хуулиар зохицуулах	20.0

4	Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн төсөл	Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу дагуул хот, тосгон, тусгай бүсийг байгуулах асуудлыг нарийвчлан зохицуулах.	20.0
5	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дүрмийн төсөл	Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн иргэдийн амьдрах орчин, суурьшил, ногоон байгууламж, агаарын бохирдол, барилга, байгууламжийн нягтаршил, авто замын түгжрэл, нийтийн тээвэр зэрэг тулгамдсан асуудлыг дэд төвүүд, төрөлжсөн төвүүдийг дэмжих албан татварын төрөл, хувь хэмжээ, татварын бус дэмжлэгийг оновчтой тодорхойлох, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах татварын болон бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх Улаанбаатар хотын доторх төлбөрийн бүсчлэл тогтоох талаар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх зүйлд хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг нийслэл хотын дүрмээр зохицуулж болно, 9.2 дахь зүйлд "Нийслэл хотын дүрмийг НИТХ батална" гэсний дагуу Улаанбаатар хотын доторх төлбөрийн бүсчлэл тогтоох	20.0
	Нийт	-	100.0

Хөгжлийн ерөнхий ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үүднээс дээрх нэр бүхий 5 хууль, тогтоомжийн төслийг боловсруулах үйл ажиллагаанд нийт 100.0 сая төгрөг шаардлагатай гэж үзлээ.

**Хүснэгт 5. Нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, тогтоомжууд (давхардсан тоогоор)**

№	Хууль, тогтоомжийн нэр	Зохицуулах харилцаа, хэрэгцээ шаардлага
1	Газрын багц хууль	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдаагүй газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар олголтоос ерөнхий төлөвлөгөө хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсч байна. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дагуу бүсчлэл, газар зохион байгуулалтын төлөвлөлт хийх дараалал, үе шатуудыг зөв тодорхойлж, уялдаа холбоог хангасан эрх зүйн орчинг бүрдүүлэх. Ерөнхий төлөвлөгөөний эрх зүйн орчинг сайжруулах ажлын хүрээнд өөр нэршилтэй ижил агуулгатай хөгжлийн төлөвлөгөөг нэг нэршилтэй болгох, бусад хуулийн нэр томъёог нэгтгэх замаар шийдвэрлэх. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>▪ хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө</li> <li>▪ хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө,</li> <li>▪ хот, тосгон, бусад суурин газрын байршил, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө</li> <li>▪ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө</li> <li>▪ хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө</li> </ul>
2	Хот байгуулалтын тухай хууль	
3	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль	
4	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль	
5	Агаарын тухай хууль	
6	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль	
7	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	Хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн төрөлд 20 жилийн төлөвлөлтийг орхигдуулсныг тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар нэмж тусган залруулах 20 жилийн төлөвлөгөөг зөрчсөн, биелүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлагын тогтолцоог нэмж тусгах
8	Монгол Улсын Нийслэл хотын албан татварын тухай хууль	Хуулийн 7 дугаар зүйлд Нийслэлийн хотын албан татвар ногдох бараа үйлчилгээнд бүх төрлийн согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, зочид буудлын үйлчилгээ, амралтын газрын үйлчилгээ, рестораны үйлчилгээ,

		баарны үйлчилгээ, автомашины угаалгын газрын үйлчилгээ, авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйлчилгээ хамаарч байна. Хот өөрийн хууль, дүрмээр зохицуулсан татварын төрөл, хэмжээ бүхий татварын бүсчлэлийг тогтоох.
9	Эрчим хүчний тухай хууль	Агаарын бохирдлыг бууруулах, түүхий нүүрсний хэрэглээг багасгах, цаашид өсөн нэмэгдэх дулаан хангамжийг хийн түлшний хэрэглээг дэмжих замаар экологийн тэнцвэрт байдлыг хангах, инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх
10	Зөрчлийн тухай хууль	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, түүнд заасан урт хугацааны төлөвлөлтийг зөрчсөн тохиолдолд зөрчилд тооцох, хүлээлгэх хариуцлагыг тусгах
11	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хууль	Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахын тулд барилгажилтыг хориглох (нягтаршил ихтэй) бүс, ногоон бүсэд барилга, байгууламж барьсан тохиолдолд Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг нэмэгдүүлэх заалт тусгах, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдэх.
12	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль	Дагуул хотын тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлттэй зээлийг тэргүүн ээлжид олгох нэмэлт, өөрчлөлт тусгах.
13	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль	Дагуул хотын тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах дэмжлэг үзүүлэх нэмэлт, өөрчлөлт тусгах.
14	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам	Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд Ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт гаргах зохицуулалт нэмж тусгах
15	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам (Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан)	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах уг журамд 20 жилийн хугацаатай ерөнхий төлөвлөгөөг нэмж тусгах

Хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Нийслэлийн Засаг даргын тамгын газраас холбогдох яамдуудад санал хүргүүлэн уламжилж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах боломжтой.

Хүснэгт 6. Шинээр боловсруулах стандартууд

№	Стандартын дугаар	Стандартын нэр	Хуудасны тоо	Зардал /сая.төг/
1	ISO 37100:2016	Sustainable cities and communities - Vocabulary <i>Тайлбар толь</i>	10	17.2
2	ISO 37101:2016	Sustainable development in communities - Management system for sustainable development - Requirements with guidance for use <i>-Тогтвортой хөгжлийн менежментийн систем -Ашиглах зааварчилгаа болон шалгуур үзүүлэлтүүд</i>	32	55.0
3	ISO 37104:2019	Sustainable cities and communities - Transforming our cities - Guidance for practical local implementation of ISO 37101 <i>ISO 37101 стандартыг орон нутгийн практикт хэрэгжүүлэх заавар</i>	61	104.8
4	ISO 37105:2019	Sustainable cities and communities - Descriptive framework for cities and communities <i>Хот болон олон нийтийн хамрах хүрээ</i>	54	92.8
5	ISO 37106:2018	Sustainable cities and communities - Guidance on establishing smart city operating models for sustainable communities <i>Тогтвортой олон нийтэд зориулсан ухаалаг хотын үйл ажиллагааны загварыг бий болгох удирдамж</i>	46	79.1
6	ISO/TS 37107:2019	Sustainable cities and communities - Maturity model for smart sustainable communities <i>Ухаалаг тогтвортой олон нийтийн боловсорсон загвар</i>	40	68.8
7	ISO 37120:2018	Sustainable cities and communities - Indicators for city services and quality of life <i>Хотын үйлчилгээ, амьдралын чанарын үзүүлэлтүүд</i>	121	208.0
8	ISO/TR 37121:2017	Sustainable development in communities - Inventory of existing guidelines and approaches on sustainable development and resilience in cities	96	165.0
9	ISO 37122:2019	Sustainable cities and communities - Indicators for smart cities <i>Ухаалаг хотын үзүүлэлтүүд</i>	95	163.3
10	ISO 37123:2019	Sustainable cities and communities - Indicators for resilient cities <i>Уян хатан хотуудын үзүүлэлтүүд</i>	83	142.7
11	ISO/TR 37150:2014	Smart community infrastructures - Review of existing activities relevant to metrics <i>Одоо байгаа үйл ажиллагааны хэмжигдэхүүнтэй холбоотой тойм</i>	110	189.1
12	ISO/TS 37151:2015	Smart community infrastructures - Principles and requirements for performance metrics <i>Хэмжигдэхүүний үр дүнгийн зарчим ба шаардлагууд</i>	57	98.0
13	ISO/TR 37152:2016	Smart community infrastructures - Common framework for development and operation <i>Хөгжил ба үйл ажиллагааны нийтлэг хамрах хүрээ</i>	21	36.1

14	<b>ISO 37153:2017</b>	Smart community infrastructures - Maturity model for assessment and improvement	26	44.7
15	<b>ISO 37154:2017</b>	Smart community infrastructures - Best practice guidelines for transportation <i>Тээврийн хамгийн шилдэг туршлага бүхий удирдамжийн баримт бичиг</i>	24	41.3
16	<b>ISO 37155-1:2020</b>	Framework for integration and operation of smart community infrastructures - Part 1: Recommendations for considering opportunities and challenges from interactions in smart community infrastructures from relevant aspects through the life cycle <i>Хэсэг1 Ухаалаг олон нийтийн дэд бүтцийн харилцан үйлчлэл ба тэдгээрийн боломж бэрхшээлийг урт хугацааны туршид авч үзэх аргазүйн зөвлөмж</i>	23	39.5
17	<b>ISO 37155-2:2021</b>	Framework for integration and operation of smart community infrastructures - Part 2: Holistic approach and the strategy for development, operation and maintenance of smart community infrastructures <i>Хэсэг 2. Хот нийтийн ухаалаг дэд бүтцийн хөгжил, ашиглалт, засвар үйлчилгээний стратегийн цогц арга.</i>	22	37.8
18	<b>ISO 37156:2020</b>	Smart community infrastructures - Guidelines on data exchange and sharing for smart community infrastructures <i>Хот нийтийн ухаалаг дэд бүтцийн мэдээлэл солилцох хуваалцах зорилготой удирдамжийн баримт бичиг</i>	30	51.6
19	<b>ISO 37157:2018</b>	Smart community infrastructures - Smart transportation for compact cities <i>Компакт хотуудад зориулсан ухаалаг тээвэр</i>	7	12.0
20	<b>ISO 37158:2019</b>	Smart community infrastructures - Smart transportation using battery-powered buses for passenger services <i>Ухаалаг тээвэрлэлт нь батерейгаар ажилладаг нийтийн тээврийн автобус ашиглаж байна.</i>	8	13.8
21	<b>ISO 37159:2019</b>	Smart community infrastructures - Smart transportation for rapid transit in and between large city zones and their surrounding areas	9	15.5
22	<b>ISO 37160:2020</b>	Smart community infrastructures - Electric power infrastructure - Measurement methods for the quality of thermal power infrastructure and requirements for plant operations and management <i>- Цахилгаан эрчим хүчний дэд бүтэц - Дулааны эрчим хүчний дэд бүтцийн чанарыг хэмжих арга, станцын үйл ажиллагаа, менежментэд тааигдах шаардлага</i>	29	49.8
23	<b>ISO 37161:2020</b>	Smart community infrastructures - Guidance on smart transportation for energy saving in transportation services	15	25.8

		-Тээврийн үйлчилгээнд эрчим хүч хэмнэх ухаалаг тээврийн удирдамж		
24	ISO 37162:2020	Smart community infrastructures - Smart transportation for newly developing areas - Шинээр хөгжиж буй бүс нутгуудад зориулсан ухаалаг тээвэр	10	17.2
25	ISO 37163:2020	Smart community infrastructures - Smart transportation for parking lot allocation in cities Ухаалаг тээврийн зогсоол, зогсоолын хуваарилалт	11	18.9
26	ISO 37164:2021	Smart community infrastructures - Smart transportation using fuel cell light rail transit (FC-LRT) FC-LRT ухаалаг тээвэр ашиглалт	5	8.6
27	ISO 37165:2020	Smart community infrastructures - Guidance on smart transportation with the use of digitally processed payment (d-payment)	8	13.8
28	ISO 37167:2021	Smart community infrastructures - Smart transportation for energy saving operation by intentionally driving slowly -Удаан жолоодлого хийн эрчим хүч хэмнэх ухаалаг тээвэр	10	17.2
29	ISO 37169:2021	Smart community infrastructures - Smart transportation by run-through train/bus operation in/between cities - хот хооронд/галт тэрэг/автобусны үйлчилгээ	13	22.3
30	ISO/TR 37171:2020	Report of pilot testing on the application of ISO smart community infrastructures standards ISO ухаалаг нийгмийн дэд бүтцийн стандартыг ашиглах туршилтын тайлан	18	30.9
31	ISO 37180:2021	Smart community infrastructures - Guidance on smart transportation with QR code identification and authentication in transportation and its related or additional services - Тээвэрлэлт, түүнтэй холбоотой болон нэмэлт үйлчилгээнд QR код таних, баталгаажуулах ухаалаг тээврийн талаарх заавар	10	17.2
	-	<b>Нийт дүн</b>	-	1,897.5

Эх үүсвэр: Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар

Барилгын хөгжлийн төвөөс 2021 оны 07 дугаар сарын 06-нд зарласан “Тогтвортой хот ба олон нийтийн хамтын үйл ажиллагаа. Удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага” ISO37101 зөвлөх үйлчилгээний тендерийн төсөвт өртийг жишиг болгон тооцов.

Шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хуулиуд мөн шинээр стандартууд боловсруулан батлуулж, Нийслэл Улаанбаатар хотын хууль эрх орчныг сайжруулахад нийт 1 тэрбум 997.5 сая төгрөгийн зардлын тооцоо гарч байна.

### 1.3. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын зардал /томсгосон тооцоо/

Боловсруулсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийгмийн дэд бүтэц, орон сууц, үйлдвэр аж ахуй, нийтийн тээвэр, төмөр зам, инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээ, ногоон байгууламжийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай томсгосон хөрөнгө оруулалтын тооцоог 2040 он хүртэлх хугацаанд тооцоолоход нийт 236

их наяд 219 тэрбум төгрөг гарч байна. Үүний 40% буюу 94 их наяд 802 тэрбум төгрөгийг улс, нийслэлийн төсөв, концесс, жижиг дунд үйлдвэрлэлийн сан, орон сууцны санхүүжилт зэрэг эх үүсвэрүүдээр хөрөнгө оруулах шаардлагатай тооцоолол гарсан.

**Хүснэгт 7. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний шаардагдах хөрөнгө оруулалтын томсгосон тооцоо**

Тэрбум төгрөг, өссөн дүнгээр	2023-2030 он хүртэл	2031-2040 он хүртэл	Нийт-2040	Нийт санхүүжилт бүтэц	
				Төсвийн эх үүсвэр	Хувийн эх үүсвэр
НДБ	4,298	3,922	8,220	8,220	-
Орон сууц	17,378	48,294	65,671	4,758	60,913
Үйлдвэр аж ахуй	26,748	54,994	81,742	1,396	80,347
Авто зам, зогсоол	5,015	12,518	17,532	17,532	-
Уулзвар, гүүр, нүхэн гарц	1,105	2,149	3,254	3,254	-
Явган зам	58	127	184	184	-
Дугуйн зам	114	145	259	259	-
Төмөр зам	-	539	539	539	-
Метро	10,404	-	10,404	10,404	-
LRT	343	-	343	343	-
Богд уулын туннел		3,500	3,500	3,500	-
BRT	2,272	-	2,272	2,272	-
Дүүжин тээвэр	200	-	200	200	-
ДУЛААН	1,933	1,503	3,436	3,436	-
ЦАХИЛГААН	10,225	7,078	17,303	17,303	-
ИБАХ	4,849	6,610	11,459	11,459	-
УХАТ	584	3,743	4,327	4,327	-
Мэдээлэл холбоо	112	45	157		157
Ногоон байгууламж	655	666	1,321	1,321	-
газар чөлөөлөлт	1,182	2,912	4,094	4,094	-
<b>Нийт</b>	<b>87,475</b>	<b>148,745</b>	<b>236,219</b>	<b>94,802</b>	<b>141,417</b>
<b>Эзлэх хувь</b>	<b>37%</b>	<b>63%</b>	<b>100%</b>	<b>40%</b>	<b>60%</b>

*Тайлбар: Барилга, Хот байгуулалтын сайдын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 203 дугаар тушаалаар баталсан "Барилгын байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм" /БД 81-106-16/-ийг үндэслэн боловсруулав.*

Төлөвлөлтийн нийт хугацаа буюу 2040 он хүртэлх хугацаанд 2 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд эхний үе шат болох 2030 он хүртэлх хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтаар 57 их наяд 001 тэрбум төгрөг шаардлагатай томсгосон тооцоо гарсан.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсаны дараа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулагдаж дээрх шаардагдах хөрөнгө оруулалтын томсгосон тооцоог тусгаж Засгийн газрын тогтоолоор батлагдах тул энэ хөрөнгө оруулалтын томсгосон тооцоог улс, нийслэлийн төсөвт 2040 он хүртэл үе шаттай тусгагдаж хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай гэдэг үүднээс зардлын тооцоонд тусгав.

**1.4. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд олон нийтэд сурталчлах үйл ажиллагаа**  
Батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй эхлүүлэх үүднээс иргэд олон нийт, аж ахуй нэгж байгууллагад хандсан хөгжлийн ерөнхий ерөнхий

төлөвлөгөөний товч утга, агуулга, үр дүн, ач холбогдлын талаар ойлголт бүхий 30 секундэн бичлэг бэлтгэж 1 жилийн турш телевиз, вэб сайтуудад байршуулж, сурталчлах ажлыг зохион байгуулна.

**Хүснэгт 9. Телевиз, вэб сайтуудад байршуулах зардлын тооцоо**

№	Телевиз, сайт	Цаг/Нэвтрүүлэг	Үнэ төгрөг /сек/	Бичлэгийн хэмжээ /сек/	Нийт давтамж	Нийт үнэ /сая төгрөг/
1	Бичлэг хийлгэх	-	2,000,000	30	1	60.0
2	Телевиз – 1	06:00-12:00	12,000	30	365	131.4
3	Телевиз – 1	18:00-00:00	3,500	30	365	38.3
4	Телевиз – 1	Бичлэг цацах /1сек/	7,000	30	365	76.7
5	Вэб сайт	Мэдээнд 1 цаг байрших, үндсэн хэсэгт шилжих	770,000	-	365	281.1
<b>Нийт дүн</b>		-	-	-	-	<b>587.4</b>

*Тайлбар: Жишиг зардлын тооцоог урьдчилан авч байсан телевиз, сайтуудын үнийн саналд үндэслэв.*

**1.5. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд, олон нийтэд нээлттэй болгож, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх**

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, хөгжлийн газар нь Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цахим барилгын нэгдсэн систем/e-BARILGA/-ийг ГЗБГЗЗГ-ын орон зайн мэдээллийн сантай холбогдох боломжийг хангасан нээлттэй эх үүсвэрийн PostgreSQL, PostGIS, QGIS зэрэг программ хангамж болон вэбэд суурилсан платформ программ /шинээр зохиох/ ашиглан байгуулна. Нийт зардалд 800 сая төгрөг шаардлагатай.

**Хүснэгт 10. Программ шинээр зохиох ажлын хүрээнд хийгдэх ажлууд, зардлын төсөөлөл**

№	Хийгдэх ажлууд	Зардал
1	Хот байгуулалтын мэдээллийн санг шинэчлэн зохион байгуулах - Нээлттэй эх үүсвэрийн /open source/ программ хангамж ашиглан Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн өгөгдлийн санг шинэчлэх, нэгдсэн стандартад оруулах	800.0 сая төгрөг
2	Цахим барилгын нэгдсэн систем /e-Barilga/ - Шинэчлэгдсэн хот байгуулалтын мэдээллийн санг ашиглан Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламжийн зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг вебэд /web based/ суурилсан e-BARILGA систем /web based platform/ шинээр байгуулан олон нийтэд ил тод нээлттэй болгож цахимжуулах.	
3	Гар утасны аппликейшн /төрийн үйлчилгээ/ - Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны Хур, Дан системүүдэд холбогдон шаардлагатай мэдээллийг татаж авах, төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс давхар шаардахгүй байх боломжийг бүрдүүлнэ. Уг систем нь e-Mongolia төсөлтэй холбогдсон байна.	

*Эх сурвалж. Хот байгуулалт, хөгжлийн газар*

Хүснэгт 11. Нийт төрийн байгууллагын зардал

№	Зардлын чиглэл чиглэл	Нийт зардал /сая төгрөг/
1.1	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлээ хийх	167.15
1.2	Хууль эрх зүйн орчныг сайжруулах	1,997.5
1.3	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний шаардагдах хөрөнгө оруулалтын томсгосон тооцоо	94,802,259.35
1.4	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд олон нийтэд сурталчлах	587.4
1.5	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд, олон нийтэд нээлттэй болгож, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх	800.0
1.6	Зураг төсөл боловсруулах	32,323.52
	Нийт	94,838,134.92

Эдгээр нэмэлт зардлаас гадна холбогдох төрийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, оновчтой ажил үүргийг хуваарилалт шаардлагатай байгааг анхаарч үзэх нь зүйтэй байна.

## **2. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДАЛ**

Хуулийн этгээдийн зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Зардлыг тооцох;
- Тоон үзүүлэлтийг тооцох;
- Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- Хялбарчлах боломжийг ашиглах;
- Нэмэлт зардлыг тооцох

Аргачлалын 2.3-т хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг тогтоохоор дурдсан байна.

Аргачлалд зардлыг тооцохын тулд ажилтны ажлын хөлс, мэдээлэл бэлтгэн гаргахтай холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг нэг бүрчлэн тооцох шаардлагатай.

### **Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:**

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, нийслэлийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөж, үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тооцож байна.

Боловсруулсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийт шаардагдах хөрөнгө оруулалтын томсгосон тооцоог 2040 он хүртэлх хугацаанд тооцоолоход нийт 236 их наяд 219 тэрбум төгрөг гарч байгаагийн 60% буюу 148 их наяд 745 тэрбум төгрөг /Хүснэгт 7./-ийг хувийн хэвшлийн дотоодын болон гадаадын санхүүжилтийн эх үүсвэрүүдээр санхүүжүүлэх шаардлагатай тооцоолол гарсан.

Эхний үе шатанд буюу 2030 он хүртэл томсгосон тооцооллоор 87 их наяд 475 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаагаас 35% буюу 37 их наяд 801 тэрбум төгрөгийг хувийн хэвшлээс санхүүжүүлэх шаардлагатай тооцоолол гарсан.

## **3. ИРГЭНИЙ ЗАРДАЛ**

Батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ хот байгуулалт, хот дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд олон нийт, иргэдийн оролцоог хангаж, санал авч, төлөвлөж, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэдийн төлөөллийн байгууллагаар дамжуулан оролцох нөхцөлийг бүрдүүлж хуулинд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Олон нийт, иргэд хот байгуулалтын үйл ажиллагаа, хот дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбай дахь газар, үйл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгчтэй гурван талт харилцан үр ашиг, үр дүнтэй байх зарчмыг баримтлан оролцоно.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд иргэнд шууд зардал үүсгэсэн заалт байхгүй бөгөөд батлагдах хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь "Амьдрахад таатай орчин бүрдсэн хот" болох зорилготойгоор боловсруулагдсан бөгөөд иргэдийн өдөр тутмын амьдралын шууд болон шууд бус зардлыг бууруулахад чиглэсэн чухал ач холбогдолтой.

## **4. ЗУРАГ ТӨСЛИЙН ЗАРДАЛ**

Зураг төслийн ажлын үе шатны дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн дараачийн шатны зураг төслүүд хийгдэнэ. Үүнд:

- Салбарын мастер төлөвлөгөө
- ТЭЗҮ-ийн ажлууд
- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө

### **Дагуул, хаяа хот тосгод**

Улаанбаатар хотын Захирагчийн 2017 оны А/18, А/917 Захирамжуудаар нийслэл Улаанбаатар хотын дагуул хот, тосгон суурингуудын нутаг дэвсгэр, хилийн цисийг тогтоосоны дагуу Улаанбаатар хотын татлцал нөлөөллийн бүс орчмын 11 сууринд ерөнхий төлөвлөгөө болон тодотголын ажлуудыг хийнэ. Дагуул хаяа хот тосгодын ЕТ-ний төсөвт өртөг 5.3 тэрбум төгрөг шаардлагатай байна.

- Налайх хот 4.5 мянган га - 745
- Багануур хот 3 мянган га - 497

- Багахангай тосгон 4.5 мянган га - 745
- Хонхор 1.8 мянган га - 298
- Гацуурт тосгон 1.2 мянган га - 199
- Био-Сонгино, Туул-Шувуу тосгон 4.9 мянган га - 811
- Өлзийт хороо 1.2 мянган га - 199
- Аргалант-Эмээлт 5.9 мянган га - 977
- Жаргалант тосгон 0.4 мянган га - 210
- Рашаант тосгон 0.4 мянган га - 210
- 361-ийн гарам 2.4 мянган га - 397

#### Дэд төвүүд

Улаанбаатар хотын төлөвлөлтийн бүсүүдийн 2 төв, 5 төвүүдэд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байгаа бөгөөд 2027 оны түвшинд хэрэгжилтийн явцыг хянасаны үндсэн дээр дахин тодотгол хийх эсэхийг шийдвэрлэн төсөвт тусгана. Мөн шинээр 5 хотын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинээр хийх шаардлагатай бөгөөд төсөвт тусгав.

#### Нэгж хорооллууд

Төлөвлөлтийн шийдлийн хүрээнд 12 хот, 42 хороолол бүхий нэгжтэйгээр хөгжих тул цаашид 47 нэгж хорооллоор хийгдсэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, 42 нэгж хорооллоор хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болгон шинэчлэх шаардлагатай тул төсөвт тусгах саналтай байна.

Хүснэгт 12. Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой эхний ээлжийн урсгал зардал

Д/д	Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой эхний ээлжийн урсгал зардал	1 жилийн зардлын тооцоо /сая төгрөг/
1	Улаанбаатар хотын 12 хотын ерөнхий төлөвлөгөө	5,736.02
2	Дагуул хотууд /нийт 14 дагуул хот тосгодын ерөнхий төлөвлөгөө, тодотголууд/	5,287.5
3	Нэгж хорооллууд /нийт 42 хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тодотгол/	16,800.0
4	Салбаруудын мастер төлөвлөгөө, ТЭЗҮ /Хотоос гаргах болон хязгаарлах шаардлагатай салбаруудын ТЭЗҮ-ийн ажлууд/	3,000.0
5	Хотын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө /5 төв/	1,500.0
	<b>Нийт</b>	<b>32,323.52</b>

#### 5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд заасны дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах нийт зардлыг дараах байдлаар тооцсон болно.

Хүснэгт 12. Нийт зардал

№	Зардлын чиглэл чиглэл	Нийт зардал Сая.төг
<b>1. Урсгал зардал /1 жилд/</b>		
1.1	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлээ хийх ажилтны цалин хөлс	167.15
1.2	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд олон нийтэд сурталчлах	587.40

1.3	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд, олон нийтэд нээлттэй болгож, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх	800.00
<b>2. Хөрөнгө оруулалт 1 удаагийн зардал, хөрөнгө оруулалт</b>		
2.1	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд, олон нийтэд нээлттэй болгож, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх	800.00
2.2	Хууль эрх зүйн орчныг сайжруулах	1,997.50
2.3	Зураг төсөл батлуулах /Хүснэгт 12-с харна уу/	32,323.52
2.4	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд олон нийтэд сурталчлах	587.40
2.5	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэд, олон нийтэд нээлттэй болгож, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх програм хангамж хөгжүүлэлт	800.00
<b>3. Ерөнхий төлөвлөгөөний хөрөнгө оруулалтын зардал /жилд дунджаар/</b>		
3.1	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний шаардагдах хөрөнгө оруулалтын томсгосон тооцоо	5,576,603.4
	Нийт	5,615,666.4

Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх эхний жилийн зардал – 5,615.6 тэрбум төгрөг, цаашид жилд дунджаар 5,576.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр байна.

Цаашид ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих 1 жилийн зардалд ажил – 167.15 сая төгрөг

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэрэгжилттэй холбоотойгоор иргэнээс зардал гарахгүй гэсэн төсөөлөл хийгдлээ.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь 2040 он хүртэл буюу урт хугацаанд хэрэгжих хот байгуулалтын баримт бичиг бөгөөд хэрэгжилтийн хугацаанд тухайн үеийн нөхцөл байдлын улмаас шинээр үүсэх харилцааг хариуцах төрийн байгууллагын чиг үүрэгтэй холбогдон гарах зардлын тооцоог оруулаагүй болно.

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, зардлын тооцоо өндөр гарч байгаа боловч төлөвлөлтийн дагуу хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдэж чадсанаар Улаанбаатар хотод тулгамдаж байгаа авто замын түгжрэл, төвлөрөл, агаар, хөрсний бохирдол гэх мэт тулгамдсан асуудал шийдэгдэх ач холбогдолтой байна. Ийм үр дүнд хүрэхийн тулд шаардлагатай хүний нөөц, санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой бүрдүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй:

**“УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”  
БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХҮРГҮҮЛСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ТОВЪЁГ**

УБХЕТ-2040 ажилд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулах ажилд 2024 оны 09 сарын 28-аас 10 сарын 15 хүртэлх хугацаанд 2 үндэсний хороогоос 6 санал, 16 яамдаас 52 санал, 37 агентлагаас 131 санал, 6 дүүргээс 17 санал, 383 иргэдээс давтагдсан тоогоор 4597 санал, бусад байгууллагаас 10 санал тус тус ирсэн. Төслийн хэмжээнд нийт 542 саналыг хүлээн авч 60-70% ийг тусгасан байдалтай байна.

**АГЕНТЛАГ**

№	Ангилал	Хүргүүлсэн мэдээлэл, санал	Тайлбар
1	Хот байгуулалт, хотын стандартын газар	<p>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай газар чөлөөлтийн урт хугацааны төлөвлөгөө гаргах</p> <p>Газар чөлөөлтийн зардлыг бүтээн байгуулалт хийх ажлын зардалтай хамтагтах</p> <p>Төлөвлөлтийн бодлого дахь “га” талбайг тодорхой болгон бичих</p> <p>Хотуудын эдэлбэр газарт ороогүй суурьшлын хил, зааг цаашдын чиг хандлагыг тодорхойлох асуудлыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд оруулж өгөх</p>	<p>Газар зохион байгуулалтын салбарын тайланд нарийвчилсан тоо хэмжээг тусгасан ба газар чөлөөлөх урт хугацааны төлөвлөгөө гэж тусдаа салахгүй бөгөөд гэр хорооллыг шинэчлэн зохион байгуулах, гэр хорооллыг орон сууцжуулах, авто замын сүлжээг сайжруулах гэх мэт төсөл хөтөлбөртэй уялдсан салбар дундын төлөвлөгөө байна. УБЕТ 2040-д ерөнхий байдлаар тусгасан.</p> <p>Газар чөлөөлөх шаардлагатай газрын нөхөх олговорын дүнг УБЕТ 2040-ийн томсгосон төсөвт тусгасан</p> <p>Бүс, газар ашиглалтын га талбайг тодорхойлон салбар болон нэгдсэн тайлангуудад тусгасан.</p> <p>Хотуудын эдэлбэр газарт ороогүй бусад суурин, зуслангийн бүсүүдийн хил заагийг тодорхойлж, цаашид баримтлах дэглэм, авах арга хэмжээний санал, завлэмжийг тусгасан.</p> <p>Нийслэлийн хэмжээнд хот байгуулалтыг хориглох, хязгаарлах, дэмжих бүсүүд болон эдгээрт байх газар ашиглалтыг тодорхойлж, цаашид баримтлах дэглэм, авах арга хэмжээний санал, завлэмжийг тусгасан. БХБ-ын сайдын 2020 оны 57 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөмж”-д газар ашиглалтын ерөнхий бүсчлэл болох “Хот, тосгон бусад суурин ерөнхий бүс” нь Хот байгуулалтын тухай хуулийн 13-р зүйл “Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэл”-ийн дагуу боловсруулдаг. Тус зөвлөмжийн 9.2.9-д Хот, тосгон бусад суурин газрын газар ашиглалтын дэлгэрэнгүй бүсчлэлийг</p>
		<p>Нийслэлийн газар нутагт газар ашиглалтыг бүсчлэн тогтоож газар зохион байгуулалтын бүс архитектур орон зайн төлөвлөлтийн бүсүүдийг нийцүүлэх</p>	

			<p>хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр, аймгийн хэмжээнд газар ашиглалтын дэлгэрэнгүй бүсчлэлийг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөгөөр гаргахаар заасан байдаг.</p> <p>Иймд газар зохион байгуулалтын бүс, архитектур орон зайн төлөвлөлтийн бүсүүдийг "Нутаг дэвсгэрийн бүс"-д нэгдсэн байдлаар тусгаж, төлөвлөлтийн шийдлийг боловсруулсан.</p> <p>Инженерийн шугам сүлжээг өргөтгөх боломжтой байршлуудын судалгааг "Дулаан хангамж", "Ус хангамж, ариутгах татуурга"-ын тайланд туссан. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2015 оны А/200 дугаар тушаалаар "Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга зүй"-г, түүний хавсралтаар "Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын шалгуур үзүүлэлт"-ийг баталсан. Иймд УБЕТ 2040 нь шинэ хотын төлөвлөгөө биш тул "Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ"-ний дагуу "Нутаг дэвсгэрийн бүс"-ийн үнэлгээг хийж тайланд тусгасан болно.</p> <p>Өнөөгийн үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль"-ийн дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн газар ашиглалтын горим дэглэмд өөрчлөлт оруулах замаар газрын харилцааг зохицуулах саналыг тусгасан.</p> <p>"Газрын хэвлийн тухай хуулийн 4.1-д Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ." гэж заасан байдаг ба УБЕТ 2040- өөр газар дээрх хот байгуулалтын үйл ажиллагааг зохицуулах тул энэ төлөвлөлтөөр зохицуулах боломжгүй байна. Харин нийслэлийн нутаг дэвсгэрт байх ашигт малтмалын газарт авах арга хэмээний зөвлөмжийг тайланд тусгасан.</p>
Архитектур орон зай	<p>Инженерийн шугам сүлжээг өргөтгөх боломжтой байршлуудын судалгаа, Газар зохион байгуулалтын тохиромжтой байдлын үнэлгээ, Газрын харилцааны хууль эрх зүйн байдлын зохицуулалт, Газрын хэвлийн-хэстийн төлөвлөлт болон эрх зүйн байдлын судалгаа</p>	<p>1. Нутаг дэвсгэрийн үндсэн бүс</p> <p>14 хотын үзэл баримтлал: Хотыг тусгай үүрэг бүхий 14 бүс болгон хувааж, эдгээрийг тус</p>	
	Архитектур орон зай	<p>1. Нутаг дэвсгэрийн үндсэн бүс</p> <p>- 20 минутын хот, 14 хотын үзэл баримтлалыг уялдуулан тусгах</p>	<p>1. Нутаг дэвсгэрийн үндсэн бүс</p>

	<p>- Одоогийн барилгажилттай уялдуулан бүсчлэлийг тогтоох, Төвийн бүс, Хан-Уул дүүрэг 15 дугаар хороо орчим, төлөвлөлтийн Зүүн бүс, Дүнжингарав орчим, төлөвлөлтийн Баруун өмнөд бүс, Нисэх, Яармаг орчим. Гэх мэт</p> <p>2. Амьдралын орчин сайжруулах “20 минутын хот”</p> <p>- 20 минутын явган алхалтаар авах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор түүнд саад учруулах орц, гарц хаасан зөрчлүүд, нийтийн эзэмшлийн талбайг чөлөөтэй, нээлттэй байлгах, хашаа хайсны стандартын дагуу байлгах боломжийг бүрдүүлэх</p> <p>3. Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн чиглэлээр</p>	<p>тусад нь бие даасан хөгжил бүхий нэгж хот болгон төлөвлөсөн.</p> <p>Мөн О.Н.3-тэй 14 хотыг 42 нэгж хороололтой байхаар төлөвлөж Хотын аль ч бүсээс 20 минутын дотор алхах, унадаг дугуйгаар явах эсвэл нийтийн тээврээр зорчих боломжтойгоор бүсүүдийн үйл ажиллагааг төлөвлөсөн.</p> <p>2. Мьдралын орчин сайжруулах “20 минутын хот”</p> <p>Тайлбарт нэмэлтээр “20 минутын хот” үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>Орц, гарц хаасан зөрчлийг арилгах:</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Нийтийн эзэмшлийн зам, талбайг саадгүй, чөлөөтэй болгох.</li> <li>○ Хууль бус хашаа, байгууламжийг албадан чөлөөлөх.</li> </ul> <p><b>Нийтийн эзэмшлийн талбайг нээлттэй байлгах:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>○ Газрын кадастрын мэдээлэлд үндэслэн хязгаарыг тодорхойлж, хяналт хийх.</li> <li>○ Нийтийн талбайг иргэдийн ашиглалтад чөлөөтэй байлгах нөхцөлийг бүрдүүлэх.</li> </ul> <p><b>Хашаа, хайсны стандартыг мөрдүүлэх:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>○ Хэт өндөр, хаалттай хашаанаас татгалзаж, стандартын дагуу үзэмжтэй, хүртээмжтэй хашаа хэрэглэхийг шаардах.</li> </ul> <p>Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр иргэдийн аюулгүй, хүртээмжтэй, амьдрахад таатай орчин бүрдэнэ.</p> <p>3. Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн чиглэлээр</p>
--	--	--

		<p>- Эмээлт хотын нэр томъёоллыг Аргалант-Эмээлт хот гэж өөрчлөн найруулах. Тайлбар бичигт Эмээлт хот, Эмээлт Аргалант хот гэж 2 янзын бичиглэлтэй боловсруулагдсан байна. “Аргалант-эмээлт” хотын томъёоллоор боловсруулах саналтай байна.</p> <p>- Бүсийн орон зайн зураглал, Бүсийн таталцал нөлөөллийн зураглалд Майдар сити хотыг хамтад нь зураглаж, Улаанбаатарын бүсийн зураглалд Майдар хотыг зураглалаас хасах саналтай байна. Засгийн газрын 55 дугаар тушаалаар Майдар хот нь төв аймгийн нутаг дэвсгэрт харьяалагдана. Нийслэлийн дагуул хот биш болно.</p> <p>- Шаргаморьт хотын суурьшлын бүсийн төлөвлөлт, Агро сити хотын суурьшилд тэргүүлэх чиглэлийн дагуу бие даасан дагуул хот бий болох хөгжлийн төсөвлөлийг нэмэлтээр судлан тусгах шаардлагатай байна. Агросити болон Шаргаморьтын суурьшилд хөгжлийн төлөвлөлт нь тайлбар бичиг болон зураглалд тодорхой тусгагдаагүй байна. Агроситигийн хөгжлийн хөшүүрэг нь эдийн засгийн тусгай бүс. Тайлбар бичигт хуучин 3 суурьшлын хэмжээнд нь авч боловсруулсан байна. Логистикийн 2 төв, тэр дундаа Зүүн бүсийн логистикийн төвийн төлөвлөлтийн Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүстэй уялдуулж боловсруулах шаардлагатай. Улаанбаатар хотын төвлөрлийг задлах бодлого болон үйлдвэр аж ахуйн нэгжүүдийг хотоос нүүлгэн шилжүүлэх бодлоготой Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулж боловсруулах шаардлагатай. “Налуу-Ухаа” эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагаа 2025 онд эхэлж байгаа учир тусгай бүсийн чиглэлийг</p>
	<ul style="list-style-type: none"> <li>○ 2040 оны Ерөнхий төлөвлөгөөнд Эмээлт нэрээр тусгагдсан</li> <li>○ Зураглалд Майдар сити байршлийг заасан томъёоллоор орсон.</li> <li>○ УИХ-ын 72 дугаар тогтоолын дагуу Шаргаморьт болон Агро Сити дагуул хотуудын хилийн цэс, хамрах нутаг дэвсгэр, хөгжлийн төвүүд, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хүн амын бүтэц, ажиллах хүчийг тодорхойлж, төлөвлөлтийн шийдэлд бүрэн тусгасан.</li> <li>○ Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийг Налайх улсын зэрэглэлтэй хотын хөгжлийн тэргүүлэх чиглэл, төлөвлөлтийн шийдэлтэй уялдуулан төлөвлөсөн. Улаанбаатар хотын зүүн бүсэд төлөвлөж буй логистикийн төвтэй тусгай бүс нь авто зам болон төмөр замаар харилцан холбогдох боломжтой. Гэсэн хэдий ч, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн үндсэн үйл ажиллагаа болон тэргүүлэх чиглэл нь зүүн бүсийн логистикийн төвөөс ялгаатай байхаар төлөвлөгдсөн. Энэ нь бүс нутгийн хөгжлийн онцлогийг тодотгон, үүрэг хариуцлагыг тодорхой болгоход чиглэгдэнэ.</li> </ul>	

		<p>дурдаж, тодорхой санал дэвшүүлж, оруулах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотыг хүнсээр хангах зорилгод Агросити эдийн засгийн тусгай бүсийн хөгжил, ач холбогдлыг тусгаж өгөх 14 хотын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж баримт бичигт тусгах</li> </ul>	<p><b>4. Дэд төвийн чиглэлээр</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 2 хотын төв, 6 дэд төв, 5 дэд төв гэдгийг дэд төвийн ойлголтыг О.Н.3 14 хот 42 нэгж хороололд хуваан нэгж хороололын төвүүдийг дэд төв гэсэн нэр томъёоллоор тусгасан.</li> <li>- 182 дугаар хуудсанд “Орчин үед соёлын төв, театрын урлагийн үйл ажиллагааг сонирхогчийн тоо төдийлэн их биш, үйл ажиллагаа нь хязгаарлагдмал хүрээнд байдагтай уялдуулан төлөвлөлтөөр дагуул хотуудын соёлын төвийн тоог нормын дагуу УБ хотын хувьд Үндэсний урлагийн их театрыг оролцуулан дэд төвүүд дээр тус бүр нэг маягийн зураг бүхий 850 суудалтай соёлын төвийг байгуулна” гэж төлөвлөснийг дахин нягтлах. Соёлын төвийн тоог нормын дагуу 14 бүс /хот/-той уялдуулан төлөвлөх</li> <li>- Цаашид олон нийтийн төв гэж төлөвлөлтөд байх эсэх? Төлөвлөлтөд хэд хэд дурдагдсан байна. Хэрэв байхгүй бол тайлбар бичгээс тэр хэсгийг нь хасах</li> <li>- 42 хорооллын төв гэж явах юм уу? 42 дэд төв гэж явах юм уу? Тодорхой зааж нэг нэр томъёололтой байх, 144 хуудсанд дурдсан хотын төвүүдийн ....га-г тодорхой болгох</li> </ul>
<p><b>4. Дэд төвийн чиглэлээр</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 2 хотын төв, 6 дэд төв, 5 дэд төв гэдгийг дэд төвийн ойлголтыг О.Н.3 14 хот 42 нэгж хороололд хуваан нэгж хороололын төвүүдийг дэд төв гэсэн нэр томъёоллоор тусгасан.</li> <li>- О.Н.3-тэй 14 хотод соёлын төвүүдийг нормын дагуу төлөвлөсөн төлөвсөн.</li> <li>- Тайлангаас олон нийтийн төв гэх нэршилгүйг хассан.</li> <li>- 42 нэгж хороолол төвийг дэд төв гэх нэрээр тодорхойлсон. О.Н.3-тэй 14 хотын тайлбайг эцэслэн тодорхойлсон</li> </ul>	<p><b>5. Хот байгуулалтын үйл ажиллагаа</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэвээр хадгалж шинэчлэн сайжруулах бүс нь 14 хотуудын төв болон нэгж хорооллын дэд төвүүдтэй уялдуулан төлөвлөсөн.</li> <li>- Тухайн Хан-Уул дүүргийн хороонд хамрагдах нутаг дэвсгэр нь суурьшлын бүс бүхий тусгай хамгаалалттай газар нутагт харагдах бөгөөд УБ хотын 2040</li> </ul>		
<p><b>4. Дэд төвийн чиглэлээр</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 2 хотын төв, 6 дэд төв, 5 дэд төв гэдгийг дэд төвийн ойлголтыг О.Н.3 14 хот 42 нэгж хороололд хуваан нэгж хороололын төвүүдийг дэд төв гэсэн нэр томъёоллоор тусгасан.</li> <li>- О.Н.3-тэй 14 хотод соёлын төвүүдийг нормын дагуу төлөвлөсөн төлөвсөн.</li> <li>- Тайлангаас олон нийтийн төв гэх нэршилгүйг хассан.</li> <li>- 42 нэгж хороолол төвийг дэд төв гэх нэрээр тодорхойлсон. О.Н.3-тэй 14 хотын тайлбайг эцэслэн тодорхойлсон</li> </ul>	<p><b>5. Хот байгуулалтын үйл ажиллагаа</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэвээр хадгалж шинэчлэн сайжруулах бүс нь 14 хотуудын төв болон нэгж хорооллын дэд төвүүдтэй уялдуулан төлөвлөсөн.</li> <li>- Тухайн Хан-Уул дүүргийн хороонд хамрагдах нутаг дэвсгэр нь суурьшлын бүс бүхий тусгай хамгаалалттай газар нутагт харагдах бөгөөд УБ хотын 2040</li> </ul>		

			<p>байгаа суурьшил үүссэн хэсгийн нутаг дэвгэрийн бүсчлэлд тусган хууль, эрх зүйн зохицуулалт хүрээнд зөвшөөрөгдөх ашиглалтын тусгаж гудамж замын сүлжээг тодорхой болгох.</p> <p>- Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Барилгын материал, түүхий эд болон хүнд, хөнгөн үйлдвэрийн бүс, олон нийт, орон сууцны бүсийг тус тусад тусгах Налайхын үйлдвэр технологийн паркруу шилжүүлж уялдуулан тусгах.</p> <p>- Улаанбаатар хотын тэлэлт суурьшилтай холбоотой Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан үйлдвэрийн бүсчлэлд ахин судалгаа хийж бодит байдалтай уялдуулах. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хот төлөвлөлтийн бүсчлэлийн зөвшөөрөгдөх ашиглалтад Төрийн дээд байгууллагуудын шийдвэр болон цаг үеийн онцгой нөхцөл байдал (Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хийгдэж буй нийгэмд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэсэн хөрөнгө оруулалт, барилга байгууламж (Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, музей, соёлын төв, бусад барилга гэх мэт)-ийг зайлшгүй шалтгаан)-ын улмаас хот байгуулалт, орчны барилгажилтад нийцүүлэн бусад бүсэд төлөвлөх эрхийг нээх.</p> <p>- 136-р хуудас Дахин төлөвлөж хөгжүүлэх газар нутаг: “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль”-д шинэчлэн найруулга хийж түүнийг даган батлагдсан журмууд, дахин төлөвлөлтийн стратеги төлөвлөгөө боловсруулж дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулж сайжруулах. гэж тодорхой оруулах. 210-320 хүн/га-аас “хэтрүүлэхгүй төлөвлөнө” гэж заах.</p>	<p>оны ерөнхий төлөвлөгөөний үндсэн болон дэд бүсүүдэд тусгасан.</p> <p>○ Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр нь 2040 оны төлөвлөлтөнд үйлдвэр болон үйлдвэрийн холимог ашиглалтай бүс байх ба Налуу-Ухаа тусгай бүсрүү шилжүүлэх хүнд хөнгөн үйлдвэрийн судалгааг дараагийн шатны зураг төсөлд тусгах нь зүйтэй,</p> <p>○ Улаанбаатар хотын тэлэлт суурьшилтай холбоотой Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан үйлдвэрийн бүсийн судалгааг дараагийн шатны зураг төсөлд хийнэ. 2040 оны дэд бүсчлэлд орон сууц болон олон нийтийн холимог бүс нэмэлтээр тусгагдсан энэ нь цаг үеийн онцгой нөхцөл байдал Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төслүүдийг тусгах боломжийг нээнэ.</p>	<p>Бүсийн аялал жуулчлалд 5 төрлөөр хөгжүүлэхээр тусгагдсан.</p>
	<p><b>Аялал жуулчлалын</b></p>	<p>Аялал жуулчлалын бүсүүдийн маршрут, дарааллыг тодорхой болгон одоо байгаа</p>			

	хөгжлийн чиг хандлага		<p>Хотын хэмжээнд аялал жуулчлалын 3 тэнхлэг, 11 маршрут төлөвлөгдсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>○ 1-р тэнхлэгт түүх соёл, хотын гол үзмэрүүд,</li> <li>○ 2-р тэнхлэгт шинээр төлөвлөгдсөн 14 хот бизнесийн дүүрэгт төлөвлөгдсөн худалдаа үйлчилгээ,</li> <li>○ 3-р тэнхлэгт алслагдсан хэсэгт зориулсан уулын өндөрлөг, иргэдийн амралт зугаалгын хэсэг тус тус төлөвлөгдсөн.</li> </ul> <p>Хотын аялал жуулчлалд холимог аялал, шашны аялал, үзэрийн аялал болон бие даасан 7 хэсэгт бизнес, танин мэдэхүйн аяллын маршрут тус тус төлөвлөгдсөн.</p>
	Түүх соёлын үл хөдлөх өв дурсгалын хадгалалт хамгаалалт	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг түүх соёлын өвийн барилга байгууламжид оруулсан асуудлыг тодруулан төлөвлөлтийн шийдлийг тусгах	<p>“Хот,суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хуульд тусгагдсан ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламж буулгах тухай хууль нь соёлын өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалд хамаарах барилга байгууламжид хамаарахгүй гэж заасан байдаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэрэгжүүлэх арга хэмжээнд тус асуудалд холбогдох яамд, ТББ, мэргэжлийн зөвлөл байгуулж хүчитгэх, буулгах, сэргээн засварлах тухай санал зөвлөмжийг үндэслэж шийдлийг гаргаж байхаар тусгасан.</li> </ul> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийн иргэдийн сонсгол зөвхөн тухайн барилгын оршин суугчид СӨХ-ийн оролцоотойгоор шийдвэрлэгддэг.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн барилгын орчинд өртөж буй иргэд хувь хүнээс санал авдаггүй нь учир дутагдалтай байна.</li> </ul> <p>Одоо байгаа барилга байгууламжийг нурааж дахин барилгажуулахад барилгын компаниудын ашиг сонирхлоос хамаарч өндөр барилга барьж өндөр нягтралтай болж байгааг анхаарч хотын ансамбель харагдах орчин соёлын биет бус өв иргэдийн дурсамж зэргийг харгалзах талаар тусгасан болно.</p>
	Гамшгийн менежмент	- Нүүлгэн шилжүүлэх байршлыг нэмэгдүүлэх, цуглах талбайн таталцлыг судлан нүүлгэн шилжүүлэх байршил руу хаанаас цуглуулан шилжүүлэх хөдөлгөөний схемийг төлөвлөх, үе шат дарааллыг тодруулан тусгах. Яармаг орчимд гал унтраах	<ul style="list-style-type: none"> <li>- Нүүлгэн шилжүүлэх байршил одоогийн байдлаар бүсийн хэмжээнд нийт 31 байгаа бөгөөд 2040 оны түвшинд нийт 32 байршлыг шинээр төлөвлөсөн. Мөн нүүлгэн шилжүүлэх гол болон туслах замын</li> </ul>

		<p>аврах анги нэмэгдүүлэх, Гол замын болон туслах зам трасс төлөвлөн чиглэлийг тодорхой болгох.</p> <p>- Түр хорогдох байрны тоон мэдээллийг засах</p>	<p>схем, чиглэлийг тодруулан тусгасан. MNS 6412:2013 стандартын дагуу Яармаг орчимд гал түймэр унтраах аврах ангийг төлөвлөв.</p>
		<p>Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж байгаа хэдий ч Гамшгийн үеийн болон сэргэх төлөвлөгөөтэй болох шаардлагатай.</p>	<p>- 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/1511 дүгээр захирамжаар баталсан түр хоргодох байр – 344ш байх ба энэ нь одоогийн байдлаар хүн амд хүрэлцээгүй байгаа тул УБХЕТ2040 төлөвлөлтөөр 184 хоргодох байрыг нэмж төлөвлөсөн.</p>
	<p><b>Хог хаягдлын менежмент</b></p>	<p>Аюултай хог хаягдлыг түр хадгалах, саармагжуулах, дахин боловсруулах бүсийг суурьшлын бүсээс гаргах</p>	<p>Энэхүү төлөвлөгөө нь ОБЕГ-т нарийвчилсан байдлаар хийгддэг ба УБЕТ 2040- ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна.</p> <p>Аюултай хог хаягдлыг түр хадгалах, саармагжуулах, дахин боловсруулах бүс нь “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм” БНБД 30.01.04- ийг хангасан байна.</p> <p>Шинжлэх ухааны сорилт судалгаа хийх зориулалтаар сургууль, лабораториос гарсан хаягдал, ахуйн хог хаягдлаас гарах батарей, зарим нэр төрлийн цахилгаан бараа гэх мэт аюултай хог хаягдлыг тусгай зориулалтын хайрцаг, саванд хуримтлуулж, устгалд явуулах агуулах бөгөөд тус бүр 300 м<sup>2</sup> байна. Одоогийн байдлаар Цагаан давааны төвлөрсөн хог хаягдлын цэгт нэг байгаа ба Нарангийн энгэр, Цагаан даваанд дахин 1 ширхэг , Налайх, Багануурт тус бүр нэгийг шинээр нэмж төлөвлөв.</p>
	<p><b>Зам тээвэр, гудамж замын чиглэлээр</b></p>	<p>1. Гудамж замын төлөвлөлтийг хэрэгжүүлэх хугацаа, богино хугацаанд хийх ажлуудын дарааллыг гаргаж, төлөвлөгөөнд тусгах. Жишээ нь: Эхний ээлжид - Хэвээр хадгалж үлдээх нутаг дэвсгэрт туслах замыг нэмэгдүүлэх, барилга, хотхон хооронд чөлөөтэй алхах нарийн явган замыг бий болгох, явган замыг авто замын хорт утаанаас</p>	<p>1. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хугацаа болон дарааллыг Эдийн засаг, хөрөнгө оруулалтын тайланд тусгасан. Хороолол, хотхон доторх нарийн явган замын төлөвлөлтийг барилгажилтын төсөл болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шатанд нарийвчлан тусгана.</p>

		<p>тусгаарлаж ногоон байгууламж төлөвлөх гэх мэт.</p> <ol style="list-style-type: none"> <li>2. Унадаг дугуйн зам төлөвлөх үед ашигтай байдал буюу дөт шулуун замыг тодорхойлж мэдээллийн сан бүрдүүлж хөгжүүлэх.</li> <li>3. Унадаг дугуйн зам авто замын дунд тусгаарлах зурвас: ногоон зурвас, зам дагуу зогсоол гэх мэт орон зайг төлөвлөж хотын гудамжны норм стандартад оруулах.</li> <li>4. Зам, замын сүлжээ, авто замын ачаа тээвэр, логистикийн хөдөлгөөний менежментталыг анхаарч нэгдсэн сүлжээний зураглалд тусгах.</li> <li>5. Зам, замын байгууламжийн төлөвлөлтийг 20 минут 14 хот үзэл баримтлалтай уялдуулж төлөвлөлтийн шийдэл боловсруулж хот байгуулалтын баримт бичигт тусгах</li> <li>6. Зам, замын сүлжээний улаан шугамыг инженерийн дэд бүтцийн орон зайтай уялдуулж нэгдсэн байдлаар эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>2. Дахин төлөвлөж хөгжүүлэх болон шинээр суурьшил үүсгэх нутаг дэвсгэрт газрын гадаргын өндөржилтийн байдалд тохируулсан байдлаар, мөн хотын чанартай цэцэрлэгт хүрээлэнгүүд, Туул, Сэлбэ, Улиастай зэрэг голуудын ногоон байгууламжийн дагуу амралт зугаалгын зориулалттай дугуйн зам байгуулж, хотын дугуйн замын сүлжээтэй холбохоор тус тус төлөвлөлтөд тусгав.</li> <li>3. Хотын гол гудамж замын сүлжээг авто замын зорчих хэсэг, хамгаалалтын ногоон зурвас, дугуйн зам, явган зам, хамгаалалтын зурвас гэсэн хөндлөн огтлолтойгоор төлөвлөх бөгөөд дугуйн замыг олон улсад мөрдөгдөж буй стандартын дагуу 1.5 м-с багагүй, гудамжны хоёр талаар байхаар тооцож төлөвлөв.</li> <li>4. Ачаа тээвэр, логистик зурагт тусгасан.</li> <li>5. 20 минут хотын үзэл баримтлалтай уялдуулан явган хүний зам болон дугуйн замыг төлөвлөсөн.</li> <li>6. Улаанбаатар болон дагуул хот суурингуудын хилийн цэсийн хүрээнд гудамж замын улаан шугам төлөвлөх ба улаан шугам, хамгаалалтын зурвасын хэмжээг авто замын тэнхлэгээс хоёр тийш нь хэмжиж тогтооно. Хотын гудамж замын улаан шугамын дотор дараах байгууламж хамрагдана. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>▪ Авто замын зорчих хэсэг</li> <li>▪ Тусгаарлах зурвас</li> <li>▪ Ногоон байгууламж</li> <li>▪ Явган зам</li> </ul> </li> </ol>
--	--	---	--

		<p>7. Одоо байгаа болон төлөвлөгдсөн газар доорх нүхэн гарц болон гүүрэн гарцуудыг тэмдэглэж зурагт тусгаж харуулах.</p> <p>8. Олон давхар зогсоол: Хөгжилтэй орны жишгээр олон давхар зогсоолын хэрэгцээ шаардлага буурах чиг хандлагатай, нийтийн тээвэр хөгжлийг дагаж олон давхар зогсоолын эрэлт буурдгаас зогсоолын барилга ашиглалтгүй, үр ашиггүй болдог. Машинд төвлөрсөн барилга байгууламж тул холимог үйлчилгээг давхар нэвтрүүлэх, маш их агаар, дуу чимээний бохирдол бий болгодог тул ногоон байгууламжийг нэвтрүүлж карбон нөхөх буюу net zero carbon emission байхаар төлөвлөлт тусгах</p> <p>9. Метро төслийн эхлэл төгсгөлийг тодруулан шинэчлэн уялдуулах.</p> <p>10. 20 минутын хот концепцийн хүрээнд нийтийн тээврээр үйлчлүүлэх иргэдийн их багтаамжийн зогсоолын байршил болон зогсоолын тоог нарийвчлан тусгаж харуулах.</p> <p>11. Зураглалын материалын 30 хуудас Метро 17,7-оос нэмэгдсэн трассын тайлбар бичгийг нэмж оруулах.</p> <p>12. Өртөө тээвэр, агуулах дээр түшиглэсэн хөгжүүлэлтийн төлөвлөгөө гаргах, газар ашиглалттай уях, одоогийн төмөр замын трасс чөлөөлөлт хийх тохиолдолд барилгажилт</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Дугуйн зам</li> <li>▪ Зорчих хэсгийн дагуу борооны ус зайлуулах шугам</li> <li>▪ Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас</li> </ul> <p>7. Хотын гудамж замын сүлжээний зурагт олон түвшний уулзварууд болон дахин инженерчилэх шаардлагатай уулзваруудын байршлыг тусгасан.</p> <p>8. Төлөвлөлтөөр орон сууцны бүс болон худалдаа үйлчилгээ, олон нийтийн зогсоолын шардлагатай тоо хэмжээг гарган төлөвлөлтийн тайланд тусгасан. Зогсоолын төрөл, байршлыг барилгажилтын төсөл болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шатанд нарийвчлан тусгана.</p> <p>9. Метро төслийн батлагдсан трасс болон зогсоолуудын байршлыг төлөвлөлтөд тусгасан. Мен депо байгуулах байршлыг орон зайн төлөвлөлтөд тусгасан</p> <p>10. Төлөвлөлтийн тайланд багтаамж ихтэй нийтийн тээврийн төрөл тус бүрээр урт, чиглэл, зогсоолын тоо, хүчин чадлыг тусгасан.</p> <p>11. Авто замын салбарын тайлбар бичигт тусгасан.</p> <p>12. Нийтийн тээврийн үйлчилгээний маршрутыг оновчтой, боловсронгуй болгож, багтаамж ихтэй нийтийн тээврийн төрөл нэмэгдсэнээр сүлжээний давхцал болон сүлжээний урт багасаж хүчин</p>
--	--	--	---

			<p>хийхгүйгээр газрыг хотын мэдэлд шилжүүлэн ногоон байгууламж эсвэл BRT, трамвайн зам зэргээр ашиглах</p>	<p>чадал, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ. Хотын нийтийн тээврийн маршрутыг хотын гудамж сүлжээний хэвтээ, босоо тэнхлэгийн дагуу төлөвлөж хөгжүүлэх бөгөөд одоогийн нийтийн тээврийн чиглэлийн давхцалыг арилгаж зорчилтын хугацааг 2-2,5 дахин багасгана. 2040 онд хүртэл метро 42.23 км, LRT 10 км, BRT 61.15 км, агаарын дүүжин тээврийн сүлжээ 7.1 км байхаар төлөвлөв. Автобусны туслах чиглэлүүд богино эргэлтээр хотын захын зорчигчийн үндсэн чиглэлд хүргэх, хотын зах руу түгээх үүрэгтэй байхаар төлөвлөсөн.</p>
		<p><b>Хүн амын төлөвлөлт</b></p>	<p>1. Хүн амын төлөвлөлт УБХЕТ-2040 оны хүн амын тооцоо нь Үндэсний статистикийн Хороо болон ХАНСХЕТ-ийн тооцооноос аль алианаас нь зөрүүтэй байна. Үндэсний Статистикийн хороо нь 2021 онд "Хүн амын шинэчилсэн хэтийн тооцоо 2020-2050" судалгааг шинэчилсэн бөгөөд энэ тооцоогоор 2040 онд УБ хотод 2.146 сая хүн амьдрахаар тооцсон. ХАНСХЕТ тооцоог үзэхэд Улаанбаатар хотын хүн амын тоог харьцуулахдаа Нийслэлийн Статистикийн Газар ба ҮСХ-ны статистикийг шууд харьцуулж тооцсон. НСГ суурин хүн амын тоог мэдээлдэг бөгөөд үүнд бүртгэлтэй боловч гадаадад оршин суугаа хүнийг тоолох, эсвэл орон нутгаас албан ёсоор шилжин ирээгүй боловч нийслэлд амьдарч байгаа хүмүүсийг давхардуулан тоолох тохиолдол байна. ҮСХ-ны 1Б хувилбарт нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд, гадаадын харьяат болон харьяалалгүй иргэдийг хамруулан тооцдог. Энэ утгаараа хотод бүртгэлтэй боловч гадаад оронд удаан хугацаагаар явсан нь Хилийн мэдээгээр нотлогдсон хүмүүсийг хасаж тооцох зэргээр тохируулга хийдэг тул албан ёсны тооцоонд суурь болон хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна.</p>	
	<p><b>Хүн амын төлөвлөлт</b></p>			<p>1. Улаанбаатар хотын хүн амын тоог МУЗГ-ын 2020 оны 5 сарын хуралдаанаар 2040 онд 2.2 сая, үүнээс дагуул хотуудад 600 мянга байхаар тогтоосон. Гэвч Ажлын даалгаварт тусгагдсан ХАНСХЕТ-ын зүгээс үндэсний аюулгүй байдлын хүрээнд монгол улсын нэг бүсэд хэт их нягтралтай байгааг бууруулах шаардлага тавиж орон нутагт 162 мянган хүн амыг суурьшуулах төлөвлөгөөг үзүүлэв. Улмаар шилжих хөдөлгөөнийг зохицуулах байдлаар Улаанбаатар хотын хүн амын тооцоог 2 сая 89 мянга байхаар зөвшилцсөн. УБХЕТ-2040-д бүрэлдэхүүний аргаар хүн амын хэтийн тооцоог хийсэн ба бүрэлдэхүүний аргын онцлог нь хүн амын бүрэлдэхүүн хэсэг болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний ирээдүйн чиг хандлагаар тооцоолдог. Шилжих хөдөлгөөний нөхцөл нь ХАНСХЕТ-д өгөгдсөн бол бусад бүрэлдэхүүн хэсэг болох ТНК, дундаж наслалтын хэтийн тооцоо нь Алсын Хараа-2050-д тусгагдсан байв. Манай байгууллагын зүгээс хүн амын 3 үндсэн тооцоог санал болгосон ба энэ 3 нь дотроо шилжих хөдөлгөөний нөхцлөөс хамаарч дахин 3 хэсэг болж нийт 9 хувилбартай хийгдсэн. Үндсэн 3 нөхцөл нь 1/ ХТСИ-ын тооцоо 2/ ҮСХ-ны тооцоо 3/ Алсын хараа-2050-д тусгагдсан зорилтуудын тооцоо. Эдгээрээс БХБСайдын 2021 оны хаварын хуралдаанаар Алсын хараа-2050-д тусгагдсан зорилтуудын хүрээнд ХАНСХЕТ-тай</p>

		<p>2. Хэрэв хүн амын тооцоондоо ХАНХЕТ-г баримталсан гэвэл дагуул хотуудын хүн амын зөрүүг тайлбар өгөх.</p> <p>3. 2040 оны УБ хотын эмэгтэйчүүдийн дундаж наслалт 81,07 байгаа нь Үндэсний статистикийн хорооны тооцсон улсын дунджаас (84)-аас 2,3 насаар дутуу байна. Мөн 2040 оны УБ хотын эрэгтэйчүүдийн дундаж наслалт 79,4 байгаа нь Үндэсний статистикийн хорооны тооцсон улсын дунджаас (80,4)-аас 1 насаар илүү байна. Монгол улсын өндөр хөгжилтэй, аз жаргалтай амьдрахад тааламжтай нийслэл хотын эмэгтэйчүүд яагаад улсын дунджаас доогуур наслах болсон шалтгааныг тайлбарлах</p> <p>4. Хүн амын есөлтийг "бодлогоор" зохицуулна гэсэн өгүүлбэр байх боловч ямар бодлого нь тодорхойгүй байна. Төрөлт нас, баралтын тоо тэнцүү байхаар гэр бүл төлөвлөнө гэсэн үг үү, эсвэл илүү гарсан хүмүүсийг дагуул хот болон орон нутаг руу шилжүүлэх бодлого хэрэгжүүлнэ гэсэн үг үү.</p>	<p>зөвшилцсөн 2 сая 89 мянган хүн ам гэсэн тооцоог баталсан. Батламжилсан хурлын протокол шийдвэрийг БХБЯ-аас авах боломжтой. Тиймээс манайх хүн амын хэтийн тооцоонд алсын хараа-2050 байхаар тооцсон ба УСХ-ны аливаа тооцооллыг БХБЯ-ам дэмжээгүй болно. Хүн амын тооцоо эцэслэсэн зөвшилцсөнөөр цаашид төлөвлөлт хийгдэх боломжтой болсон.</p> <p>2. Дагуул хотуудын хүн ам нь хуульд заасны дагуу улсын зэрэглэлтэй ба орон нутгийн зэрэглэлтэй хотуудын хүн амын минимум нөхцлийг хангасан байдлаар төлөвлөсөн манай зорилтот хүн ам юм.</p> <p>3. Монгол улсын дундаж наслалтын хэтийн тооцоо нь Алсын Хараа 2050-д дурдагдсаны дагуу 2030 онд 78 , 2040 онд 82 байна. Манай тооцоо нь зөвхөн Алсын хараа-2050-д заагдсан нөхцлөөр тооцогдсон. Манай байгууллагын тооцоолсон хэтийн тооцоог БХБСайдын ШУТ-ын зөвлөл, МАЭ-ын дэргэдэх мэргэжлийн зөвлөл болон 2021 оны 11 сарын 30-ний өдрийн эдийн засгийн магадлалын дүгнэлт баталгаажуулсан.</p> <p>4. Хүн амын есөлтийг бодлогоор зохицуулна гэдэг нь Монгол улсын төрөөс хүн ам зүйн талаар баримтлах бодлогыг Алсын хараа-2050-д нийцүүлж явуулсанаар УБ хот мөн түүнийг дагах, мөн МУЗГ-аас орон нутгийн хөгжлийг дэмжсэнээр шилжих хөдөлгөөний сөрөг урсгал үүсч УБ-с бусад сум суурингууд хөгжих нөхцөл бүрдсэн байхыг ойлгоно.</p>
<p><b>Эдийн засгийн төлөвлөлт</b></p>	<p>1. CGE (Computable General Equilibrium) загварын тавилыг 2021 онд боловсруулсан, 99 хувийн үнэмшилтэй байсан учраас тооцоог EXCEL рүү шилжүүлсэн гэх тайлбар нь учир дутагдалтай байна. Учир нь: Энэ загварын дагуу боловсруулсан албан ажлын хэрэгцээнд ашиглах зориулалттай программмын зохиогч, нэр мөн хувилбар (Version) -</p>	<p>2. CGE-г анхнаасаа Excel програм дээр хийсэн ба 2021 онд хийгдсэн 2019/2020 оны суурьтай тооцоо нь 2023 оны байдлаар 99.2% магадлалтай таарч байна. Тиймээс 2021-2023 оны зарим өөрчлөгдсөн нөхцлийг тусгаж загварыг үргэлжлүүлж тооцсон. Ингэхдээ 90 салбарын тоог 50 болгож 500 бараа үйлчилгээг 201 болгон</p>	

		<p>ыг дурдах, Олон улсын байгууллага, Монгол улсын Сангийн яаманд ашиглагддаг программ хамгийн өндөртөө 5-10 хувийн алдаа буюу 90-95 хувийн үнэмшилтэй байдаг. Ийм учраас олон улсын байгууллагууд жил бүр улс орнуудын эдийн засгийн өсөлтийг өөрөөр тооцон таамаглаж, дараа нь хагас жил болон гуравдугаар улирлын урьдчилсан дүнгээр өмнөх таамаглалаа залруулдаг. Монгол улсын Сангийн яамны хувьд мөн төсөөлөл гаргадаг бөгөөд үүндээ үндэслэн Төсвийн тухай хууль баталдаг. Монгол улсын түүхэнд эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 99 хувиар алдаагүй тооцогдож байсан жилүүд бараг үгүй бөгөөд энэ нь жил бүрийн төсвийн тодотголоор нотлогддог. 90 салбарын тоог 50 болгож 500 бараа үйлчилгээг 201 болгон бүдүүвчилсэн бол CGE загвар ашигласан тооцооллын алдаа нэмэгдэх нь математикийн хууль юм</p>	<p>бүдүүвчилсэн нь тус загварын алдаагүй болгож буй гол үндэс юм. Загварын тоон өгөгдлүүд буурвал алдааны магадлал нэмэгдэнэ гэж зохиогчын зүгээс үзэж байна. 2024 оны нөхцлөөс харахад алдаа багатай байгаа тул загварыг цаашид 90% алдаатай болох хүртэл нь багадаа 10 жил үргэлжлүүлэх шаардлагатай ба түүний дараа тооцоог засварлаж болох юм. Сангийн яамны зүгээс 2021 оноос эхлэн манай байгууллагатай адилханаар CGE модел руу шилжсэн ба тэдний их алддаг шалтгааныг цөөн нэр төрөл барааг түүвэрлэж авсанаас болсон байж магадгүй. Гэхдээ манай зүгээс Сангийн яамны ямар нэг тооцоог шүүмжлэх болон засварлахаар зааварлах шаардлагагүй гэж үзэж байна. CGE загварыг дараах шалтгаанаар сонгосон:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Алсын хараа-2050 нь энэ загвар дээр суурилсан тул нийцүүлэх зорилготой,</li> <li>▪ Монгол банк ба Сангийн яам хэрэглэдэг тул тэднийтэй нийцүүлэх зорилготой</li> <li>▪ ҮСХ-ний ДНБ тооцдог арга зүй 2015 оноос тус загварлуу шилжсэн тул нийцүүлэх зорилготой</li> <li>▪ 4 удаа нобель хүртсэн /ерөнхий тэнцвэр онол, салбар хоорондын тэнцэл, загварчлалууд - 1972, 1973, 1983, 2014/ онол дээр суурилсан загвар бөгөөд одоогоор дэлхий дээр ДНБ тооцдог</li> <li>▪ Төрөл бүрийн бодлогын нөлөөлөл оруулж хүлээгдэж буй үр дүнг урьдчилан тооцох боломжтой,</li> <li>▪ УБХЕТ-2020/2030 дээр тооцогдсон загвар нь маш өндөр алдаатай болсон тул өөрчлөх зайлшгүй шаардлагатай болсон, энэ тухай Мониторингийн тайланд дурдагдсан ба УБХЕТ-2020 хэрэгжилт хангалтгүй байсны шалтгааныг ЭЗ нөхцлийг бодит байдлаас зөрүүтэй тооцоолсоноос үүдэлтэйгээр алдаа дутагдал гарсан гэж үзсэн байдаг.</li> </ul>
--	--	---	---

		<p>1. Хотын эдийн засгийн тэргүүлэх чиглэл, бодлогын шийдэл, хүлээгдэж буй үр дүнг дахин нягтлах, эдийн засгийн тэргүү лэх чиглэлд багтах Нийслэл хотын хөгжлийн бодлогын хүрээнд Дэмжин хөгжүүлэх, хязгаарлах үйлдвэрлэл, үйлчил гээний салбаруудыг тодорхойлж, үе шатаар төлөвлөлтийн шийдлийг боловсруулах,</p> <p>2. Үйлдвэрийн салбарын хөгжлийг төсөөлбөл, 2023 онд 49 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан хотын үйлдвэрлэлийн салбар нь 2030 онд 63 их наяд, 2040 онд 110 их наядад хүрч өсөх болно. Салбарын бүтцийн хувьд Уул уурхайн салбар 64%-иас 32% болж буурах бол боловсруулах салбар 26%-иас 59% болж өсөх ба инженерийн үйлдвэрлэл тогтвортой байна. Нэмэлт тайлбар оруулах, мөн инженерийн үйлдвэрлэл гэж ямар салбар вэ?</p>	<p>1. Тэргүүлэх чиглэл нь Алсын хараа-2050-д дурдагдсаны дагуу байгаа ба төлөвлөлтөөр Хөдөө аж ахуй, бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба бусад бүтээгч үйлчилгээний салбаруудын хөгжлийн төсөөллийг нарийвчлан тусгасан.</p> <p>2. Бодит үйлдвэрлэл салбар буюу үнийн өсөлтгүй байх нөхцлийг дурдсан байна, нэмэлт тайлбар оруулаа. Боловсруулах салбарт бодлогын нөлөөлөл хэрэгжүүлж байгаа ба боловсруулах салбар өссөнөөр Уул уурхайн салбарын эзлэх хувийн жин буурах юм. Учир нь Уул уурхайн гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр 2040 он гэхэд өнөөгийнхөөс 60% унах төлөвтэй байгаа тул нийт ЭЗ-ыг татаж унагах аюултай байгаа. Бидний энэ тооцоонд хэлэх гэсэн санаа нь, боловсруулах салбарыг дэмжихгүй бол МУ-ын ЭЗ тэр дундаа УБХотын ЭЗ 2035-2040 онуудад бүрэн хямралд орж 2015-2018 онуудынх шиг зогсонги байдалд орохыг анхааруулахыг зорьсон болно, Инженерийн үйлдвэрлэлд : Цахилгаан + дулаан + УХАТ + Хог боловсруулах салбаруудыг оруулж тооцсон ЛСХ-ны баталсан ISIC 4.0 стандарт дагуу/</p> <p>3. Хүнсний хэрэглээний тооцоо нь Хүн амын хүнс тэжээлийн нормд дурдагдсаны дагуу дутагдалтай байгаа хүнсний дутагдалыг арилгах шийдэлтэй болно, энэ хүрээнд УБ хотын хөдөө аж ахуйг хөгжүүлэх төлөвлөлт нь хийгдсэн.</p>
<p><b>Эдийн засгийн хөгжил</b></p>	<p>1. УБ хотын ДНБ-ийг ам доллароор тооцон ирүүлсэн. Төлөвлөгөөг Монгол Улсын Их Хурал батлах учраас үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцсон хувилбарыг оруулах</p>	<p>1. Тэгэх боломжтой, Алсын хараа-2050-д төгрөгөөр биш ам.доллараар тооцсон байдаг тул адилхан дагасан. Гэхдээ бодит хэмжээгээр буюу 2023 оны суурь эсвэл бүр 2015 оны сууриар оруулах саналтай байна. Учир нь Алсын хараа-2050 дахь төгрөгөөр илэрхийлсэн тооцоо нь одоо</p>	
<p><b>Дотоодын нийт бүтээгдэхүүний хэтийн төлөв</b></p>			

		<p>2. ДНБ нь оны үнээр эсвэл зэрэгцүүлсэн үнээр тооцсон аль нь болох нь тодорхойгүй байгааг залруулах</p> <p>3. 2040 оны ДНБ 67.95 (тэрбум төг), 23.84 (тэрбум USD) гэж төлөвлөсөн байна. 2040 онд 1 ам долларын ханш 2850 төг болж төгрөгийн ханш 20 орчим хувиар чангарна гэж тооцсон уу</p>	<p>байгаагаас 400 их наядын мөнгөний нийлүүлэлт хийж ДНБ 512 их наяд хүргэж вальютын ханшийг 2.5 дахин унагаж 8 мянган төгрөгт хүргэх тооцоотой байгаа. Иймэрхүү тооцоо нь иргэдийг ихэд айлгах тул ам.доллараар болон бодит төгрөгөөр илэрхийлсэн тооцоотой байх саналтай байна</p> <p>2. Ам.долларт шилжүүлэхдээ нэрлэсэн дүнг хувааж шилжүүлнэ, бодит дүнг шилжүүлэхгүй, нэрлэсэн дүнг давхар бичих замаар ойлголтын зөрүүг залруулая, ханш 1\$=3400₮ байхаар тооцож байна</p>
	<p><b>Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн чиглэлээр</b></p>	<p>1. Эмээлт хотын нэр томъёоллыг Аргалант-Эмээлт хот гэж өөрч лөн найруулах. Тайлбар бичигт Эмээлт хот, Эмээлт Аргалант хот гэж 2 янзын бичиглэлтэй боловсруулагдсан байна. "Аргалант-эмээлт" хотын томъёоллоор боловсруулах саналтай байна.</p> <p>2. Шаргаморьт хотын суурьшлын бүсийн төлөвлөлт, Агро сити хотын суурьшилд тэргүүлэх чиглэлийн дагуу бие даасан дагуул хот бий болох хөгжлийн төсөөллийг нэмэлтээр судлан тусгах шаардлагатай байна. Агросити болон Шаргаморьтын суурьшилд хөгжлийн төлөвлөлт нь тайлбар бичиг болон зураглалд тодорхой тусгагдаагүй байна. Агроситигийн хөгжлийн хөшүүрэг нь эдийн засгийн тусгай бүс. Тайлбар бичигт хуучин 3 суурьшлын хэмжээнд нь авч боловсруулсан байна.</p> <p>3. Логистикийн 2 төв, тэр дундаа Зүүн бүсийн логистикийн төвийн төлөвлөлтийн Налуу- Ухаа эдийн засгийн тусгай бүстэй уялдуулж боловсруулах шаардлагатай. Улаанбаатар хотын төвлөрлийг задлах бодлого болон үйлдвэр аж ахуйн нэгжүүд ийг хотоос нүүлгэн шилжүүлэх бодлоготой Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулж боловсруулах шаардлагатай. "Налуу-Ухаа" эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагаа 2025 онд эхэлж байгаа учир тусгай бүсийн чиглэлийг дурдаж, тодорхой санал дэвшүүлж, оруулах</p>	<p>Саналын дагуу залруулан өөрчлөлтийг оруулав. УБХЕТ-2040 төслийн хураангуй, нэгдсэн болон салбарын тайланд тус тус тусгав.</p>

			<p>4. Улаанбаатар хотыг хүнсээр хангах зорилгод Агросити эдийн засгийн тусгай бүсийн хөгжил, ач холбогдлыг тусгаж өгөх</p> <p>5. 14 хотын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж баримт бичигт тусгах</p>	

**“НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

**АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ**

№	Нэр	Албан тушаал
1	Ж.Батсуурь	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны сайд
2	Х.Нямбаатар	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
3	С.Төмөрхүү	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
4	Ц.Баярбат	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга
5	Д.Бэлэгсайхан	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын Ахлах шинжээч
6	Ч.Төгсдэлгэр	Нийслэлийн Ерөнхий Архитектор
7	П.Хадбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Бодлого төлөвлөлийн газрын дарга
8	Д.Баялагцэнгэл	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хууль тогтоомж, эрх зүйн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
9	А.Баттөмөр	Хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга
10	Б.Оюунтуяа	Хот байгуулалт, хотын стандартын газрын Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга
11	Д.Адъяа	Хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны ахлах мэргэжилтэн
12	Ц.Мягмарсүрэн	Хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны ахлах мэргэжилтэн
13	С.Энхжаргал	Хот байгуулалт, хотын стандартын газрын Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтсийн Дагуул хотын хуулийн асуудал хариуцсан ажилтан
14	Р.Амартүвшин	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дарга
15	О.Одбаяр	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер
16	Л.Ганбат	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Зөвлөх архитектор
17	П.Энхболд	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Эдийн засагч
18	Т.Тэлмэн	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга
19	Б.Лхагвасүрэн	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Дэд бүтцийн хэлтсийн дарга
20	Д.Содномрагчаа	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Гамшгийн менежмент зөвлөх

21	С.Аригун	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Хог хаягдлын менежментийн зөвлөх
22	А.Цогт	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Дулаан хангамжийн зөвлөх инженер
23	Б.Мөнхбаяр	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Сэргээгдэх эрчим хүчний зөвлөх инженер
24	Г.Нансалмаа	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Инженерийн бэлтгэл арга хэмжээний зөвлөх инженер
25	Ж.Наранцэцэг	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Мэдээлэл холбооны зөвлөх инженер
26	Г.Сарайдамба	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Цахилгаан хангамжийн зөвлөх инженер
27	Б.Анхбаяр	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Авто замын зөвлөх инженер
28	Н.Намшир	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Авто замын зөвлөх инженер

# Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөнд санал авч байна

МОНГОЛЫН МЭДЭЭ | НИЙГЭМ



“НИЙСЛЭЛ  
ХОТОО ХАМТДАА  
ХӨГЖҮҮЛЬЕ”

ИРГЭН ТА  
САНАЛАА ӨГНӨ ҮҮ

09.29 - 10.29


WWW.ULAANBAATAR2040.MN

2040  
УЛААНБААТАР

Улаанбаатар /МОНЦАМЭ/. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд иргэдээс 10 дугаар сарын 29-нийг дуустал цахимаар болон харьяа хороогоор дамжуулан санал авч байна.

Нийслэлийн ирээдүйн 20 жилийн хөгжлийг тодорхойлох хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд иргэн бүрийн санал чухал юм. Иймээс иргэд харьяа хороон дээрээ очин, хэвлэмэл товч танилцуулгатай танилцаж, хорооны хэсгийн байцаагч, эсвэл зохион байгуулагчаас саналын хуудас авч бөглөн, саналаа өгөх боломжтой. Мөн цахимаар дараах зааварчилгааны дагуу саналаа өгч, нийслэлийн хөгжилд хувь нэмэр оруулахыг НЗДТГ-аас мэдээллээ.

Цахимаар [www.ulaanbaatar2040.mn](http://www.ulaanbaatar2040.mn) сайтаар дамжуулан санал өгөх боломжтой. Мөн QR код бүхий постерыг харьяа хороо, дүүргүүдэд байрлуулсан. Энэ QR кодыг гар утасны камераар уншуулахад веб сайт руу шууд нэвтрэх юм. [www.ulaanbaatar2040.mn](http://www.ulaanbaatar2040.mn) сайт руу нэвтрэн орсноор товч танилцуулга, санал өгөх, видео танилцуулга, дэлгэрэнгүй мэдээлэл гэсэн үндсэн цэс бүхий цонх гарч ирнэ.



Хөгжлийн  
Ерөнхий  
Төлөвлөгөө


Товч танилцуулга

Санал өгөх


Видео танилцуулга

Дэлгэрэнгүй мэдээлэл

Үүний санал өгөх гэсэн цэс рүү орсноор Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд санал өгөх хэсэг гарч ирнэ. Санал өгөхөөс өмнө хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлтэй танилцахын тулд "Товч танилцуулга үзэх" гэсэн холбоосыг дарж, товч танилцуулга хэсэг рүү шилжих, эсвэл гар утасныхаа камерыг нээн, QR кодыг уншуулснаар мэдээлэл авах боломжтой.



Товч танилцуулгыг уншиж танилцсаны дараа санал өгөх хэсэг рүү буцаж орно. Энд овог, нэрээ бичнэ. Мөн өөрийн байнга оршин суудаг дүүрэг, хороо, харгалзах насны ангиллаа сонгох юм. Өөрийн амьдарч буй орчинд 1-10 хүртэлх үнэлгээ өгнө. Нэг оноо муу гэсэн илэрхийлэл бол 10 оноо сайн гэсэн илэрхийлэл юм.



Үүний дараа амьдарч байгаа орчинд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлох зорилго бүхий нийгмийн тэгш хүртээмж, хот байгуулалтын асуудал, хүрээлэн буй орчны асуудал, аюулгүй байдал гэсэн дөрвөн бүлэг асуулт гарч ирнэ.

УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ИРГЭДИЙН САНАЛЫГ АВЧ БАЙНА

## Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд иргэдийн саналыг авч байна

Б.БИЛГҮҮН, IKON.MN

2021 ОНЫ 9 САРЫН 24

IKON.MN



Гэрэл зургийг MPA.mn

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой асуудлаар Нийслэлийн Хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Сүхбаатар мэдээлэл өглөө.

Тэрбээр "Улаанбаатар хот түүхэндээ зургаан удаа хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байсан. Тодруулбал, Улаанбаатар хотыг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй, урт хугацааны анхдугаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 1954 онд ЗХУ-ын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэсэн бөгөөд үүнээс хойш 1961, 1976, 1986, 2002, 2013 онд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2020 оны аравдугаар сараас эхлэн

боловсруулж, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, Шинжлэх ухааны академи, их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачдын дунд 1,200 гаруй хүнийг хамарсан цахим хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан юм. Үүнээс гадна Засгийн газрын яамд, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, зөвшилцөх үйл ажиллагаа үргэлжилж байна.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд иргэдээс санал авах ажлыг есдүгээр сарын 29-нөөс аравдугаар сарын 29-ны хооронд зохион байгуулна.

Иргэд Ulaanbaatar2040.mn веб хуудас болон Улаанбаатар 2040 фэйсбүүк, твитер, инстаграмм, ютүүб хуудсаар зэрэг цахим сүлжээний хэрэгслүүдээр Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн талаарх мэдээллийг авч, саналаа өгөх боломжтой. Мөн хороодын засаг дарга нар цаасаар санал ажлыг явуулна.

Ерөнхий төлөвлөгөөг энэ жондоо багтаж батлуулна" гэв.

#### Анхааруулга

*Хэвлэл мэдээллийн байгууллагууд (Телевиз, Радио, Social болон Вэб хуудаснууд) манай мэдээллийг аливаа хэлбэрээр бүрэн ба хэсэгчлэн авч ашиглахдаа эх сурвалжаа (ikon.mn) заавал дурдах ёстойг анхаарна уу!*



[← Буцах](#)

## Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд саналаа өгөөрэй



Б.Ирээдүй

6

2021-09-30



Улаанбаатар хотыг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй, урт хугацааны анхдугаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 1954 онд ЗХУ-ын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэсэн.

Үүнээс хойш 1961, 1976, 1986, 2002, 2013 онд гээд нийт зургаан удаа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан юм.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсноос хойш Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын архитектор, инженерүүд боловсруулж, Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолоор баталсан.

Тус ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад нийслэлийн хүн ам, эдийн засаг, газрын харилцаанд томоохон өөрчлөлтүүд гарсны улмаас тодотгол хийх шаардлага бий болж, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг **88%**

хандлага"-ын баримт бичгийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлуулж, нийслэлийн хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

Дээрх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжих хугацаа албан ёсоор дуусаж байгаатай холбогдуулан Улаанбаатар хот цаашид хэрхэн хөгжих вэ гэдгийг иргэд, олон нийт, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын оролцоонд тулгуурлан тодорхойлох үүднээс Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал боловсруулах нээлттэй уралдааныг зохион байгуулсан. Уралдаанд ирүүлсэн шилдэг, шинэлэг санаануудад үндэслэн үзэл баримтлал /концепц/-ыг боловсруулж, 2020 онд Монгол Улсын Засгийн газрын хурлаар хэлэлцүүлж дэмжсэн.

Тус үзэл баримтлалын дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2020 оны аравдугаар сараас эхлэн боловсруулж, төрийн бус байгууллага, Шинжлэх ухааны академи, их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаач 1200 гаруй хүнийг хамарсан цахим хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.

Үүнээс гадна яамд, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, зөвшилцөх үйл ажиллагаа үргэлжилж байна.

Хот байгуулалтын тухай хууль, "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ын дагуу Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд 2021 оны есдүгээр сарын 29-нээс аравдугаар сарын 29-ний хооронд нэг сарын хугацаанд иргэд, олон нийтээс санал авах юм.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын ирээдүйн 20 жилийн хөгжлийг тодорхойлох хариуцлагатай үйл ажиллагаанд иргэн таны санал, оролцоо нэн чухал юм. Иймд иргэн та <https://www.ulaanbaatar2040.mn/> вэб хуудас,

- Ulaanbaatar.mn
- Facebook
- Twitter
- Instagram
- Youtube зэрэг олон нийтийн цахим сүлжээний хэрэгслүүд болон харьяа хороогоороо дамжуулан Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн талаарх мэдээллийг авч, саналаа өгөөрэй.

Нэмэлт мэдээллийг 94442040 дугаарын утаснаас лавлана уу.

Post Like 6 Share